



МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН
САНААЧИЛГА

МОУИТБС-ЫН ТАЙЛАН 2018

2019 оны 12 дугаар сар



АГУУЛГА

1	Монголын ОУИТБС	5
1.1	Монгол улсын Засгийн Газрын үүрэг	5
1.2	Компанийн үүрэг оролцоо	6
1.3	Иргэний нийгмийн үүрэг оролцоо	7
1.4	Олон талт оролцогчдын бүлэг	7
1.5	Ажлын төлөвлөгөө	7
2	Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн салбарын хууль, эрх зүйн хүрээ.....	8
2.1	Хууль, эрх зүйн хүрээ.....	8
2.1.1	Олборлох үйлдвэрлэлийн салбарыг зохицуулж буй голлох хууль болон журам	8
2.1.2	Хууль, тогтоомжийн шинэчлэлт.....	15
2.1.3	Олборлох салбарт оролцоотой Засгийн газрын агентлагууд	17
2.2	Төсвийн дэг.....	19
2.2.1	Олборлох үйлдвэрлэлтэй холбоотой голлох хууль, тогтоомжууд	19
2.2.2	Хууль, тогтоомжийн шинэчлэлт.....	23
2.2.3	Олборлох салбарын татвар хүлээн авах үйл ажиллагаанд оролцоотой Засгийн газрын агентлагууд.....	23
2.3	Гэрээний болон тусгай зөвшөөрлийн хуваарилалт.....	24
2.3.1	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл явц	24
2.3.2	Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл олгох үйл явц	29
2.4	Тусгай зөвшөөрлийн бүртгэл.....	30
2.4.1	Уул уурхайн кадастрын бүртгэл.....	30
2.4.2	Бүтээгдэхүүн хуваах гэрээ	32
2.4.3	Уран.....	33
2.5	Гэрээний ил тод байдал.....	34
2.6	Бенефициар эзэд.....	37
2.6.1	Бенефициар эздийн замын зураг.....	37
2.6.2	Бенефициар эздийн тодорхойлолт	38
2.6.3	Бенефициар эздийн ил тодруулга.....	38
2.7	Төрийн оролцоо	39
2.7.1	Олборлох үйлдвэрлэл дэх төрийн оролцоонд мөрдөгдөх журам	39
2.7.2	Төрийн өмчит аж ахуй нэгжүүд	40
2.7.3	Засгийн газар болон ТӨААН-үүдийн хоорондын санхүүгийн харилцааг зохицуулсан үндсэн дүрэм журам.....	47
2.7.4	Засгийн Газар болон ТӨААН-үүдийн санхүүгийн харилцааг зохицуулах практик.....	47
3	Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ерөнхий тойм	49
3.1	Уул уурхайн салбар	49
3.1.1	Стратегийн ач холбогдол бүхий ордууд	49
3.1.2	Монгол Улсын ашигт малтмалын нөөц.....	50
3.1.3	Уул уурхайн хайгуулын ажил.....	50
3.1.4	Уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба экспорт	52
3.1.5	Экспортын хэсэг.....	53
3.1.6	Гар аргаар ашигт малтмал олборлох буюу бичил уурхай.....	55
3.2	Газрын тос болон байгалийн хий	57
3.2.1	Газрын тос болон байгалийн хийн үйл ажиллагааны тухай тойм.....	57
3.2.2	Газрын тосны нөөц.....	58
3.2.3	Газрын тосны олборлолт болон экспорт	59
3.2.4	Газрын тосны бүтээгдэхүүний орлого	60
3.3	Баяжуулах болон боловсруулах үйлдвэр	60
4	Орлогын төвлөрөл	61
4.1	Хамрах хүрээг тодорхойлох нь	61
4.1.1	Материаллаг байдлын босго үзүүлэлт.....	61
4.1.2	Компаниудын жагсаалт	63
4.1.3	Орлогын урсгалуудын жагсаалт	63
4.1.4	Төрийн байгууллагуудын сонголт	65
4.1.5	Компаниудын сонголт.....	65
4.2	Мэдээллийн цуглуулалт.....	66
4.2.1	2018 оны нэгтгэлд ашигласан маягууд	66
4.2.2	Задаргааны түвшин	66
4.2.3	Мэдээллийн чанар ба баталгаажуулалт	68
4.3	Нэгтгэлийн үр дүнд илрүүлсэн үндсэн асуудлууд	70
4.3.1	Гол үр дүн	70
4.3.2	Гол дүгнэлт.....	70
4.3.3	Нэгтгэл ажлын үр дүнгүүд.....	74
4.3.4	Тохируулаагүй зөрүүнүүд	86
4.3.5	УРАН	91
4.3.6	Нэг талаас тайлагнасан төлбөрүүд.....	92
4.4	ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН ТАЙЛАНГИЙН ГОЛ ТООНУУДЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ	93
4.5	Олборлолтоос төрд ногдох хувь хэмжээ болон бэлэн бус хэлбэрээр хүлээн авсан орлого.....	95
4.6	Дэд бүтцэд хөрөнгө оруулах болон бартерын солилцоо	96
4.7	Тээвэрлэлтийн орлого.....	96
4.8	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдтэй холбоотой гүйлгээ	96

5	Орлогын хуваарилалт	97
5.1	Төсвийн орлогын төвлөрүүлэлт ба хуваарилалт	97
5.2	Орлогын менежмент болон зарцуулалт	98
5.2.1	Монгол улсын төсвийн систем	98
5.2.2	Төсвийн хууль тогтоомжууд	99
5.2.3	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан	99
5.2.4	Ирээдүйн өв сан	101
5.2.5	Төсвийн тогтворжуулалтын сан	102
5.3	Төсвийн гүйцэтгэл, тайлагнал, аудитын цагалбар	102
6	Нийгэм, эдийн засгийн зарцуулалт	104
6.1	Олборлох салбарын компаниудын нийгмийн болон байгаль орчны зардал	104
6.2	Төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрүүд	105
6.3	Олборлох салбарын зүгээс эдийн засагт оруулж буй хувь нэмэр	105
6.3.1	Ерөнхий тойм	105
6.3.2	Олборлох үйлдвэрлэлээс төвлөрүүлэх Засгийн газрын нийт орлого	107
6.3.3	Эдийн засагт оруулж буй хувь нэмэр	107
6.4	Олборлох үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл	111
6.4.1	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар төрийн бодлого	111
6.4.2	Байгаль орчныг хамгаалах тусгай данс	112
6.4.3	2018 оны уулын ажлын болон нөхөн сэргээлтийн ажлууд	112
6.4.4	Ашигласан усны мэдээлэл	114
6.4.5	Хог хаягдлын мэдээлэл	115
6.4.6	Агаарын бохирдлын төлбөр	115
7	Өмнөх жилийн зөвлөмжийн хэрэгжсэн байдал	116
8	МОУИТБС-ын тайлагнал, түүний хэрэгжилтэд өгөх зөвлөмж	118

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

БУНДХ	Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
га	га талбай
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ХК	Хувьцаат компани
кг	килограмм
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХҮГ	Хөдөлмөр, нийгмийн халамж үйлчилгээний газар
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
Төг	төгрөг
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
ОТАХ	Олон талт оролцогчдын бүлэг
ТЕГ	Татварын ерөнхий газар
ҮАҮТ	2016-2018 оны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө
ЦЭК	Цөмийн энергийн комисс
ТББ	Төрийн бус байгууллага
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
шаард.	ОУИТБС-ын стандартын шаардлага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЖДААН	Жижиг дунд аж ахуйн нэгж
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
км	километр
Мян.барр	Мянган баррел
СЯ	Сангийн яам
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

1 Монголын ОУИТБС

1.1 Монгол улсын Засгийн Газрын үүрэг

2005 оны 10 дугаар сард, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаан дээр Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол улсад даган мөрдөхийг дэмжиж, Засгийн газарт энэхүү санаачилгад нэгдэхийг үүрэг болгосон. Засгийн газар 2006 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар ОУИТБС-ийг дагаж мөрдөхийг тунхагласан.¹

Харилцан ойлголцлын санамж бичигт ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд Засгийн Газар, олборлогч компаниуд болон иргэний нийгмийн гүйцэтгэх үүргийг тусгасан байдаг. Монгол Улсын засгийн газрын 2007 оны 04-р сарын 80-р тогтоолоор ОУИТБС дахь төрийн байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхойлсон бол 2010 оны 07-р сарын Монгол Улсын засгийн газрын 190-р тогтоолоор 2011 оны санхүүгийн жилээс эхлэн хэрэгжиж буй ОУИТБС-ын тайлангийн зардлыг санхүүжүүлэхийг Засгийн газарт даалгаж, ОУИТБС-ын ажлын хүрээнд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудаас хүлээн авсан бүх орлогоо олон нийтэд ил тод мэдээлэхийг улсын болон орон нутгийн төрийн байгууллагуудад үүрэг болгосон.

2012 оны 07-р сарын 04-ний өдрийн Монгол Улсын засгийн газрын 222 тоот тогтоолоор ОУИТБС-ыг зохион байгуулах, хянах үүрэг бүхий Үндэсний Зөвлөлийн бүрэлдэхүүнийг тогтоож, ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллүүдийг олон нийтэд ил тод болгохыг Засгийн Газрын агентлагуудад үүрэг болгожээ.¹

Үндэсний зөвлөл нь ОУИТБС-ыг Монголд хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулж, хяналт тавих бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан 30 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2007 оны 06-р сарын 20-ны өдрийн 62-р тогтоолоор ОУИТБС-ын өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий Ажлын албыг байгуулжээ.

Орон нутагт ОУИТБС-ын хэрэгжилтийг бэхжүүлэх зорилгоор 2013 оны 12-р сард “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх дэд зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”-ийг Үндэсний зөвлөл батлав. Энэхүү дүрэмд ОУИТБС-ын дэд зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны хэлбэр, удирдлага, тайлагнал, санхүүжилт болон бусад асуудлын талаарх удирдамжийг тусгасан болно². Улаанбаатар хот болон 21 аймаг тус бүрт нийт 22 дэд зөвлөл байгуулагдсан.

2006 оноос хойш Монгол улс ОУИТБС-н 13 удаагийн тайланг (2006-2018 онд) бэлтгэн гаргасан. ОУИТБС-ын тайланд хамрагдах төрийн байгууллага, олборлогч компаниудын тоо жилээс жилд нэмэгдэж байна. Доорх хүснэгтэд тайланд гарсан ахицыг харуулав:

Хамарсан хугацаа	Нийтлэгдсэн огноо	Хамрагдсан салбарууд	Нийт орлого (төгрөг)	Тайлан гаргаж буй компаниудын тоо
2006	2007 оны 12-р сар	Уул уурхай	492 тэрбум	137
2007	2009 оны 11-р сар	Уул уурхай	745 тэрбум	183
2008	2010 оны 06-р сар	Газрын тос, Уул уурхай	686 тэрбум	46
2009	2011 оны 06-р сар	Газрын тос, Уул уурхай	737 тэрбум	76
2010	2012 оны 01-р сар	Газрын тос, Уул уурхай	1,275 тэрбум	150
2011	2012 оны 11-р сар	Уул уурхай	2,150 тэрбум	200
2012	2013 оны 12-р сар	Газрын тос, Уул уурхай	1,594 тэрбум	200
2013	2014 оны 12-р сар	Газрын тос, Уул уурхай	1,576 тэрбум	250
2014	2015 оны 12-р сар	Газрын тос, Уул уурхай	1,579 тэрбум	236
2015	2016 оны 12-р сар	Газрын тос, Уул уурхай	1,592 тэрбум	202
2016	2018 оны 1-р сар	Газрын тос, Уул уурхай	1,318 тэрбум	213
2017	2018 оны 11-р сар	Газрын тос, Уул уурхай	2,358 тэрбум	230
2018	2019 оны 12-р сар	Газрын тос, Уул уурхай	2,889 тэрбум	202

ОУИТБС-ын стандартын дагуух Монгол Улсын анхны баталгаажуулалт 2016 оны 07 дугаар сарын 01-нд эхэлсэн. 2017 оны 01 дүгээр сарын 11-нд ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс Монгол Улс 2016 оны ОУИТБС-ын стандартыг хэрэгжүүлэхэд ихээхэн ахиц дэвшил гаргасан гэж дүгнэсэн бөгөөд найман залруулах арга хэмжээг санал болгожээ.

¹ Эх сурвалж: <http://www.eitimongolia.mn/en/resolution-of-government>

² Эх сурвалж: http://eitimongolia.mn/sites/default/files/uploads/OUITBS%20Ded%20zovloiin%20ulgerchilsen%20durem_20131223.pdf

Монгол улсын 2 дахь Баталгаажуулалт 2018 оны 01 дүгээр сарын 11 болон 2018 оны 02 дугаар сарын 13-нд эхэлсэн ба Монгол Улс нь ОУИТБС-ын стандартын бүх шаардлагыг хангаж байна гэж үнэлсэн. ОУИТБС-ын Олон улсын зөвлөлөөс анхны баталгаажуулалтаар тодорхойлсон ОУИТБС-ын хэрэгжилтэд гарсан дутагдлыг арилгах талаар гаргаж буй хүчин чармайлтыг магтан энэхүү шийдвэрийг гаргасан байна.

ОУИТБС-ыг Монгол Улсад хэрэгжүүлэх хүрээнд гарсан эрх зүйн баримт бичгүүд

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ашигт малтмалын тухай хууль (2006), Цөмийн энергийн тухай хууль (2009), Газрын тосны тухай хууль (2014), Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль (2014), Зөрчлийн тухай хууль (2017) болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017) зэрэг 6 хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтүүд орсон байна.

ОУИТБС-ыг нэвтрүүлэхтэй холбоотойгоор дараах төрийн бодлогын баримт бичгүүд батлагдсан байна, Үүнд:

- УИХ-ын тогтоолоор баталсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (2014)”-д ил тод байдлын болон хариуцлагатай уул уурхай, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ зэрэг олон улсын санаачилгыг дэмжин хөгжүүлэх,
- “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” (2016)-т олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах талаар тусган,
- Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2017)”-нд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах 6 төрлийн арга хэмжээг 2017-2023 оны хугацаанд 2 үе шатаар хэрэгжүүлэхээр төлөвлөжээ³.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 381 дүгээр тогтоолоор “Нээлттэй засгийн түншлэлийн 2 дахь шатны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө (2016-2018)”-г батлан байгалийн баялгийг ашиглах бенефициар эздийн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоол болон 2017 оны 263 дугаар тогтоолуудаар олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгожээ.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 190 дүгээр тогтоолоор олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хүрээнд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн орон нутгийн төсөвт төлж байгаа татвар, төлбөр, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагад хандивлаж байгаа мөнгөн болон мөнгөн бүс хөрөнгийн тайланг жил бүр гаргаж, нийтэд мэдээлж, тайлагнаж байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосон байна. Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах хамтын ажиллагааны гэрээний загвар, мөн 2015 оны 104 дүгээр тогтоолоор “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний загварыг баталсан байна.

1.2 Компанийн үүрэг оролцоо

Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.10-т заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг дараа оны 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Газрын тосны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-т заасны дагуу гэрээлэгч нь тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалт, гаргасан зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсний хэмжээг дараа оны 1-р улиралд багтаан холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх үүрэгтэй.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.10-т заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг дараа оны 01 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч нь Үндэсний зөвлөл болон ОТАХ-т уул уурхайн лиценз болон бүтээгдэхүүн хуваах гэрээтэй компаниуд, мэргэжлийн холбоодын төлөөллийг томилох үүрэгтэй.

³ Эх сурвалж: <https://www.iaac.mn/files/4347ff67-be17-4239-a929-bc5ebe4386c8/Засгийн%20газрын%202017%20оны%20%2014%20%20дүгээр%20тогтоолын%20хавсралт%202017.06.07.pdf>

1.3 Иргэний нийгмийн үүрэг оролцоо

Иргэний нийгмийн “Төлсөн Авснаа Нийтэл” эвсэл болон байгаль орчны Иргэний нийгмүүд нь Үндэсний зөвлөл болон ОТАХ-т өөрсдийн төлөөллийг томилох үүрэгтэй.

1.4 Олон талт оролцогчдын бүлэг

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7-р сарын 222 дугаар тогтоолоор ОУИТБС-ыг хэрэгжүүлэх зорилгоор “Олон Талт оролцогчдын бүлэг (ОТОБ)”-ийг байгуулсан бөгөөд уг тогтоолд мөн ОТОБ-ийн бүрэлдэхүүнийг нарийвчлан тусгасан байдаг. ОТАХ нь 34 гишүүнтэй бөгөөд Ерөнхий Сайдын ахлах зөвлөх ахалж ажилладаг.

ОТОБ нь 2017 оны 11-р сард “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн ажиллах журам” боловсруулан даган мөрдөж эхэлсэн⁴. Уг журамд ОТОБ-ийн үйл ажиллагааны чиглэлүүдийг дараах байдлаар тодорхойлсон байна:

- Олборлох үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжээс улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр болон улс, орон нутагт хүлээн авсан орлогын дүнг олон улсын жишигт нийцүүлэн хөндлөнгийн байгууллагаар тулгалт хийлгүүлж, тайлагнан ил тод байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлэх;
- Санаачилгыг хэрэгжүүлэх чиглэлээрх үйл ажиллагааны хүрээнд үндэсний семинар, зөвлөгөөн, сургалт, танилцах аялал, үзүүлэх сургууль, бусад арга хэмжээг зохион байгуулах;
- Санаачилгын зарчим, шалгуур, ач холбогдол болон хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар сурталчлах.

ОТОБ нь Засгийн Газар, компани, иргэний нийгмийн хамтарсан 3 талт оролцогчдоос бүрдэнэ. ОТОБ-ийн гишүүд нь дараах харьцаатай квоттой байна:

- Засгийн Газрын 10 төлөөлөл;
- Улсын Их Хурал, түүний харьяа байгууллагын 1 төлөөлөл;
- Ашигт малтмалын салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуд, мэргэжлийн холбоодын 9 төлөөлөл;
- Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээтэй компаниудын 2 төлөөлөл;
- Иргэний нийгмийн эвслийн 9 төлөөлөл;
- Байгаль орчны ТББ-ын эвслийн 2 төлөөлөл;
- ОУИТБС-ын Ажлын хэсгийн зохицуулагч.

ОТОБ-ийн ажиллах журамд дотоод засаглалын дүрэм, журмын талаар нарийвчилсан заалтуудыг оруулсан байна. ОТАХ нь аливаа шийдвэр гаргахдаа зөвшилцлийн механизмыг ашигладаг. Энэ зорилгоор аливаа асуудлыг боловсруулах, хэлэлцэхдээ оролцогч 3 талын оролцоог тэгш хангах зарчмыг баримтална. Санал зөрөлдвөл санал хураалт явуулж, асуудлыг шийдвэрлэж болно.

1.5 Ажлын төлөвлөгөө

ОУИТБС-ын хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, ОУИТБС-ын тайлангийн цар хүрээг өргөжүүлэх, зөрүүг илрүүлэх, тохируулах, тохируулагчийн зөвлөмжийг дагаж мөрдөх, санхүүгийн найдвартай эх үүсвэр бий болгох, ОУИТБС-ын улс төрийн хүсэл зориг, Иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, ОУИТБС-ыг орлогын хуваарилалт, тусгай зөвшөөрөл, байгал орчны нөхөн сэргээлтийн зардал, гэрээний ил тод байдал, Монгол Улсын ОУИТБС-ын чадавхыг нэмэгдүүлэх зэрэг зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын ОУИТБС-ын 2010-2014 оны дунд хугацааны стратегийг Үндэсний зөвлөлөөс 2010 оны 6-р сарын 24-ний өдөр баталсан. Энэхүү баримт бичгийн үндсэн дээр жилийн ажлын төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө боловсруулсан болно.

ОТАХ нь дараагийн жилийн ОУИТБС-ын хэрэгжилтийн зорилтыг тодорхойлох болон тухайн зорилгодоо хүрэх арга хэмжээний талаар нарийвчлан тооцсон ажлын төлөвлөгөөг жил бүр бэлтгэдэг.

2018 оны ажлын төлөвлөгөөг Монгол Улсын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлөөс 2017 оны 12-р сарын 21-ний өдрийн 16 дахь хуралдаанаараа баталсан. Энэхүү ажлын төлөвлөгөө нь дараахь үндсэн зорилгуудыг агуулдаг:

- ОУИТБС-ын баталгаажуулалт ба Монгол Улсын 2016 оны ОУИТБС-ын тайланд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх;
- Монгол Улсын ОУИТБС-ын 2017 оны тайлангийн бэлтгэх үйл явцыг сайжруулах, тайланг хэлэлцэн батлах;
- ОУИТБС-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой үр ашгийг үндэсний болон орон нутгийн түвшний оролцогч талуудад танилцуулж, сурталчлах, хамтын ажиллагааг сайжруулах; ба
- Бенефициар эзэмшигчдийг ил тод болгох талаар хууль эрх зүйн хүрээг бий болгох, мэдээллийн болон бүртгэлийн системийг сайжруулах.

⁴ Эх сурвалж: http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/Mongolia_EITI_MSWG_ToR_en_renewed_20171115.pdf

2 Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн салбарын хууль, эрх зүйн хүрээ

2.1 Хууль, эрх зүйн хүрээ

2.1.1 Олборлох үйлдвэрлэлийн салбарыг зохицуулж буй голлох хууль болон журам

Олборлох салбарыг зохицуулах голлох хуулиудыг дор жагсаав:

	<u>Уул уурхай</u> • Ашигт малтмалын тухай хууль, 2006 (2017 онд нэмэлт өөрчлөлт орсон ба 2018 шинэчлэн найруулсан) • Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, 2014 (2017 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) • Газрын хэвлийн тухай хууль, 1988 (2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) • Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, 2009 (2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) • Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2009 (2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) • Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, 2013 (2017 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)
	<u>Газрын тос & Байгалийн хий</u> • Газрын тосны тухай хууль, 2014 (2017 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) • Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, 2005 (2019 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) • Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 2006 (2017 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)
	<u>Цөмийн энерги</u> • Цөмийн энергийн тухай хууль, 2009 • Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2009
	<u>Байгаль орчин</u> • Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, 2010 (2018 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) • Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012 (2017 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) • Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хууль, 2012 (2019 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)

Монгол улсын олборлох үйлдвэрлэлийн салбарт хэрэгжиж байгаа эрх зүйн гол баримт бичгүүдийн зохицуулалтын тухай хураангуйлан танилцуулав.

2.1.1.1 Ашигт малтмалын тухай хууль, (2006)

УИХ-аас одоогийн Ашигт малтмалын тухай хуулийг 2006 онд баталсан. Уг хууль нь ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалуудыг хамардаг (элс, хайрга, шавар, боржин чулуу, бусад ижил төрлийн). Энэхүү хууль нь Монгол Улсын ашигт малтмалын нөөцөд оруулах хөрөнгө оруулалттай холбогдох горим, зохицуулалт болон ашигт малтмалыг эрэх, хайх, уурхайтай холбоотой байгаль орчныг хамгаалах зэрэг дүрэм, журмуудын үндсэн суурь болдог.

Уг хууль 11 бүлгээс бүрдэх ба ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг хадгалах нөхцөл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг болох зэргийг багтаасан ашигт малтмалын салбар дахь төрийн зохицуулалттай холбогдсон харилцааг зохицуулдаг. Мөн тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах болон дуусгавар болгох зэргийг багтаасан байдаг.

Ашигт малтмалын тухай хуульд 2018 болон 2019 онд байдлаар орсон өөрчлөлтүүдийг дараах хураангуй хүснэгтээс харна уу.

Зүйл. 26.12, Зүйл. 27.1.14, Зүйл. 49.13 (2018)	• Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд газар ашиглах эрхээ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу эрхийг улсын бүртгэлд бүртгүүлнэ. Ингэснээр ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авсан этгээдийн газар ашиглах эрх нь эрхийн улсын бүртгэлд бүртгэснээр үүсдэг болсон. • Мөн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх үүрэгт газар эзэмших эрхээ улсын бүртгэлд бүртгүүлсэн байх үүргийг нэмж оруулсан.
Зүйл. 47.6, 47.7, 47.10, 47.11, 47.12, 47.13, 47.14, 47.15, 49.12 (2019)	• Энэ хуулийн 47.3.1, 47.3.2, 47.4, 47.5-д заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журмыг Засгийн газар батална. • Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хүдэр, баяжмал, бүтээгдэхүүнд давхардуулахгүйгээр ногдуулна. • Монгол банк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээдээс бусад энэ хуулийн 47.1-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн ашигт малтмалд ногдох тухайн сарын төлбөрийг дараагийн сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайлангаар хийсэн эцсийн тооцоогоо дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор төсөвт төлнө. • Монгол банк, түүнээс эрх олгосон арилжааны банк нь энэ хуулийн 47.3.2-т заасан хувь хэмжээгээр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тушаасан алтны борлуулалтын үнэлгээнээс суутган авч, улсын төсөвт шилжүүлнэ. • Монгол банк, түүнээс эрх олгосон арилжааны банк нь энэ хуулийн 47.12-д заасны дагуу төсөвт шилжүүлсэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан, мэдээг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу дараа сарын 20-ны өдрийн дотор тус байгууллагад хүргүүлнэ. • Экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох олон улсын жишиг үнэ тогтоодог биржийн нэрийг тухайн бүтээгдэхүүний нэр төрлийг харгалзан Засгийн газар нийтэд зарлана. • Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу тогтворжуулах гэрчилгээ бүхий татвар төлөгчийн тухайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр ногдуулна. • Татварын ерөнхий хуулийн 6.1.48-д заасан эцсийн эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд энэ хуулийн 49.4.8-д заасан баримт бичгийг Татварын ерөнхий хуулийн 26.10, 26.11, 26.12-д заасны дагуу харьяа татварын албанд мэдэгдэнэ.
Зүйл. 47.3.3 (2019)	• Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн доод хэмжээг тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5.0 хувь болгон өөрчилсөн.
Зүйл. 56.1.5 (2019)	• Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцална.

2.1.1.2 Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль (2014)

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг УИХ-аас 2014 онд баталсан. Уг хууль нь хайрга, шавар, боржин чулуу, элсэн чулуу зэрэг түгээмэл тархацтай ашигт малтмалуудыг хамардаг бөгөөд хайгуул, олборлолтой холбоотой байгаль орчныг хамгаалах, хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой журмуудын үндсэн суурь болдог. Уг хууль 10 бүлгээс бүрдэх ба ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг хадгалах нөхцөл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах, тусгай зөвшөөрөл дуусгавар болох зэргийг багтаасан түгээмэл тархацтай ашигт малтмалын талаар төрийн зохицуулалттай холбоотой харилцааг зохицуулдаг.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11.2.5-д зааснаар аймаг, нийслэлийн засаг дарга өөрсдийн харьяа нутаг дэвсгэрт хамаарах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2.1.1.3 Газрын тосны тухай хууль (2014)

Газрын тосны тухай хуулийг шинэчлэн найруулж УИХ-аас 2014 оны 07 сард баталсан. Энэхүү хуулийг Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор шинэчилж найруулсан байна. Өмнөх үеүдэд батлагдсан гэрээнд өөрчлөлт ороогүй боловч шинэчлэгдсэн хууль нь газрын тос олборлогчдод тодорхой хөнгөлөлтийг үзүүлэхээр болсон. Уг хуульд зааснаар газрын тосны бүтээгдэхүүнийг 'газрын тос' болон 'уламжлалт бус газрын тос' гэсэн үндсэн хоёр төрөлд хувааж үздэг. Газрын тос гэдэгт боловсруулсан газрын тосноос гадна түүхий нефть, байгалийн хийг ойлгож болох ба харин уламжлалт бус газрын тос гэдэгт тослог элс, шатдаг занарыг ойлгоно.

Шинэчлэн найруулсан хуульд зонхилох газрын тосны үйл ажиллагаа, нэршлийн тайлбар, газрын тосны хайгуул болон олборлолтын талаар тодорхойлсон. Газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа болон уламжлалт бус газрын тос нь Газрын тосны тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрлийн журамд хамааралтай байдаг. Газрын тосны хадгалалт, тээвэрлэлт, судалгаа зэрэг бусад үйл ажиллагаанууд нь холбогдох төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсан байх шаардлагатай байдаг.

Шинээр олгосон газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа нь 8 хүртэл жил байх бөгөөд төрийн захиргааны байгууллага 2 хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно. Газрын тосны ашиглалтын хугацаа 25 хүртэл жил байх бөгөөд гэрээлэгч ашиглалтын хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тохиолдолд төрийн захиргааны байгууллага 5 хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно. Уламжлалт бус газрын тосны хайгуулын хугацаа 10 хүртэл жил байх бөгөөд уг хугацааг төрийн захиргааны байгууллага 5 хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.

Газрын тосны тухай хуулиар газрын тосны эрэл хийхээр төлөвлөсөн хуулийн этгээд нь АМГТГ-т хүсэлт гаргах үүрэгтэй байдаг. БХГ-нд оролцохоос өмнө эрэл хийж дууссан хуулийн этгээд нь гүйцэтгэлийн тайланг АМГТГ-т өгч дүгнэлт гаргуулах үүрэгтэй.

АМГТГ-тай БХГ-г байгуулсан хуулийн этгээдэд УУХҮЯ нь хайгуулын тусгай зөвшөөрлийг олгоно. Түүнчлэн, АМГТГ-ын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох заалтын дагуу БХГ хийх боломжгүй ч хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгарсан бол уг компанид хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдоно.

Газрын тосны тухай хуульд зааснаар гэрээлэгч нь газрын тосыг арилжаалах ажиллагааг эхэлсэн тохиолдолд газрын тосны зардлын нөхөн төлбөрийг авах боломжтой. Газрын тосны өртгийн хэмжээ нь тухайн жилд олборлосон нийт газрын тосноос нөөц ашигласны төлбөрт ногдох газрын тосыг хасаад үлдэх тосны 40 хүртэл хувь хамаарна. Хайгуул, ашиглалт, боловсруулалтын үед гарсан бүх зардлууд нь БХГ-ний заалтад дурдагдсан дүнгээр бүрэн хэмжээгээр нөхөн төлөгдөх боломжтой. Тус хуулийн 32 дугаар зүйлийн дагуу БХГ-ний хугацаа дуусгавар болох үед өртөг нөхөгдөх зардлын зарим хэсэг нь гэрээлэгчид олгогдохгүй ба энэ нь нөхөн төлөгдөхгүй үлдэх юм. Засгийн газар гэрээлэгчийн өртөг нөхөгдөх хуримтлагдсан зардалд хүү төлөхгүй.

2014 оны Газрын тосны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд нэмэлт журам болон БХГ-ний загварын гол заалтуудыг агуулсан. Засгийн газрын 2015 оны 104 тоот тогтоолоор газрын тосны хайгуул болон олборлолтын БХГ-ний загварыг баталсан. Энэхүү шинэ загварыг батлахтай холбоотойгоор гэрээний нууцлалын байдалд зарим өөрчлөлт оруулсан.

Газрын тосны тухай хуулийн 7.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд газрын тосны нөөц ашигласны төлбөр төлөх, хуваарилах, зарцуулах журмыг боловсруулж, Газрын тосны бүртгэл, тооцооны журмыг боловсруулахаар АМГТГ-аас томилогдсон Ажлын хэсэг ажиллаж байна.

2.1.1.4 Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль (2005)

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг УИХ-аас 2005 оны 7 сард баталсан. Энэ хуулиар газрын тосны бүтээгдэхүүнтэй холбогдох үйл ажиллагааны дэд ангилал (импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалт)-ыг тодорхойлсон. Газрын тосны бүтээгдэхүүн гэж газрын тос болон химийн нэгдлүүдийг боловсруулах замаар гарган авсан бүх төрлийн шатахуун, тусгай шингэн, шатдаг хий, тос тосолгооны материал, битум, мазут болон бусад бүтээгдэхүүнийг хэлнэ.

Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаанд газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл шаардлагатай. Харин тээвэрлэлт болон хадгалалтын үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл шаардлагагүй боловч Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, АМГТГ-аас гаргасан холбогдох дүрэм журмыг мөрдөх шаардлагатай.

Түүнчлэн, газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд 2013 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр газрын тосны бүтээгдэхүүнийг жижиглэн худалдаалах үйл ажиллагаанд нэмэлт тусгай зөвшөөрөл шаардах болсон. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд 2019 онд байдлаар орсон өөрчлөлтүүдийг дараах хураангуй хүснэгтээс харна уу.

Зүйл. 2.1, 9.2
(2019)

• Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалтын “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай” гэснийг “Хэмжил зүйн тухай” гэж өөрчилсөн.

2.1.1.5 Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль (2009)

УИХ-аас 2009 онд гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай гэсэн “үрт нэртэй хууль”-ийг баталсан. Уг хуулийн зорилго нь усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий тодорхой бүс нутагт ашигт малтмалын хайгуул болон уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглох болон тухайн газарт байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэхүү хуульд заасан хориг нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарахгүй.

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн заагийг Монгол Улсын Засгийн газар тогтоох бөгөөд заасан бүс нутагт ашигт малтмалын хайгуул болон уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Энэхүү хуулийн хүрээнд хайгуул болон ашиглалтын олон тооны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. “Урт нэртэй хууль”-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан уг хуулийг дагаж мөрдөх журам 2009 онд батлагдсан. Хуулиар хориглогдсон талбайд ашигт малтмалын ашиглалтын 576 тусгай зөвшөөрөл хамрагдаж, үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон.

Дээрх хуулийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд Засгийн газраас таван тогтоол баталсан. Хуулийг хэрэгжүүлэх явцад олон хүндрэлүүд гарч байна. Тухайлбал, хуулиар хориглосон талбайн хилийн зааг тогтоох, онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг хасуулах, энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулах гэрээ, тусгай зөвшөөрлийн төлбөртэй холбоотой асуудлуудыг дурдаж болно.

Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалттай бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтэд 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүнд:

- 2009 оноос эсвэл хууль батлагдахаас өмнө олгосон лицензийн хувьд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийг хүсч байгаа лиценз эзэмшигч нь үрт нэртэй хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш гурван сарын дотор АМГТГ-т хүсэлт гаргах ёстой. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам, АМГТГ, холбогдох аймгийн Засаг даргатай гэрээ байгуулах бөгөөд уг гэрээний загварыг Монгол Улсын Засгийн газраас батлуулах ёстой. Хуулийн дагуу Мэргэжлийн хяналтын байгууллага нь уг гэрээний биелэлтэд хяналт тавина. Тусгай зөвшөөрөл эзэмшигч үрт нэртэй хууль хэрэгжих бүс нутагт үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх хүсэлт гаргаж, шаардлагатай гэрээ байгуулаагүй тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, энэ тохиолдолд хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг цаашид уг хамаарагдах бүс нутагт ямар ч талд олгохыг хориглоно.
- Гол мөрний урсац бүрэлдэх эх газарт олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, тодорхой арга хэмжээ авах, түүний дотор уул уурхайн олборлолт эхэлсэн "ердийн" усны хамгаалалттай бүсэд байрлах тусгай зөвшөөрлийн бүсэд байгаль орчныг нөхөн сэргээх журмыг Засгийн газар батална (усны эргээс 200 метр зайтай). Энэхүү журам, гэрээнд төслийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалтай тэнцэх хэмжээний хөрөнгө байршуулах тухай заалтууд, мөн үүнд хяналт тавих үүрэгтэй төрийн албан тушаалтнуудын үүрэг, хариуцлага орно.
- Ойн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ойн тухай хуульд заасан тодорхой шаардлагыг хангаж байх ёстой. Хэрэв хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбай нь усны сав газрын энгийн хамгаалалтын бүстэй давхцаж байгаа бол тусгай зөвшөөрөл бүхий талбай нь ойн талбайтай давхцаж байвал энэхүү асуудлыг Усны тухай хууль, Ойн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.
- Хэрэв ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ашиглалтын талбайг сэргээгээгүй бол тухайн талбайг нөхөн сэргээх зардлыг ашиглалтын явцад олж авсан ашгийг харгалзан тусгай зөвшөөрөл эзэмшигч төлнө.

2.1.1.6 Цөмийн энергийн тухай хууль (2009)

Цөмийн энергийн тухай хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, хүн ам, нийгэм, байгаль орчныг ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна.

2.1.1.7 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай (2013)

Энэ хуулийн зорилт нь үйлдвэрлэлийн зориулалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих, тэдгээрийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангах, хууль бус хэрэглээг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулна.

2.1.1.8 Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль (2012)

Усны нөөцтэй холбоотойгоор “бохирдуулсны төлбөр”-ийн зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль нь аж ахуйн нэгж, байгууллагад усны нөөц бохирдуулсны төлбөр ногдуулах болон усны бохирдуулалтын хэмжээнээс хамааран усны бохирдуулалтын төлбөрийн дээд болон доод хэмжээг тодорхойлдог.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл сав газрын захиргаа ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяа татварын албанд зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэж авна.

Уг хуулийн дагуу ус бохирдуулсны төлбөр төлөгчийн гаргасан (i) хаягдал усны стандартад нийцүүлэн зөвшөөрсөн хязгаарын дотор байгальд шүүд нийлүүлж байгаа хаягдал ус, (ii) ариутгах татуургад нийлүүлэх бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд агууламжийн стандартад нийцүүлэн ариутгах татуургад нийлүүлж байгаа хаягдал усанд ус бохирдуулсны төлбөр ногдуулна.

Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд 2019 онд дараах нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан:

Зүйл. 4.3,
Зүйл. 4.4
Зүйл. 8.1.3
Зүйл. 4.2
Зүйл. 7.1
Зүйл. 7.3
Зүйл. 9.3
Зүйл. 4
(2019)

- Сав газрын захиргаа, эсхүл сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 4.2 дахь хэсэгт зааснаас бусад ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг сарын дотор гарган өгч, татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ” нэмж оруулсан.
- Ус бохирдуулагчийн талаарх мэдээлэлд төлбөр төлөгчийн нэр, хаяг, байршил, ус бохирдуулагчийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, үйл ажиллагааны чиглэл, хаягдал усны эзлэхүүн, хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ зэрэг татварын хяналтад шаардлагатай бусад үзүүлэлтийг тусгана.
- Хаягдал усыг цэвэрлэх байгууламж ашиглан хаягдал усны стандартын түвшинд хүртэл цэвэрлэж байгаа нь тогтоогдсон бол цэвэрлэх байгууламж суурилуулан ашигласан өдрөөс эхлэн гурван жилийн хугацаагаар ус бохирдуулагчийг төлбөрөөс чөлөөлнө.
- Сав газрын захиргаа, эсхүл сум, дүүргийн Засаг даргатай ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулсан хот, суурин газрын ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг хуулийн этгээд нь ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг сарын дотор гарган өгч, татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ.
- Төлбөрийн хэмжээг хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээнд үндэслэн дараах хязгаарт багтаан Засгийн газар тогтооно.
- Төлбөрийн орлогыг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэн, усны нөөцийг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт-шинжилгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ба орлогын 50-иас доошгүй хувийг цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээнд зарцуулна.
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “холбогдох” гэснийг “хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн” гэж, 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Улсын болон аймгийн зэрэглэлтэй хот” гэснийг “Хот” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэснийг “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад” гэж, 4 дүгээр зүйлийн “4.3” дахь хэсгийн дугаарыг “4.4” гэж, “4.4” дэх хэсгийн дугаарыг “4.5” гэж, “4.5” дахь хэсгийн дугаарыг “4.6” гэж тус тус өөрчилсүгэй.

2.1.1.9 Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль (2010)

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулиар агаар бохирдуулагч этгээдэд агаарын бохирдлын төлбөр ногдуулах, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Олборлосон түүхий нүүрс, үйлдвэрлэсэн болон импортолсон органик уусгагч, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл, агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт гаргах хаягдалд агаарын бохирдлын төлбөр /цаашид “төлбөр” гэх/ ногдуулна. Төлбөр ногдуулах органик уусгагчийн жагсаалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт бохирдуулах бодисыг бохирдуулах бодисын хаягдлын стандартад заасан хэмжээнээс хэтрүүлэн гаргасан тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны байцаагч, холбогдох сум, дүүргийн Засаг дарга учирсан хохирлыг арилгуулж, хохирлын хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр агаарын бохирдлын нөхөн төлбөр ногдуулан, төлөлтөд нь хяналт тавина (АБТТухай хуулийн 5.5).

Зүйл. 5.6
(2018)

- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийн “улсын төсөвт” гэснийг “Агаарын бохирдлын эсрэг санд” гэж өөрчилсүгэй.
Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2.1.1.10 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (2012)

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хууль нь 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан. Энэхүү хуулиар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна.

Энэхүү хуулийн дагуу уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан үс тэдгээрийн орчинд төлбөр ногдуулна гэж заасан байдаг ба уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усыг шоо метрээр усны нөөц ашигласны төлбөрийг тооцдог.

2.1.1.11 Бусад ерөнхий хуулиуд болон журмууд

Олборлох үйлдвэрлэлийн салбарын харилцааг зохицуулж буй бусад хууль, тогтоомжуудыг доорх хүснэгтэд үзүүлэв:

Хариуцлагын чиглэлийн	Бизнесийн харилцаа болон бизнесийн орчны чиглэлийн
- Аудитын тухай хууль, 1997, 2015 - Зөрчлийн тухай хууль, 2017 - Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017 - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 2015 - Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2012	- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001 - Захиргааны ерөнхий хууль, 2015 - Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013 - Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, 2015
Байгаль орчны чиглэлийн	Төсөв & Татварын чиглэлийн
- Байгаль орчныг хамгаалах хууль, 1995 - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 - Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012 - Газрын тухай хууль, 2002 - Газрын төлбөрийн тухай хууль, 1997 - Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, 2012	- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2006, 2019 - Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, 2008 - Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, 2017 - Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, 2012 - Ирээдүйн өв сангийн тухай хууль, 2016 - Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, 2006, 2015 - Татварын ерөнхий хууль, 2008 - Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2010 - Үл хөдлөх эд хөрөнгийн татварын тухай хууль, 2000 - Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, 2010

Олборлох үйлдвэрлэлийн салбарын харилцааг зохицуулж буй хуулиудыг багцлан тайлбарлав.

Захиргааны ерөнхий хууль (2015)

Эрдэс баялгийн салбарт төрийн захиргааны байгууллагатай хийх шаардлагатай хэд хэдэн төрлийн гэрээ байдаг. Тухайлбал, Хөрөнгө оруулалтын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Орд ашиглах гэрээ болон Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ зэрэг юм. Эрх зүйн зохицуулалтын дутагдалтай байдлаас шалтгаалан эдгээр гэрээг байгуулах үйл явц, түүний агуулга нь ихэнхдээ хаалттай байдаг. Угтаа эрдэс баялгийн гэрээнд ил тод байдал, олон нийтийн оролцоог хангах нь уг салбар дахь орлогын урсгалыг хянах, нийгмийн шударга ёсыг хангах, улмаар байгаль орчин, хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад чухал ач холбогдолтой.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль (2001)

УИХ-аас Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг 2001 оны 02 сард баталсан бөгөөд ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөлд мөрдөх горимыг тодорхойлох, зохицуулахад онцгой анхаарал хандуулсан.

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГ-аас авахаас гадна зөвшөөрөлд хамрагдах эдэлбэр газар харьяалагдаж буй аймгийн захиргаа нь тусгай зөвшөөрөл бүрийг батлах шаардлагатай. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хууль тогтоомж, дүрэм журмын мөрдөлтөд хяналт тавих геологи, уул уурхайн улсын хяналтын газар болон орон нутгийн захиргааны үүрэг, хариуцлагуудыг уг хуулиар тодорхойлсон.

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг зөвхөн Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулсан хязгаарлагдмал хариуцлагатай компани эсвэл хувьцаат компанид олгоно. Монгол Улсын иргэн эсвэл гадаадын иргэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчээр бүртгүүлэх эрхгүй.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд 2014 онд өөрчлөлт орсон бөгөөд уламжлалт болон уламжлалт бус газрын тосны хайгуул хийх болон ашиглах үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөлтэйгөөр хийгдэх бизнесийн ажиллагааны жагсаалтад нэмэгдсэн.

2.1.2 Хууль, тогтоомжийн шинэчлэлт

2.1.2.1 Одоогийн мөрдөж буй хууль, тогтоомжуудад орсон нэмэлт өөрчлөлтүүд

Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн давхардал, дутагдал, зөрчлийг арилгах болон хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх ажлын хүрээнд “Ашигт малтмалын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан хууль зүй, дотоод хэргийн сайд, уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар батлуулсан.

- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай,
- Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай,
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль,
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

2018 онд хэд хэдэн хуулийн төслүүдийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Уг хэлэлцүүлгийн дараа тухайн хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан. Хуулийн төсөлд дараах асуудлуудыг тусгасан:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,
- Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг хүчингүй болгох тухай,
- Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Тэсэрч, дэлбэрэх тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

2.1.2.2 Төрөөс эрдэс баялгийн салбарт 2025 хүртэл баримтлах бодлого⁵

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого нь хувийн хэвшилд түшиглэсэн, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хангахад чиглэнэ.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилго нь хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг бүрдүүлж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, дэвшилтэт техник, технологи, инновацыг дэмжих замаар ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд оршино.

Энэхүү бодлогын баримт бичиг нь төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах зарчим, хөгжлийн чиглэлийг тодорхойлж, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэх бөгөөд тэдгээр нь эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж, дунд, урт хугацааны хөтөлбөр, дэд хөтөлбөр, төсөлд тусгагдан хэрэгжинэ.

2.1.2.3 Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (2018-2027)⁶

“Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого”⁷-ын залгамж чанарыг хадгалан энэ салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хүний нөөц, үндэсний ажиллах хүчийг чадавхжуулах, мэргэшүүлэх шаардлагын үүднээс Засгийн газрын 2018 оны 6 сарын 6-ны өдрийн хуралдаанаар “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ыг хэлэлцэн Засгийн газрын 169 дүгээр тогтоолоор баталсан.

⁵ Эх сурвалж: <http://www.mmhi.gov.mn/public/file/id/28>

⁶ Эх сурвалж: <http://www.mmhi.gov.mn/public/file/id/374>, <http://www.mmhi.gov.mn/public/file/id/387> БОЛОН <http://www.mmhi.gov.mn/public/file/id/480>

⁷ Эх сурвалж: <http://www.mmhi.gov.mn/public/file/id/374>, <http://www.mmhi.gov.mn/public/file/id/387> БОЛОН <http://www.mmhi.gov.mn/public/file/id/480>

Энэхүү шинэчилсэн төрийн бодлогыг 2018-2027 онд 2 үе шаттай хэрэгжүүлнэ:

- I үе шат буюу 2018-2021 онд: газрын тосны салбарын бодлого, хууль эрх зүйн орчин боловсронгуй болгож, дэд бүтцийг сайжруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой газрын тосны компанийг байгуулах ажлыг эхлүүлснээр улсын нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өрсөлдөх чадвар дээшилнэ;
- II үе шат буюу 2022-2027 онд: стратегийн ач холбогдол бүхий газрын тосны салбарт эрэл, хайгуулын ажил эрчимжиж, газрын тосны нөөц, олборлолт нэмэгдэн боловсруулах үйлдвэр байгуулагдаж, хүний нөөцийн чадавх бэхжиж, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангах газрын тосны үндэсний аж үйлдвэрийн суурь бий болно.

Үүнээс гадна 2019 оны 8 дугаар сарын 08-ны өдөр Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны сайдын А/163 тоот тушаалаар “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх 2018-2027 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан. Уг төлөвлөгөөний дагуу дараах үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлнэ:

- Газрын тос, уламжлалт бүс газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлэх;
- Газрын тос боловсруулах үйлдвэрлэлийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах;
- Салбарын хүний нөөц, ажиллах хүч бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх;
- Газрын тосны салбарын үйл ажиллагааны үед байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон хөгжил, орон нутгийн хөгжлийг дэмжих;
- Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулж, хөгжүүлэх;

2.1.2.4 Алт-2 Үндэсний хөтөлбөр⁸

Засгийн газрын 2017 оны 1-р сарын 18-ны өдрийн 20 дугаар тогтоолоор батлагдсан “Алт-2” үндэсний хөтөлбөрийн гол зорилго нь Монгол Улсын алтны үйлдвэрлэлийн ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангаж алт олборлох, боловсруулах үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологи, менежмент нэвтрүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн үр дүнг сайжруулах, алтны үйлдвэрлэлээс эдийн засагт оруулах өгөөжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн чадавхыг өсгөхөд оршино.

- I үе шат /2017-2018 он, Алтны үйлдвэрлэлтэй холбоотой харилцаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох, геологийн судалгаа, эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлснээр алтны олборлолтыг нэмэгдүүлэх, бэлтгэгдсэн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хууль бусаар алт олборлох үйл ажиллагааг цэгцлэх ажлыг эхлүүлнэ/
- II үе шат /2019-2020 он, Алтны эрэл хайгуул хийх болон олборлох, үйлдвэрлэхэд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж алтны олборлолт, үйлдвэрлэлийг тогтвортой өсгөх, байгаль орчин, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх, хяналт, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ/.

2.1.2.5 Төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого⁹

Төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогын зорилт нь цацраг идэвхт ашигт малтмалын нөөц баялгаа гүнзгийрүүлэн судлах, түүнийг энхийн зорилгоор олборлогч, боловсруулагч, экспортлогч тэргүүлэгч орны нэг болох, улмаар цөмийн энергийг эдийн засаг, нийгмийн салбарт өргөн хүрээнд ашиглах, хүний эрүүл мэндэд аюулгүй, экологийн хувьд цэвэр, байгаль орчинд ээлтэй технологиор цөмийн эрчим хүч үйлдвэрлэхэд оршино.

2.1.2.6 Шинээр болон шинэчлэн хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, журам, зааврууд

Олборлох үйлдвэрлэлийн салбарт хэрэгжиж буй хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд 2018-2019 оны эхний хагас жилийн байдлаар шинэчилсэн болон шинээр гарсан журам, заавруудын талаар энд танилцуулав.

- Цацраг идэвхт ашигт малтмалыг олборлох, боловсруулах үйл ажиллагаанд мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм /Цөмийн энергийн комиссын 2018 оны 01 дүгээр тогтоол/
- Нөөц ашигласны төлбөр болон, тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам /Засгийн газрын 2018 оны 5 дугаар тогтоол/
- Газрын тос, уламжлалт бүс газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журам /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны А/50, А/31 тоот тушаал/
- Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавигдах шаардлагын төсөлд хийсэн нөхцөл байдлын дүн шинжилгээ /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/07 дугаар тушаал/,

⁸ Эх сурвалж: <http://www.mmhi.gov.mn/public/file/id/374>, <http://www.mmhi.gov.mn/public/file/id/387> болон <http://www.mmhi.gov.mn/public/file/id/480>

⁹ Эх сурвалж: <http://www.mmhi.gov.mn/public/file/id/374>, <http://www.mmhi.gov.mn/public/file/id/387> болон <http://www.mmhi.gov.mn/public/file/id/480>

- Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журмын төсөлд хийсэн нөхцөл байдлын дүн шинжилгээ /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/06 дугаар тушаал/,
- Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/08 тушаал/
- Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр /Засгийн Газрын 2019 оны 214 дүгээр тогтоол/
- Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам /Уул уурхай, хүнд үйлдвэрийн 2018 оны А/20 тоот сайдын тушаал/
- Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны а/19 тоот тушаал/
- Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоол /Улсын Их Хурлын 2018 оны 73 тоот тогтоол/

2.1.2.7 Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендерийн талаар баримтлах бодлого (2019-2026)¹⁰

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны сайдын тушаалаар “Эрдэс баялгийн салбарын жендерийн нөлөөллийн үнэлгээ” хийх ажлыг холбогдох судалгааны байгууллагаар гүйцэтгүүлсэн ба уг судалгаагаар бодлогын төлөвлөлт, хэрэгжилт, хяналт шинжилгээ, үнэлгээнд жендерийн асуудлыг тусгах арга зүйг салбарын хэмжээнд хангалтгүй гэж үзсэн ба товчоор үнэлгээний үр дүн нь дээрх дүгнэлт, зөвлөмжийг баталгаажуулж байна.

Дээрх судалгаагаар нөхцөл байдлыг тогтоон, цаашид геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендерийн талаар баримтлах бодлогыг тодорхойлж, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүрэг, өгөгдсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хангах, салбарын бусад бодлогын шинэчлэл, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулсан.

Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын бодлого, эрх зүйн орчныг жендерийн үзэл баримтлалтай болгон шинэчилж, байгаль орчин, хүний эрх, нийгэм, нөлөөллийн бүсэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, салбарын үр шимийг эмэгтэй, эрэгтэй хүмүүст тэгш хүртээх, гэр бүлд ээлтэй хөдөлмөрийн харилцааны орчин нөхцөлийг бүрдүүлэх, бүх хүрээнд хамтын ажиллагаа түншлэлийг хөгжүүлэх замаар жендерийн хэвшмэл ойлголт хандлагыг өөрчлөх, жендерийн эрх тэгш байдлыг хангах, жендерийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд энэхүү бодлогын зорилго оршино.

2.1.3 Олборлох салбарт оролцоотой Засгийн газрын агентлагууд

Уул уурхай, газрын тос, байгалийн хий, цөмийн энергийн салбарын үйл ажиллагааг зохицуулах, хянах, удирдах үүрэг хүлээсэн холбогдох төрийн байгууллагууд:

Засгийн газрын байгууллага	Веб хуудас
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)	www.mmhi.gov.mn
Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)	www.mrpam.gov.mn
Цөмийн энергийн комисс (ЦЭК)	www.nea.gov.mn
Сангийн яам(СЯ)	www.mof.gov.mn
Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)	www.mne.mn
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)	www.mlsp.gov.mn
Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ)	www.zasag.mn
Төрийн өмчийн, бодлого зохицуулалтын газар (ТӨБЗГ)	www.pcsp.gov.mn

2.1.3.1.1 Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)

УУХҮЯ нь уул уурхайтай холбоотой засгийн газрын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд ашигт малтмалын хайгуул болон олборлолтын журам батлах үүргийг хүлээж болно. Тус байгууллагын тэргүүлэх чиглэл бол ашигт малтмал, боловсруулалт, худалдаа болон экспортоор холбоотой бүхий үйл ажиллагааны хууль, эрх зүйн орчин, уул уурхайн салбарын бодлогоор дамжуулан эдийн засгийн хүчин чадлыг сайжруулах юм.

Мөн УУХҮЯ нь геологи, уул уурхай, газрын тос, түлш болон хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх эдийн засгийн үр ашиг, хууль эрх зүйн орчин, санхүүгийн чадавхыг сайжруулах зорилготой. Түүнчлэн УУХҮЯ нь дэвшилтэт технологи, шинэ санаачлалыг нэвтрүүлэх, нутагшуулах, шинэчлэх, үйлдвэрлэлийн технологийг хөгжүүлэх чиглэлээр ажилладаг.

¹⁰ Эх сурвалж: <http://www.mmhi.gov.mn/public/file/id/469>

2.1.3.1.2 Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)

АМГТГ-ын зорилго нь геологийн нөөцийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх болон геологийн нөөц ба үйл ажиллагааны удирдлагын бодлого, төлөвлөгөөг сайжруулах юм. Энэ нь геологийн нөөц, үйл ажиллагааны удирдлагын талаарх хууль тогтоомж, журам, арга хэмжээг боловсронгуй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах болон холбогдох хууль тогтоомж, журам, арга хэмжээг хянах, хэрэгжүүлэх замаар хийж байна.

Үүнээс гадна, АМГТГ нь геологи, ашигт малтмалын судалгаа, шалгалт, шинжилгээ, мэдлэгийг сайжруулах үйл ажиллагаануудыг явуулдаг. Түүнчлэн геологи, ашигт малтмалын чиглэлээр бусад улс орон, олон улсын байгууллагатай хамтран ажилладаг. АМГТГ нь байгалийн нөөцийн төлөв байдлын талаарх геологийн ойлголтыг өгөх зорилгоор ашигт малтмал, суурь ба хэрэглээний геологийн судалгаа, шинжилгээг хийх геологийн баримт хайх агентлаг юм.

2.1.3.1.3 Цөмийн энергийн комисс (ЦЭК)

Цөмийн энергийн комисс нь Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн технологийг ашиглах судалгааг боловсруулах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, хүн ам, байгаль орчныг ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Цөмийн энергийн комиссын үндсэн чиг үүрэг нь цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийг ашиглахтай холбогдсон Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; цөмийн байгууламж, материал, цацраг идэвхт ашигт малтмалын лиценз олгох, түдгэлзүүлэх; Монгол Улсын цөмийн энергийн салбарын эрдэм шинжилгээний судалгааны ажлыг зохицуулах, хянах; цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах юм.

Тус комисс нь Захиргааны алба, Цөмийн технологийн зохицуулах газар, Цөмийн аюулгүй байдлын зохицуулах газар, Гадаад харилцааны хэлтэс гэсэн дөрвөн хэлтэстэй хамтран ажилладаг.

2.1.3.1.4 Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)

БОАЖЯ-ны үндсэн чиг үүрэг бол байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар үндэсний бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах явдал юм. БОАЖЯ нь байгаль орчинд ээлтэй, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар тогтвортой орчныг хадгалан хамгаалах чиглэлээр ажилладаг. Түүнчлэн БОАЖЯ нь байгаль орчныг хамгаалахтай холбоотой тодорхой асуудлаар орон нутгийн захиргааны байгууллага, нийслэлийн захиргааны байгууллагын дагаж мөрдөх журам, бодлогыг батлах, шийдвэр гаргах үүрэгтэй.

Эрдэс баялгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл хүлээн авснаас 30 хоногийн дараа байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг БОАЖЯ-нд ирүүлэх ёстой. Цаашилбал, БОАЖЯ нь тухайн жилийн компаниудын байгаль орчныг хамгаалах төсвийн 50% -тай тэнцэх хэмжээний төлбөрийг хадгалж үлдэх үүрэгтэй байдаг. Компани байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөгөө бүрэн биелүүлээгүй тохиолдолд энэхүү санг БОАЖЯ нь холбогдох зориулалтаар ашиглаж болно.

2.1.3.1.5 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын газар (ХНХГ)

ХНХЯ-ны үндсэн үүрэг нь хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулах явдал бөгөөд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бодлогыг хэрэгжүүлэх, хөдөлмөрлөх таатай орчин бүрдүүлэх, мэргэжлийн үр чадварыг сайжруулах замаар хүний нөөцийг хөгжүүлэх явдал юм.

ХНХЯ нь хөдөлмөр эрхлэлт, ядуурлыг бууруулах, ажиллах нөхцөл ба амьжиргааны өртгийн асуудлыг сайжруулах, Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэдийн ажил эрхлэлтийн асуудал болон гадаад улсад хөдөлмөр эрхлэгчдийн асуудлыг зохицуулах үүрэгтэй. ХНХЯ-ны эрхэм зорилго нь хөдөлмөрлөх таатай орчин болон хөдөлмөрийн зах зээл дэх тэгш боломжийг бүрдүүлэх явдал юм.

2.1.3.1.6 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (ТӨБЗГ)

ТӨБЗГ-ын эрхэм зорилго нь бодлого боловсруулах, хэрэгжүүлэх болон төрийн өмчин удирдлагыг сайжруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, худалдан авах ажиллагааг олон улсын жишигт хүргэн, ил тод, өрсөлдөх тэгш боломжийг хангахад оршино.

ТӨБЗГ нь төрийн захиргааны хэлтэс, худалдан авалтын хэлтэс, төрийн өмчийн бүртгэл хяналтын хэлтэс, бодлого төлөвлөлтийн хэлтэс болон мэдээлэл технологийн хэлтсээс бүрддэг.

Энэхүү агентлаг нь төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа болон хувьчлалын ил тод байдлыг хангах үүрэгтэй.

2.2 Төсвийн дэг

2.2.1 Олборлох үйлдвэрлэлтэй холбоотой голлох хууль, тогтоомжууд

Монгол Улсын олборлох салбарын үйл ажиллагааг зохицуулахад дараах татварын хуулиуд голлох үүрэг гүйцэтгэж байна.



Татварын хуулиуд

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2006 (2019 онд шинэчлэн найруулсан)
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, 2015 (2019 онд шинэчлэн найруулсан)
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль, 2000
- Газрын төлбөрийн тухай хууль, 1997 (2019 онд 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан)
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, 2012 (2019 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, 2010 (2018 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)

2.2.1.1 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг Ашигт малтмалын хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт төлдөг. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон ашигт малтмалын борлуулалтын нийт дүн дээр үндэслэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлнө. Борлуулалтын дүнг доор дурдсаны адил бүтээгдэхүүн бүрээс шалтгаалан өөр өөр байдлаар тодорхойлдог.

- Экспортын бүтээгдэхүүн: Борлуулалтын үнэ гэдэг нь тухайн бүтээгдэхүүний эсвэл ижил төрлийн бүтээгдэхүүний сар тутмын дундаж үнэ бөгөөд энэ нь олон улсын зах зээл дээрх тогтмол үнэ эсвэл олон улсын худалдааны хүлээн зөвшөөрөгдсөн зарчим дээр тулгуурладаг.
- Дотоодын зах зээлд худалдаалах эсвэл ашиглагдах бүтээгдэхүүн: Борлуулалтын дүн нь тухайн бүтээгдэхүүний эсвэл түүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнэ юм.
- Зах зээлийн үнийг тодорхойлох боломжгүй олон улсын болон дотоодын зах зээл дээр худалдаалагдах бүтээгдэхүүн: Борлуулалтын үнэ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчээс зарласан бүтээгдэхүүний борлуулалтаас олсон орлого дээр суурилдаг.

Монгол Улсад борлуулж буй нүүрсний болон бусад түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь 2.5% байна. Бусад бүх ашигт малтмалаас зарж борлуулсан, ачуулсан эсвэл ашиглагдсан тохиолдолд 5 хувийн АМНАТ татвар ногдуулдаг. Татварын зорилгоор ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг суутгана.

Доорх хүснэгтэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах журмыг харууллаа¹¹.

Ашигт малтмалын төрөл	Жишиг түвшин	Нэмэгдэл түвшин
Нүүрс	- Дотоодын зах зээлд борлуулсан бол борлуулалтын орлогын 2.5% - Экспортод гаргасан бол 5%	- Түүхий нүүрс: жишиг болгож буй зах зээлийн үнийн 25 доллароос давсан тохиолдолд нэмэлт 25 долларын үнийн өсөлт тутамд 1%, хамгийн ихдээ 5% - Баяжуулсан нүүрс: жишиг үнэ тонн тутамд 100 доллароос давсан тохиолдолд 30 долларын үнийн өсөлт тутамд нэмэгдэл 0.5%
Монгол банк, түүнээс эрх олгосон банканд худалдсан алт	- Жишиг үнээр тооцсон борлуулалтын дүнгийн 2.5%: Жишиг үнэ: Монгол банк зарласан алтны үнэ	Алтыг зөвхөн эцсийн бүтээгдэхүүн байдлаар худалдсан бол, жишиг үнэ 900 доллар/унц давбал унц тутамд үнийн өсөлтөөс хамааран 0.5%-ийн нэмэгдэл АМНАТ тооцдог.
Зэс	- Жишиг үнээр тооцсон борлуулалтын дүнгийн 5%	- Хэрвээ зах зээлийн жишиг үнэ 5000 доллароос давбал зэсийн хүдрийн тонн тутамд нэмэлт 22-30%-ийн АМНАТ тооцдог (1000 долларын нэмэгдэл тутамд нэмэлт 2%-ийн) - Зэсийн баяжмалын тонн тутамд 11-15% нэмэгдэл АМНАТ тооцдог. - Зэсийн эцсийн бүтээгдэхүүний хувьд тонн тутамд нэмэлт 1-5%
Бусад малтмал	- Борлуулалтын дүнгийн 5%	- Жишиг үнэ тодорхой үнийн түвшний давбал 0.5%-5%-ийн хооронд нэмэгдэл АМНАТ-г тухайн бүтээгдэхүүний тонн тутамд зах зээлийн үнээс хамааран тооцдог.

¹¹ Эх сурвалж: https://www.mongolbank.mn/documents/press_conference/20190312_08.pdf

2.2.1.2 Татварын төрөл

Монгол улсын хувьд олборлох салбартай холбоотой улс болон орон нутгийн татвар, төлбөр, хураамжийн төрөл болон хүлээн авагч Засгийн газрын байгууллагууд дараах байдалтай байна.

Татварын урсгал	Төлбөр хүлээн авагч ЗГ-ийн байгууллага
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	Татварын Ерөнхий газар
Гаалийн албан татвар	Гаалийн Ерөнхий газар
Нэмэгдсэн өртгийн албан татвар	Гаалийн Ерөнхий газар, Татварын Ерөнхий газар
Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар	Гаалийн Ерөнхий газар
Автобензин, дизелийн түлшний албан татвар	Гаалийн Ерөнхий газар
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр	Татварын Ерөнхий газар
Ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	Ашигт малтмал, газрын тосны газар
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	Ашигт малтмал, газрын тосны газар
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	Хөдөлмөр, нийгмийн халамж үйлчилгээний газар
Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт нэмэгдүүлсний урамшуулал	Ашигт малтмал, газрын тосны газар
Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт эхэлсний урамшуулал	Ашигт малтмал, газрын тосны газар
Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд төлсөн сургалтын урамшуулал	Ашигт малтмал, газрын тосны газар
Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр	Ашигт малтмал, газрын тосны газар
Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх үүргээ шилжүүлэхэд төлсөн төлбөр	Ашигт малтмал, газрын тосны газар
Агаарын бохирдлын төлбөр	Татварын Ерөнхий газар
Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Нийгмийн даатгалын ерөнхий газар
Гаалийн үйлчилгээний хураамж	Гаалийн Ерөнхий газар
Төрийн өмчийн ногдол ашиг	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
Засгийн газарт төлсөн урьдчилгаа төлбөр	Сангийн яам
Цөмийн энергийн тухай хуулийн дагуу Засгийн газарт ногдох орлого	Цөмийн энергийн комисс
Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлого	Ашигт малтмал, газрын тосны газар
Торгууль	Татварын Ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
Нөхөн төлбөр	Татварын Ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	Орон нутгийн ЗДТГ
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	Орон нутгийн ЗДТГ
Газрын төлбөр	Орон нутгийн ЗДТГ
Ус ашигласны төлбөр	Орон нутгийн ЗДТГ
Ус бохирдуулсны төлбөр	Орон нутгийн ЗДТГ
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	Орон нутгийн ЗДТГ
Төрийн байгууллагад өгсөн мөнгөн, мөнгөн бус хандив, дэмжлэг	Яам, агентлагууд

Уул уурхайн салбарт хэрэгжиж буй татварын хувь хэмжээний өөрчлөлт нь уул уурхайн салбарын үйлдвэрлэл, мөн гадаад дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээнд шууд хамааралтай байдаг. Уул уурхайн үйл ажиллагаа нь татварын тогтолцоо болон бусад зохицуулалтаар дамжуулан уул уурхайн үүдэлтэй эдийн засгийн түрээсийг дахин хуваарилах боломжийг засгийн газарт олгодог.

Монгол Улсын Засгийн газраас 2018 онд Улсын Их Хурал (УИХ)-д өргөн барьсан шинэчлэн найруулсан Татварын ерөнхий хууль (ТЕХ), Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)-ын тухай хууль, Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ)-ын тухай хуулиуд болон Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар (НӨАТ)-ын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 3-р сарын 22-ны УИХ-ын ээлжит бүс чуулганы хуралдаанаар эцсийн байдлаар хэлэлцэн баталсан бөгөөд уг татварын багц хуулиуд 2020 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжинэ. Татварын шинэ багц хуулийн хүрээнд одоо хэрэгжиж буй хууль тогтоомжоос зарчмын хувьд ялгаатай, татвар төлөгчдөд нөлөөлөх маш олон тооны үндсэн өөрчлөлтүүд орсон тул татвар төлөгчид шинэ хуулийг мөрдөхийн тулд зохих арга хэмжээнүүдийг авч ажиллах шаардлагатай болсон.

2.2.1.3 Татварын ерөнхий хууль

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах, хөнгөлөх, чөлөөлөх, суутган тооцох, буцаан олгох эрх зүйн үндсийг тогтоож, Монголын Татварын алба, татвар төлөгч болон энэ хуулийн дагуу татварын албаны өмнө үүрэг хүлээсэн бусад этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд болон Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурал нэгтгэн хэлэлцэж 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр баталлаа.

Татварын багц хууль хэрэгжсэнээр олон улсын татварын шинэлэг зарчмууд нэвтэрч, татвараас зайлсхийх явдал бүрэн хаагдаж, татварын бааз суурь бэхжиж, бизнесийн өрсөлдөхүйц, таатай орчин бүрдэх болно. Татварын ерөнхий хуульд дараах гол нэмэлт, өөрчлөлтүүдийг багтаасан.

Зүйл. 15.1,
(2019)

- Татварын хяналт шалгалт хийх, нөхөн ногдуулалтын акт гаргах, алданги, торгууль ногдуулах хөөн хэлэлцэх хугацаа 4 жил болж өөрчлөгдсөн;

Зүйл. 38,
(2019)

- ЭЗХАХБ-ын үндсэн шаардлагын дагуу Үнэ шилжилтийн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлсон;

Зүйл. 53.2
Зүйл. 53.3
(2019)

- Татвар төлөгчийн хүсэлтээр татварын өр барагдуулах хугацааг 2 жил хүртэл сунгах боломжтой. Хугацаа сунгах хүсэлтийг гаргахдаа тодорхой хэмжээний санхүүгийн баталгаа гаргах шаардлагатай.

2.2.1.4 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль

Монгол Улсад татвар төлөгчдийг оршин суугч болон оршин суугч бус татвар төлөгч гэсэн хоёр тусад нь ангилдаг бөгөөд тус бүр нь өөр өөр орлогын үрсгалд хамаардаг. Оршин суугч бус аж ахуйн нэгжид Монгол улсын нутаг дэвсгэрт болон Монгол улсаас эх үүсвэртэй орлогод (жишээ нь: ногдол ашиг, хүү, АМНАТ болон бусад үйлчилгээний орлого) татвар ногдуулдаг.

Монгол улсад 3.0 тэрбум хүртэлх ашгаас 10 хувь, түүнээс дээш бол 25 хувь (Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн 17.1)-иар татвар авахаар байсан нь харьцангуй доогуур гэж тооцогдож болохоор байна.

2019 оны 3 дугаар сард шинэчлэн найруулсан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд дараах онцлох өөрчлөлтүүдийг багтаасан байна. Үүнд:

Зүйл. 20.1,
(2019)

- 6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж албан татвар ногдуулна.

Зүйл. 19.2,
(2019)

- Татварын тайлангаар гарсан алдагдлыг салбар харгалзахгүйгээр 4 жилийн хугацаанд шилжүүлэн тооцно.

Зүйл. 26.9
(2019)

- Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж нь энэ хуулийн дагуу тухайн татварын жилд тусгай зөвшөөрөл тус бүрд хамаарах татварын тайланг тус тус гаргаж, албан татварын тооцоо хийнэ.

Зүйл. 26.1,
Зүйл. 26.2,
(2019)

- Жилийн 6 тэрбумаас доош татвар ногдох орлоготой ЖДААН жилд 2 удаа, 6 тэрбумаас дээш орлого бүхий ААН жилд 4 удаа ААНОАТ-ын тайланг тайлагнана.

2.2.1.5 Нэмэгдсэн өртгийн албан татвар

Манай улс нэмэгдсэн өртгийн албан татварыг 1998 оны нэгдүгээр сард бий болгож, хуулийг 1998 оны долдугаар сарын 1-нээс мөрдөж эхэлсэн юм. Энэхүү хуулиар нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах үндсэн хувь хэмжээг 15 хувиар, экспортолсон бараа, ажил үйлчилгээ болон хуульд заасан тодорхой төрлийн бараа, ажил үйлчилгээнд ногдуулах нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээ “0” хувь байхаар заасан.

Хувь хүн, хуулийн этгээдийн Монгол Улсад импортоор оруулсан, эсхүл Монгол Улсаас экспортод гаргасан болон Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд албан татвар ногдуулахад энэхүү хууль үйлчилнэ.

2019 оны 3 дугаар сард нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд дараах онцлох нэмэлт, өөрчлөлтүүдийг багтаасан байна. Үүнд:

Зүйл. 14.1.5,
(2019)

- Худалдан авсан үндсэн хөрөнгөнд төлсөн НӨАТ-ын хасалтыг тухайн хөрөнгийн төрлөөс хамаарч дараах байдлаар зөвшөөрнө:
 - Барилга, байгууламж: НӨАТ-ыг 10 жил тэнцүү дүнгээр
 - Тоног төхөрөмж, хайгуулын үйл ажиллагаа: НӨАТ-ыг 5 жил тэнцүү дүнгээр
 - Бусад үндсэн хөрөнгө: Худалдан авсан жилдээ хасалт хийнэ

2.2.1.6 Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль

Энэ хуулийн зорилт нь гаалийн тариф, барааны үнэ, ангилал, гарал үүслийг тодорхойлох, гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Монгол Улсад экспортын болон импортын барааны гаалийн тарифыг хэрэглэх бөгөөд гаалийн тарифыг тогтоохдоо барааны код, нэр төрлийг Уялдуулсан системийн дагуу заана. Импортын барааны гаалийн тарифыг ердийн, нэн тааламжтай, хөнгөлөлттэй тариф гэж ангилах бөгөөд ердийн тариф нэн тааламжтай тарифаас хоёр дахин их байна. Хөнгөлөлттэй тарифыг олон улсын гэрээгээр тогтооно.

2.2.2 Хууль, тогтоомжийн шинэчлэлт

2.2.2.1 Одоогийн мөрдөж буй хууль, тогтоомжуудад орсон нэмэлт өөрчлөлтүүд

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сүмъяабазар 2019 оны 08 дугаар сарын 13-нд доорх хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.70-д заасан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийн төслийг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК хариуцан ажиллаж байгаа билээ.

Хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийн төслийн нийт төсөвт өртгөөс хэмнэсэн хөрөнгөөр газрын тосны үйлдвэрийн ажилчдын хотхоны бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх юм. “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор хотхоны бүтээн байгуулалтын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд шаардагдах бараа материал, тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөхөөр хуулийн төслийг боловсруулсан байна.

- Гаалийн албан татварын хөнгөлж, буцаах олгох тухай
- Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай

2.2.3 Олборлох салбарын татвар хүлээн авах үйл ажиллагаанд оролцоотой Засгийн газрын агентлагууд

Олборлох салбарт татвар хураах үйл ажиллагаанд оролцох Засгийн газрын байгууллагуудыг дор харуулав:

Засгийн газрын байгууллага	Веб хуудас
Татварын Ерөнхий газар (МТА)	www.mta.mn
Гаалийн Ерөнхий газар (ГЕГ)	www.customs.gov.mn

2.2.3.1.1 Татварын ерөнхий газар (МТА)

Татварын ерөнхий хуульд зааснаар Үндэсний татварын алба нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (ТЕГ), аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасаг, татварын улсын байцаагчаас бүрдэнэ. ТЕГ нь ЗГ-ын санхүүгийн асуудал хариуцсан байгууллага болох Сангийн Яамны харьяа байгууллага бөгөөд түүний удирдлагад ажилладаг.

Үндэсний татварын алба нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөлөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх үүрэгтэй.

2.2.3.1.2 Гаалийн ерөнхий газар (ГЕГ)

Монгол Улсын Гаалийн үйл ажиллагааг гаалийн төв байгууллага болох ГЕГ удирдан чиглүүлдэг бөгөөд түүний харьяанд аймаг, нийслэлийн гаалийн алба хамаарна. ГЕГ нь гаалийн хууль тогтоомжийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага бөгөөд Сангийн Яамны хяналт дор үйл ажиллагаагаа явуулдаг.

Гаалийн байгууллагын гүйцэтгэх үндсэн үүрэг нь гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт хийж гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх үүрэгтэй.

2.3 Гэрээний болон тусгай зөвшөөрлийн хуваарилалт

2.3.1 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

2.3.1.1 Тусгай зөвшөөрөл олгох үйл явцад оролцогч талууд

2018 оны 06-р сарын 21-ний шинэчилсэн найруулгаар Ашигт малтмалын тухай хуульд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой дараах онцлох зохицуулалтууд орсон байдаг. Үүнд¹²:

Хуулийн заалтын дугаар	Эрх, үүрэг бүхий талууд	Ашигт малтмалын тухай хуулиар олгогдсон эрх, үүрэг
8.1.5	Улсын Их Хурал	Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар тодорхой нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг, эсхүл хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг хязгаарлах буюу хориглох
9.1.11	Засгийн газар	Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хайгуулын болон энэ хуулийн 24.1-т зааснаас бусад тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох талбайг солбицлоор тогтоож, нийтэд мэдээлэх;
11.1.13	Төрийн захиргааны байгууллага, Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар томилогдсон Сонгон шалгаруулалтын комисс	Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион явуулах, бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох дүгнэлт гаргах
11.1.16	Төрийн захиргааны төв байгууллага, АМГТГ	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтийг өргөдлийг хүлээн авч бүртгэх
11.1.19	Төрийн захиргааны төв байгууллага, АМГТГ	Түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох
11.1.25	Төрийн захиргааны төв байгууллага, АМГТГ	Энэ хуулийн дагуу ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох боломжтой сонгон шалгаруулалтын талбайг солбицлоор тодорхойлох, батлуулах
20.1	Төрийн захиргааны төв байгууллага, АМГТГ	Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг энэ хуулийн 10.1.2-д заасан журмын дагуу зохион байгуулах
26.1	Төрийн захиргааны төв байгууллага, АМГТГ	Энэ хуулийн 25.1-д заасан өргөдлийг хүлээн авч, хянан, шийдвэрлэх

2.3.1.2 Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц нь өмнөх оныхтой ижил байна. Дараах хүснэгтээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үе шатуудыг харуулав¹³:

Үе шат	Эрх, үүрэг бүхий талууд	Үйл явц
1	АМГТГ	Өргөдөл гаргахаар бүртгүүлсэн этгээдэд дугаар олгож, өргөдөл хүлээн авна.
2	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Хүсэлтэд дурдсан талбайд ашигт малтмал эрэх, хайх боломжтой эсэхийг тогтооно.
3	Орон нутгийн засаг захиргаа	Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох хүсэлтийг аймгийн эсвэл хотын захиргаа руу 30 хоногийн дотор хариу авахаар хүргүүлэх бөгөөд хэрэв энэ хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд АМГТГ тухайн орон нутгийн засаг захиргааг уг саналыг зөвшөөрсөн гэж үзнэ.
4	АМГТГ	Тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг зөвшөөрөл хүсэгч ажлын 10 өдөрт багтаан төлнө.
5	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	АМГТГ нь хайгуулын тусгай зөвшөөрлийг 3-н жилийн хугацаатайгаар олгох бөгөөд дараа нь хайгуулын тусгай зөвшөөрлийг 3-н удаа тус бүр 3 жилийн хугацаатай сунгаж болно.

¹² Эх сурвалж: [Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга](#)

¹³ Эх сурвалж: [Ашигт малтмал газрын тосны газар \(АМГТГ\)](#)

2.3.1.3 Лиценз олгоход ашигладаг техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд

Доорх хүснэгтээр лиценз олгоход шаардагддаг техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг харуулав¹⁴.

Үе шат	Төрийн захиргааны төв байгууллага	Үйл явц
1	АМГТГ	АМГТГ нь нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж байгаа талаарх мэдээллийг өөрийн цахим хуудас болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гурваас доошгүй удаа зарлана.
2	АМГТГ	АМГТГ сонгон шалгаруулалтын материалыг 60 хүртэл хоног байх бөгөөд сонгон шалгаруулалтын эхний захиалга хүлээн авсан өдрөөс хойш тав хоногийн дотор захиалга хүлээн авах эцсийн хугацааг зарлана. Оролцогч нь дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд: - Эрх зүйн байдлыг нотлох баримт бичиг; (Улсын бүртгэлийн гэрчилгээ) - Хөрөнгө оруулагчийн танилцуулга; - Төлөөлөх хүний овог, нэр, албан тушаал, хаяг, утас, факсын дугаар, цахим хаяг, түүнд эрх олгосныг нотлох баримт; - Техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн чадварыг нотлох баримт бичиг; - Ажилд зарцуулах хөрөнгийн баталгаа; - Гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсөв; - Хуульд заасан хайгуулын талбайн захиалгын үйлчилгээний хөлс 20,000 ам доллар төлсөн баримт; - Оролцогч нь бизнесийн түншлэлтэй бол түүний хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, оролцох хувь, хэмжээ.
3	АМГТГ	АМГТГ нь өргөдлийг хүлээн авсан эсэх талаар ажлын таван өдрийн дотор оролцогчид бичгээр мэдэгдэнэ.
4	УУХҮЯ ба АМГТГ	Оролцогчийн талаарх мэдээллийг гэрээ байгуулах хүртэл гуравдагч этгээдэд задруулахгүй.
5	АМГТГ	АМГТГ нь дараах шалгуурыг үндэслэн Засгийн газар (ЗГ)-т хамгийн ашигтай санал ирүүлсэн оролцогчийг ялагчаар тодруулан сонгоно. Үүнд: - Ашигт газрын тосны Засгийн газарт ногдох хувь; - Нөөц ашигласны төлбөрийн хувь; - Өртөгт газрын тосны хязгаарын хувь; - Хайгуулын хөрөнгө оруулалтын хэмжээ; - Байгаль орчны нөхөн сэргээлтэд зарцуулах хөрөнгийн хэмжээ; - Сургалтын урамшууллын хэмжээ; - Гэрээнд гарын үсэг зурсны урамшууллын хэмжээ; - Олборлолт эхэлсний урамшууллын хэмжээ; - Олборлолт нэмэгдүүлсний урамшууллын хэмжээ; - Орон нутгийг хөгжүүлэх урамшууллын хэмжээ; - Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг - Засгийн газарт санал болгох бусад ашигтай нөхцөлүүд.

¹⁴ Эх сурвалж: Газын тосны тухай хууль, <http://www.legalinfo.mn/law/details/10484>

2.3.1.4 Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлэх үйл явц

Дараах хүснэгтээр хайгуулын тусгай зөвшөөрлийг ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлэх үе шатуудыг харуулав. Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд зөвхөн уг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргах эрхтэй.

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1	АМГТГ	Хүсэлт хүлээн авна.
2	АМГТГ-ын хуулийн хэлтэс	Хуулиар хориглосон зүйлс байгаа эсэх эсвэл барагдуулаагүй төлбөр байгаа эсэхийг тодорхойлно.
3	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Кадастрын системд хайгуулын тусгай зөвшөөрөл нь бүртгэгдэн эсэхийг шалгана.
4	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Ашиглалтын талбай нь бусад тусгай зөвшөөрлийн газар, усны нөөц, улсын тусгай хэрэгцээний газар болон нөөцөд авсан талбай зэрэг газруудтай давхацсан эсэхийг шалгана.
5	АМГТГ-ын Уул уурхайн болон Нүүрсний хэлтэс	Хүсэлт гаргагч нь олборлолтоос үүсч болох экологийн хохирлыг нөхөн сэргээх боломжтой эсэхийг шалгана.
6	АМГТГ-ын хуулийн хэлтэс	Хүсэлт гаргагч нь Кадастрын хэлтсийн даргын гаргасан төлөвлөгөө болон бусад хууль дүрэм журмуудыг дагаж мөрдөж буй эсэхийг шалгана.
7	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Координатаар тогтоосон талбайн зургийг зөвшөөрөх: АМГТГ нь өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 20 өдөрт багтаан зохих шийдвэр гаргаж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Хэрэв зөвшөөрөл олгохоос татгалзсан бол шалтгаан хуулийн үндэслэлийг дүрдсэн хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ.
8	АМГТГ	Мэдэгдэл авсан өдрөөс хойш 10 өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлнө.
9	АМГТГ-ын Кадастрын хэлтэс	Эхний жилийн төлбөрийг хуулийн дагуу хийснээс хойш ажлын 3 өдөрт багтаан ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаагаар олгох бөгөөд дараа нь ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2 удаа тус бүр 20 жилийн хугацаатай сунгаж болно.

2.3.1.5 Тусгай зөвшөөрлүүдийн хууль тогтоомж, дүрэм журам мөрдсөн байдал

2018 онд тусгай зөвшөөрлүүдэд гарсан хөдөлгөөнд үндэслэж хараат бус хянагч нэгтгэгч нь санамсаргүй байдлаар тусгай зөвшөөрлүүдийг түүвэрлэж, хууль тогтоомж, дүрэм журам мөрдсөн байдлыг үнэлсэн. Тайлант үед нэмж олгосон 3 тусгай зөвшөөрлүүд (MV-021120-001-NM, MV-021188-001-NM, XV-46000011-003-NM), цуцлагдсан 1 тусгай зөвшөөрөл (XB-013419-017-RN), шилжүүлсэн 1 тусгай зөвшөөрөл (XV-020952-003-TF), хүчингүй болгосон 1 тусгай зөвшөөрлийг (MV-020885-002-IN) санамсаргүй байдлаар сонгон авч шалгасан.

2018 онд нэмж олгосон MV-021120-001-NM тоот тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 2014 оноос хойш тусгай зөвшөөрлийн жилийн төлбөрийг төлөөгүй байсан. Тусгай зөвшөөрөл шилжүүлэх үйл ажиллагааны хувьд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанаас хяналтын шат дамжлага болон оролцогч талууд бага буюу АМГТГ-ын Кадастрын болон Хуулийн хэлтэс горимын ажлуудыг гүйцэтгэдэг. Ийм байдлаас шалтгаалан тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авч буй хуулийн этгээд нь тусгай зөвшөөрлийг анх авсан хуулийн этгээдэд тавигдаж байсан шалгууруудыг бүрэн хангаж буй эсэх талаарх хяналт харилцан адилгүй гэж дүгнэж болно. Бусад тусгай зөвшөөрлүүдэд өөр ямар нэгэн зөрчил илрээгүй.

2.3.1.6 Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журамд орсон 2018 оны өөрчлөлт

Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн УУХҮЯ-ны сайдын А/28 дугаар тушаалаар өөрчлөн баталсан. Шинэчилсэн найруулгад дараах онцлох өөрчлөлтүүд орсон. Үүнд:

Өмнөх заалт	Нэмэлт өөрчлөлт
Орон нутгийн тусгай хэрэгцээний газартай эсхүл хууль бүс олборлолтод өртсөн талбайтай сонгон шалгаруулалтын талбай нь давхцаж байвал тухайн газарт тусгай зөвшөөрлийг олгох хязгаарлагдмал сонгон шалгаруулалтад оролцох эрхийг орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд олгоно. (2017 оны шинэчлэн найруулсан журмын 1.6 дугаар заалт)	Заалтыг хүчингүй болгосон.
Сонгон шалгаруулалтын комиссын саналын эрхтэй гишүүдийн 70 ба түүнээс дээш хувийн ирцтэйгээр сонгон шалгаруулалт хүчин төгөлдөр болно.	80% болгон өөрчилсөн.
Техникийн саналыг арван өдөрт багтаан үнэлж, дүгнэлт гаргах.	5 өдөр болгож өөрчилсөн.
Комиссын нэгдсэн дүгнэлтийг Төрийн захиргааны байгууллагын даргад ажлын 2 өдөрт багтаан хүргүүлэх.	1 ажлын өдөр болгож өөрчилсөн.
Төрийн захиргааны байгууллагын дарга Комиссын нэгдсэн дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан холбогдох тушаал гаргах.	2 өдөр болгож өөрчилсөн.
Сонгон шалгаруулалтын журмаар олгогдсон тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээллийг төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудас дээр нийтэд мэдээлнэ.	Өдөр тутмын сонинд нийтэлнэ.

Ашигт малтмалын тухай хуульд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотойгоор дараах нөхцөлийг шинээр оруулсан:

- Сонгон шалгаруулалтыг тасралтгүй зохион явуулах, ачааллыг тэнцвэржүүлэх үүднээс 3 (гурав) хүртэл тооны сонгон шалгаруулалтын комиссыг томилж болох бөгөөд комиссын бүрэлдэхүүний 2/3-ийг хагас жил тутамд өөрчилж болно гэсэн заалтыг нэмж оруулсан.
- Техникийн саналд өгөх шалгуур үзүүлэлтүүдийг өмнөх журамд зааснаас илүү нарийвчлалтай, тодорхой зааж өгсөн.
- Техникийн саналыг 10 (арав) өдөрт багтаан үнэлж, дүгнэлт гаргах заалтыг 5 өдөр болгож, Комиссын нэгдсэн дүгнэлтийг Төрийн захиргааны байгууллагын даргад ажлын 2 өдөрт багтаан хүргүүлэх заалтыг 1 өдөр болгож, Төрийн захиргааны байгууллагын дарга Комиссын нэгдсэн дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан холбогдох тушаал гаргах заалтыг 2 өдөр болгон хугацааг богиносгосон байна.
- “Сонгон шалгаруулалтад оролцогчдоос ирүүлсэн техникийн болон үнийн саналууд, тэдгээрийг хэрхэн үнэлсэн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” “Төрийн захиргааны байгууллага нь Засгийн газраас тогтоосон талбайн солбицлыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэсэн заалтууд оруулснаар сонгон, шалгаруулалтын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулсан байна.
- 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн хайгуулын тусгай зөвшөөрлийг зөвхөн сонгон шалгаруулалтын журмаар олгодог болсон. (Эх сурвалж: Монгол улсын Их хурлын 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт буюу тус хуулийн 7.1 дүгээр заалт)

2.3.1.7 Тусгай зөвшөөрөл авах өргөдлийн статистик

Доорх хүснэгтээр тусгай зөвшөөрөл авахаар гаргасан өргөдлийн статистик мэдээллийг сүүлийн 5 жилээр харьцуулан харуулав¹⁵.

Өгөгдлийн төрөл	2014	2015	2016	2017	2018
Шинээр авах	113	2,522	113	288	226
Ашиглалтын	98	87	103	65	78
Хайгуулын	0	2,335	0	0	0
Сонгон шалгаруулалтын	15	100	28	223	148
Сунгуулах	453	249	173	231	657
Шилжүүлэх	53	92	139	153	157
Ашиглалтын	36	52	49	78	25
Хайгуулын	17	40	90	75	132
Барьцаалах	44	22	33	37	61
Ашиглалтын	40	22	30	32	58
Хайгуулын	4	0	3	5	3
Талбай буцаах	128	117	137	104	86
Ашиглалтын	12	24	26	14	12
Хайгуулын	116	93	111	90	74
Бүгд	791	3,002	613	813	1,187

2.3.1.8 2018 онд шинээр олгосон болон шилжүүлсэн тусгай зөвшөөрлүүд

АМГТГ-аас өгсөн мэдээлээр 61-н ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл, 5-н хайгуулын тусгай зөвшөөрөл олгож 173 тусгай зөвшөөрөл шилжүүлсэн байна. АМГТГ-ын олон нийтэд мэдээлсэн уул уурхай, геологийн статистик мэдээлэлд дараах байдлаар тусгагдан байна¹⁶.

Бүртгэлийн төрөл	2014	2015	2016	2017	2018
Шинээр олгосон	113	827	750	151	85
Ашиглалтын	97	91	93	77	61
Хайгуулын	2	697	629	41	5
Сонгон шалгаруулалтын	14	39	28	33	19
Талбай буцаасан	119	150	166	97	91
Ашиглалтын	13	25	25	13	11
Хайгуулын	106	125	141	84	80
Цуцалсан/Хүчингүй	123	173	241	237	181
Ашиглалтын	14	10	37	35	33
Хайгуулын	109	163	204	202	148
Дүүсгавар болсон	289	179	124	176	209
Шилжүүлсэн	51	88	146	136	173
Ашиглалтын	38	46	50	62	38
Хайгуулын	13	42	96	74	134
Сунгуулсан	444	336	167	162	566
Барьцаалсан	40	22	29	39	56
Ашиглалтын	34	22	27	34	53
Хайгуулын	6	0	2	5	3
Барьцаа чөлөөлсөн	29	24	16	39	27
Ашиглалтын	24	19	12	38	26
Хайгуулын	5	5	4	1	1
Нөхөн олгосон	11	19	35	26	40
Ашиглалтын	7	10	15	19	13
Хайгуулын	4	9	20	7	27

Шинээр олгосон болон шилжүүлсэн тусгай зөвшөөрлүүдийн жагсаалтыг “Хавсралт 16 в,г,ё”-ээс харна уу.

¹⁵ Эх сурвалж: [Эрдэс баялгийн статистик мэдээ 2018 он, Ашигт малтмал, газрын тосны газар \(АМГТГ\)](#)

¹⁶ Эх сурвалж: [Эрдэс баялгийн статистик мэдээ 2018 он, Ашигт малтмал, газрын тосны газар \(АМГТГ\)](#)

2.3.2 Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэх үйл явц нь Газрын тосны тухай хуулиар зохицуулагддаг.

Газрын тосны эрэл, хайгуул, олборлолттой холбоотой асуудлууд нь Монгол Улсын Газрын тосны тухай хуулиар зохицуулагддаг¹⁷.

2.3.2.1 Газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэх үйл явц

Доорх хүснэгтээр газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэх гол үе шатуудыг харуулав¹⁸.

Үе шат	Төрийн захиргааны төв байгууллага	Үйл явц
1	УУХҮЯ	УУХҮЯ-нд хүсэлт гаргана: - Бүтээгдэхүүн хуваах гэрээний хуулбар (БХГ) - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ - Тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө - Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулсан баримт.
2	УУХҮЯ	Хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох - Газрын тосны хайгуулын хугацаа найм хүртэл жил байх бөгөөд уг хугацааг хоёр хүртэлх жилээр хоёр удаа сунгаж болно. - Уламжлалт бүс газрын тосны хайгуулын хугацаа арав хүртэл жил байх бөгөөд уг хугацааг тав хүртэлх жилээр нэг удаа сунгаж болно. - БХГ-г байгуулсан өдрөөс хайгуулын хугацааг тооцно. - Ашигт малтмал газрын тосны газар (АМГТГ) нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

2.3.2.2 Газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Доорх хүснэгтэд газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үндсэн үе шатуудыг харууллаа:

Үе шат	Төрийн захиргааны төв байгууллага	Үйл явц
1	УУХҮЯ	УУХҮЯ газрын тосны нөөцийг хүлээн авах тухай шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гэрээлэгч ашиглалтын үйл ажиллагаа явуулах тухай хүсэлт гаргана.
2	УУХҮЯ	Ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад дараах бичиг баримтыг бүрдүүлж УУХҮЯ-нд ирүүлнэ. Үүнд: - Газрын тосны нөөц бүртгэсэн тухай УУХҮЯ-ны шийдвэр; - Тухай жид гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл; - Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө; - Ашиглалтын үеийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ; - Байр зүйн зураг ашиглалтын талбайн булангийн цэгүүдийн солбилцлыг тэмдэглэсэн зураг; - Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулсан баримт.
3	УУХҮЯ	УУХҮЯ нь ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

¹⁷ Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/10484>

¹⁸ Эх сурвалж: Газрын тосны тухай хууль, <http://www.legalinfo.mn/law/details/10484>

2.4 Тусгай зөвшөөрлийн бүртгэл

2.4.1 Уул уурхайн кадастрын бүртгэл

2018 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар АМГТГ-ын кадастрын цахим хуудсанд хүчин төгөлдөр байгаа 3,078 тусгай зөвшөөрлийн мэдээллийг нийтэд ил болгосон байна¹⁹. Харин ураны хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн мэдээллүүдийг оруулаагүй байна.

МОУИТБС-ын ажлын алба нь өөрсдийн цахим хуудсанд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг нийтэд ил болгодог. 2019 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 3,447 тусгай зөвшөөрлийн мэдээллүүдийг оруулсан байна.

Мөн цахим хуудасны “Ил тодын шигтгээ” цэсний хэсэгт 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх тусгай зөвшөөрлүүдийн статистик тойм мэдээллүүдийг харуулсан боловч мэдээллээ шинэчлээгүй байна. Мөн тус цэсний “Бүтээгдэхүүн, борлуулалт”, “Татвар төлбөр” гэх мэт мэдээллийн хэсгүүд нь 2012 оноос шинэчлэгдээгүй, мөн тус цахим хуудасны зарим хэсэг нь ажиллагаагүй байна.

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,888 компанийн 3,078 тусгай зөвшөөрөлтэй талбай дээр ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.

Дараах хүснэгтээр олборлох үйлдвэрлэлийн сүүлийн 3 жилийн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг харуулав.

Үзүүлэлт	2016	2017	2018
Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо	3,580	3,369	3,078
Ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо	1,558	1,624	1,673
Хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо	2,022	1,745	1,405
Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий талбай	13.5 сая га	10.7 сая га	8.7 сая га
Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай	1.4 сая га	1.6 сая га	1.6 сая га
Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай	12.1 сая га	9.1 сая га	7.1 сая га
Нийт нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөл бүхий талбайн эзлэх хувь	8.6%	6.8%	5.5%
Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн эзлэх хувь	0.9%	1.0%	1.0%
Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайн эзлэх хувь	7.7%	5.8%	4.5%

Тайлант оны жилийн эцсийн байдлаарх ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо, талбайн хэмжээ, аймаг, нийслэлээр ангилан дараах хүснэгтээр харуулав²⁰:


№	Ашиглалт				Хайгуул			Бүгд		
	Аймаг, нийслэл	Лицензийн тоо	Талбай /мян.төг/	Талбайн эзлэх хувь	Лицензийн тоо	Талбай /мян.төг/	Талбайн эзлэх хувь	Лицензийн тоо	Талбай /мян.төг/	Талбайн эзлэх хувь
1	Архангай	27	13.1	0.2%	10	60.5	1.1%	37	73.6	1.3%
2	Баян-Өлгий	27	12.9	0.3%	38	155.9	3.4%	65	168.8	3.7%
3	Баянхонгор	86	83.3	0.7%	77	340.7	2.9%	163	424.0	3.7%
4	Булган	70	35.6	0.7%	48	139.9	2.9%	118	175.5	3.6%
5	Өвөрхангай	29	15.7	0.2%	21	96.4	1.5%	50	112.0	1.8%
6	Говь-Алтай	50	89.1	0.6%	114	749.2	5.3%	164	838.3	5.9%
7	Говьсүмбэр	13	38.9	7.0%	4	19.8	3.6%	17	58.7	10.6%
8	Дархан-Уул	67	7.9	2.4%	12	6.1	1.9%	79	13.9	4.3%
9	Дорноговь	180	218.0	2.0%	206	1,330.2	12.2%	386	1,548.3	14.2%
10	Дорнод	75	62.7	0.5%	93	476.4	3.9%	168	539.1	4.4%
11	Дундговь	98	156.3	2.1%	114	624.7	8.4%	212	781.0	10.5%
12	Завхан	9	14.1	0.2%	60	395.7	4.8%	69	409.8	5.0%
13	Өмнөговь	100	515.2	3.1%	110	814.6	4.9%	210	1,329.7	8.1%
14	Орхон	9	11.1	13.2%	0	0.0	0.0%	9	11.1	13.2%
15	Сүхбаатар	62	48.9	0.6%	38	311.6	3.8%	100	360.5	4.4%
16	Сэлэнгэ	142	38.9	0.9%	48	67.8	1.6%	190	106.6	2.6%
17	Төв	302	149.7	2.0%	136	298.1	4.0%	438	447.8	6.1%
18	Увс	47	21.1	0.3%	93	429.9	6.2%	140	451.0	6.5%
19	Улаанбаатар	168	12.4	2.6%	12	1.4	0.3%	180	13.8	2.9%
20	Хөвсгөл	21	11.5	0.1%	7	7.7	0.1%	28	19.1	0.2%
21	Ховд	33	13.4	0.2%	80	306.2	4.0%	113	319.6	4.2%
22	Хэнтий	117	49.0	0.6%	132	435.0	5.4%	249	484.0	6.0%
Улсын хэмжээнд		1,673	1,618.5	1.0%	1,405	7,067.8	4.5%	3,078	8,686.4	5.5%

Тусгай зөвшөөрлүүдийн дэлгэрэнгүй жагсаалтыг “Хавсралт 16а,б -ээс харна уу.


¹⁹ Эх сурвалж: <https://cmcs.mrpm.gov.mn/cmcs>

²⁰ Эх сурвалж: [Эрдэс баялгийн статистик мэдээ 2018, УУХҮЯм, Ашигт малтмал, газрын тосны газар](#)

Хайгуулын болон ашиглалтын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлүүдийн тоо, сүүлийн 10 жилээр²¹:



Ашиглалтын тусгай зөвшөөрлүүд ашигт малтмалын бүтцээр²²:



2018 оны эцсийн байдлаар ашигт малтмалын 10 ба түүнээс дээш тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалтыг дараах хүснэгтээр харуулав²³:

№	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ	Хуулийн этгээдийн Ангилал	Хөрөнгө оруулагч улс
1	Чингис ворлд майнинг ХХК	49	155,335.7	Хамтарсан хөрөнгө оруулалттай ХХК	Монгол, Япон
2	Монголросцветмет ТӨҮГ	30	16,136.4	ХХК	Монгол
3	Монголын алт МАК ХХК	23	60,249.8	ХХК	Монгол
4	Алтандорнод монгол ХХК	19	69,331.6	Гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК	Виржиний Арлууд
5	Гацуурт ХХК	17	9,557.3	ХХК	Монгол
6	Цайна инвестмент монголиа ХХК	15	207,645.0	Гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК	Сингапур
7	Олон-Овоот гоулд ХХК	14	90,111.6	ХХК	Монгол
8	Гобикоул энд энержи ХХК	12	11,301.0	ХХК	Монгол
9	Хүннү говь алтай ХХК	12	2,206.7	ХХК	Монгол
10	Эрэл ХХК	11	10,996.6	ХХК	Монгол
11	МОЭНКО ХХК	10	12,807.4	Гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК	Сингапур
12	МАК Цемент ХХК	10	3,854.8	ХХК	Монгол

²¹ Эх сурвалж: [Эрдэс баялгийн статистик мэдээ 2018, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар](#)

²² Эх сурвалж: [Эрдэс баялгийн статистик мэдээ 2018, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар](#)

²³ Эх сурвалж: [Эрдэс баялгийн статистик мэдээ 2018, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар](#)

2018 оны эцсийн байдлаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий 100,000 ба түүнээс дээш гектар талбайг эзэмшигчдийн жагсаалтыг дараах хүснэгтээр харуулав²⁴:

№	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ	Хуулийн этгээдийн Ангилал	Хөрөнгө оруулагч улс
1	Цайна инвестмент монголиа ХХК	15	207,645.0	Гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК	Сингапур
2	Монгол ураниум ресурс ХХК	2	191,728.6	ХХК	Монгол
3	Чингис ворлд майнинг ХХК	49	155,335.7	Хамтарсан хөрөнгө оруулалттай ХХК	Монгол, Япон
4	Кожеговь ХХК	4	121,796.0	ХХК	Монгол
5	Монлаа ХХК	4	108,679.0	ХХК	Монгол

2.4.2 Бүтээгдэхүүн хуваах гэрээ

2017 онд “Жи Өү Эйч” ХХК-тай Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн № 265 дугаар тогтоолоор баталгаажуулсан байна.

2018 оны байдлаар БХГ байгуулсан компаниудыг харуулбал:

№.	БХГ талбай	БХГ хүлээн зөвшөөрсөн өдөр; ЗГ-н тогтоолын дугаар	Гэрээлэгч компаниуд	Гэрээлэгчийн улс
1	Тосон - Уул XIX Бүйр XXII	1993.04.26 1993.03.29 (дуусгавар болсон)	Петрочайна Дачин Тамсаг Петрочайна Дачин Тамсаг	Хятад Хятад
	Тамсаг XXI	1996.08.07	Петрочайна Дачин Тамсаг	Хятад
2	БХГ-1997	1997.02.19	Доншен газрын тос Монгол ХХК	Хятад
3	Матад XX	2006.07.19	Петро Матад ХХК	Монгол
4	Нялга XVI	2007.06.20	Шейман ресоурс	Канад
5	Цагаан - элс XIII	2009.05.20	Гоби Энержи партнерс	Швейцарь
	Зүүнбаян XIV	2009.05.20	Гоби Энержи партнерс	Швейцарь
6	Галба XI	2009.05.20	Зон Хэн Юу Тиан	Хятад
7	Сүлинхээр XXIII	2009.07.22	Шунхлай энержи ХХК	Монгол
8	Борзон VII	2014.08.20	Импайргаз Монголиа ХХК	Хятад
9	Хөхнүүр XVIII	2009.07.29	Эн Пи Ай ХХК	Хятад
10	Төхөм X (хойд) Цайдам XXVI	2009.07.29 2009.07.29	Сансарын геологи хайгуул ХХК Сансарын геологи хайгуул ХХК	Хятад Хятад
11	Богд IV Онги V	2009.07.29 2009.07.29	КапКорп Монголиа ХХК КапКорп Монголиа ХХК	Британийн Кайман арлууд Британийн Кайман арлууд
12	Баянтүмэн XVII	2010.12.08	Магнай трейд ХХК	Монгол
13	Дарьганга XXIV	2011.02.09	Монголиа шин ий энержи (Апекспро инвестмент Лтд)	Хятад
14	Төхөм X (урд)	2012.07.25	Монголын алт ХХК	Монгол
15	Сүхбаатар XXVII	2013.01.05	Вульф петролеум ХХК	Австрали
16	Номгон IX	2014.02.07	Өмнөд монголын газар нутгийн тос	Хятад
17	Увс I	2015.04.20	Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК	Хятад
18	Хэрлэнтохой XXVIII	2015.04.20	Монголиа Вэлпэк Индастриал	Хятад
19	Хар-ус II	2015.06.15	Ренова илч ХХК	Хятад
20	Арбулаг XXIX	2016.06.20	Макс Ойл ХХК	Монгол
21	Эргэл XII	2016.08.24	Смарт ойл Монголиа ХХК	Хятад

Хүчин төгөлдөр Газрын тосны тусгай зөвшөөрлийн жагсаалт “Хавсралт 16 н-ээс харна уу.

²⁴ Эх сурвалж: [Эрдэс баялгийн статистик мэдээ 2018, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар](#)

2.4.3 Уран

АМГТГ-ын ирүүлсэн мэдээллээр тайлант оны эцсийн байдлаар 4 компанийн нийт 9 уран Олборлолтын тусгай зөвшөөрөл, 8 компанийн нийт 14 ураны Хайгуулын тусгай зөвшөөрөл байсан. Тайлант онд ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд ураны нөөц нэмж бүртгэгдээгүй байна.

Доорх хүснэгтээс ураны хайгуулын лицензийн талаарх мэдээллийг харна уу.

Д/д	Жагсаалт	Аймаг	Талбайн нэр	Эзэмшигч	Эзэмшигчийн регистр #	
					Монгол	Гадаад (ГХО)
1	XV-014429	Сүхбаатар	Ухаа овоо	Кожеговь ХХК	Аревамонгол ХХК	
2	XV-014017	Сүхбаатар	Дунд нарт	Кожеговь ХХК	Аревамонгол ХХК	
3	XV-012251	Дорноговь	Богд уул	Кожеговь ХХК	Аревамонгол ХХК	
4	XV-011921	Дорноговь	Дулаан	Кожеговь ХХК	Аревамонгол ХХК	
5	XV-005359	Архангай	Далтын овоо	Нуклер Энержи Монголиа ХХК	Лайв Энержи Групп ХХК	
6	XV-005355	Архангай	Асар уул	Нуклер Энержи Монголиа ХХК	Лайв Энержи Групп ХХК	
7	XV-003367	Дорнод	Эрхт овоот толгой	Адамасмайнинг ХХК	МУ-ын иргэн Номундарь	Монголиа Рисорсис Инвестмент Лимитед, Yujiro
8	XV-007856	Дорноговь	Гарган толгой	Зараяа холдингс ХХК		Их Британи Виржини Арал Zaraiya Holdings ХХК
9	XV-009688	Төв	Энгэр ар	Лукрий ХХК		Сингапур Sreekmvar Pillai
10	XV-013082	Баянхонгор	Сэвсүүлийн булаг	Лукрий ХХК		Сингапур Sreekmvar Pillai
11	XV-012685	Дундговь	Хөх дэл	Алкали метал монголиа ХХК	Алкали Металс ХХК	
12	XV-018243	Дорноговь	Шувуун уул	Монгол ураниум ресурс ХХК	МУ-ын иргэн Бүрэн-Эрдэнэ	
13	XV-018247	Сүхбаатар	Хэрмийн цагаан өндөр	Монгол ураниум ресурс ХХК	МУ-ын иргэн Бүрэн-Эрдэнэ	
14	XV-018953	Хэнтий	Холбоо	Мончех ураниум ХХК	Мон-Атом ХХК	Ураниум Индастри ХХК

Доорх хүснэгтээс түүвэрт орсон компаниудын ураны ашиглалтын лицензийн талаарх мэдээллийг харна уу.

/д	Жагсаалт	Аймаг	Талбайн нэр	Эзэмшигч	Эзэмшигчийн регистр #	
					Монгол	Гадаад (ГХО)
1	MV-020634	Сүхбаатар	Өлзийт	Гурвансайхан ХХК	Мон-Атом ХХК	Denison Mines Mongolia
2	MV-020633	Дундговь	Чойр	Гурвансайхан ХХК	Мон-Атом ХХК	Denison Mines Mongolia
3	MV-020631	Дундговь	Гурвансайхан	Гурвансайхан ХХК	Мон-Атом ХХК	Denison Mines Mongolia
4	MV-020629	Дундговь	Хайрхан	Гурвансайхан ХХК	Мон-Атом ХХК	Denison Mines Mongolia
5	MV-018916	Дорноговь	Дулаан уул	Бадрах энерги ХХК	Аревамонгол ХХК, Мон-Атом ХХК	
6	MV-018915	Дорноговь	Зөөвч овоо	Бадрах энерги ХХК	Аревамонгол ХХК, Мон-Атом ХХК	
7	MV-018914	Дорноговь	Өмнөт	Бадрах энерги ХХК	Аревамонгол ХХК, Мон-Атом ХХК	
8	MV-000247	Дорнод	Улаан	Шинь Шинь ХХК		Грейт Промис Энтерпрайз
9	MV-020634	Дорнод	Мухар-1	Хунбөө ХХК	Шинь Шинь ХХК	Хятад

Хүчин төгөлдөр ураны тусгай зөвшөөрлийн жагсаалтыг “Хавсралт 16 и-ээс харна уу.

2.5 Гэрээний ил тод байдал

Монгол Улсад олборлох үйлдвэрлэлийн салбарт баримтлах бодлогын гол баримт бичигт ил тод байдал, хариуцлагын зарчмуудыг тусгасан, гэрээний ил тод байдлыг хангах, бүтээгдэхүүн хуваах гэрээний нууцлалын заалтыг арилгах чиглэлээр хэд хэдэн арга хэмжээ авсан.

Гэрээний ил тод байдал нь Монгол Улсад хэд хэдэн хууль тогтоомжуудаар зохицуулагдах. Доорх хүснэгтэд гэрээний ил тод байдал, тэр дундаа олборлох салбарт хамаарах хууль эрх зүйн үндсэн заалтуудыг харуулав²⁵:

Хууль тогтоомжийн нэр	Гэрээ, түүний ил тод байдалд холбогдох зүйл заалт
Хууль	
Монгол Улсын Үндсэн хууль	6.1-р зүйл: Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна. 6.2-р зүйл: Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн. 16.17-р зүйл: Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задрүүлж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.
Ашигт малтмалын тухай хууль	5.3-р зүйл: Улсын төсвийн хөрөнгөөр эрэл, хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тухайн ордыг ашиглах гэрээгээр тодорхойлно. Уг гэрээгээр тогтоосон төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно. 5.4-р зүйл: Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ 50 хүртэл хувьтай байж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно. Уг гэрээгээр тогтоосон төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно. 5.5-р зүйл: Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно. Уг гэрээгээр тогтоосон төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно. 42.1-р зүйл: Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.
Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль	40-р зүйл: Улсын төсвийн хөрөнгөөр хайгуулын ажил хийж, нөөцийг нь тогтоон ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газарт олборлолт явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу хайгуулын ажилд улсын төсвөөс гаргасан зардлыг олборлолт явуулж эхэлсэн хугацаанаас эхлэн гэрээний үндсэн дээр улсын төсөвт буцааж нөхөн төлнө.
Газрын тосны тухай хууль	12 дугаар зүйл. Гэрээг цуцлах 12.1. Бүтээгдэхүүн хуваах гэрээг доор дурдсан үндэслэлээр Засгийн газрын шийдвэрээр цуцална: 12.2. Гэрээлэгч газрын тос, уламжлалт бүс газрын тосны ашиглалт явуулах нь эдийн засгийн үр ашиггүй гэж үзсэн, эсхүл онц байдал, давагдашгүй хүчин зүйл нэг ба түүнээс дээш жил үргэлжилбэл гэрээг цуцлах хүсэлтээ төрийн захиргааны байгууллагад хүргүүлж болно. 12.3. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 12.2-т заасан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дүгнэлт гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад хүргэнэ. 12.4. Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 12.3-т заасан дүгнэлтийг 30 хоногийн дотор хянан үзэж, холбогдох саналыг Засгийн газарт хүргүүлнэ. 12.5. Энэ хуулийн 12.1-д заасан үндэслэлээр бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцалсан тохиолдолд хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг нөхөж олгохгүй бөгөөд энэ хуулийн 11.2.9-д зааснаар эс克罗у дансанд байршуулсан мөнгийг байгаль орчныг бүрэн гүйцэд нөхөн сэргээх, шаардлагатай тохиолдолд хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгахад зарцуулж, үлдсэн мөнгийг гэрээлэгчид буцаан олгоно. 13 дугаар зүйл. Гэрээний биелэлтийг дүгнэх 13.1. Гэрээний хугацаа дуусгавар болсон, эсхүл энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан үндэслэлээр гэрээг цуцлах тохиолдолд төрийн захиргааны байгууллага гэрээний биелэлтийг дараах үзүүлэлтээр дүгнэнэ: 13.2. Төрийн захиргааны байгууллага гэрээний биелэлтийг дүгнэхдээ холбогдох төрийн байгууллагын төлөөллийг оролцуулна. 13.3. Гэрээг хангалттай биелүүлсэн гэж дүгнэсэн бол энэ хуулийн 11.1.4-т заасан эрх үүснэ. 14 дүгээр зүйл. Гэрээлэгч эрх, үүргээ бусдад шилжүүлэх 14.1. Гэрээлэгч бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг бүхлээр нь, эсхүл гуравны нэг буюу түүнээс дээш хувийг Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр шилжүүлэх эрхгүй. 14.2. Гэрээлэгч бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийн гуравны нэг буюу түүнээс дээш хувийг бусдад шилжүүлэх тохиолдолд хүсэлтийг төрийн захиргааны байгууллагад гаргана.

²⁵ Эх сурвалж: <http://www.iltodgeree.mn/legal/3/detail>

Хууль тогтоомжийн нэр	Гэрээ, түүний ил тод байдалд холбогдох зүйл заалт
Газрын тосны тухай хууль(үргэлжлэл)	14.3.Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 14.2-т заасан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дүгнэлт гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад хүргэнэ. 14.4.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 14.3-т заасан дүгнэлтийг хянан үзээд 30 хоногийн дотор Засгийн газарт саналаа хүргүүлж, холбогдох шийдвэр гаргуулна. 14.5.Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэх тохиолдолд гэрээлэгч, төрийн захиргааны байгууллага болон гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авч байгаа этгээдийн хооронд гурван талт гэрээ байгуулна. 14.6.Гэрээлэгч бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийн гуравны нэг буюу түүнээс дээш хувийг шилжүүлэх Засгийн газрын шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 34.7, 34.8-д заасан төлбөрийг төлнө. 14.7.Гэрээлэгч болон гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авч байгаа этгээд эрх, үүрэг шилжүүлэхэд төлсөн төлбөрийн хэмжээг шударгаар мэдээлнэ. 14.8.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 14.3-т заасан дүгнэлт гаргахдаа хайгуул хийсэн хугацаанд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ бүрэн биелүүлсэн эсэх талаарх байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн нутгийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг харгалзан үзнэ.
Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль	Уг хууль бүхэлдээ хамаарна.
Төрийн бодлого	
Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого	3.1.7. Ил тод байдлын болон хариуцлагатай уул уурхай, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ зэрэг олон улсын санаачилгыг дэмжин хөгжүүлэх; 3.5.2. Уул уурхайн олборлолтын хугацаанд нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулагч компани, нутгийн өөрөө удирдах байгууллагын хооронд орон нутгийг хөгжүүлэх гэрээг ил тод байх, оролцооны зарчмыг баримтлан байгуулах.
Шилэн дансны тухай хууль	6-р зүйл: Шилэн дансны мэдээлэл 6.4.8. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; 6.5.9. Концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг гэрээ байгуулагдсанаас нь хойш долоо хоногийн дотор 6.5.10. Концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг долоо хоногийн дотор;
Дүрэм журам	
Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам	Уг журам бүхэлдээ хамаарна.
УИХ-ын тогтоол	
Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай	Уг тогтоол бүхэлдээ хамаарна.
Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай	Уг тогтоол бүхэлдээ хамаарна.
“Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Уг тогтоол бүхэлдээ хамаарна.
Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээ тогтоох тухай	Уг тогтоол бүхэлдээ хамаарна.
Засгийн газрын тогтоол	
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай	7. ОУИТБС-ын хүрээнд Монгол Улсад хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнд хүргэж хэрэгжүүлэн, шинээр ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, түүнийг эзэмших, шилжүүлэх үйл ажиллагаа, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах талаар байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ, газрын тосны талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ, тэдгээрийн хэрэгжилт, ашиглалтын өмнөх гэрээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль хамгаалах ажлын явц, үр дүн, түүнд зарцуулсан зардал зэргийг тус санаачилгад нэмж хамруулахаар тогтоосугай. 8. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, эзэмших, шилжүүлэх (тусгай зөвшөөрлийг компанийн нэр, баримт бичигтэй нь хамт худалдах асуудал энд бас хамаарна), стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ болон тэдгээрийн хэрэгжилт, уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалт, экспортын хэмжээг нийтэд ил тод болгох ажлыг 2012 оноос туршилтын журмаар хэрэгжүүлж, үр дүнг Ажлын хэсэг, улмаар Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж жил бүр нийтэд ил тод мэдээлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод үүрэг болгосугай.
Таван толгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай	Уг тогтоол бүхэлдээ хамаарна.

Нээлттэй нийгэм форумаас (ННФ) “Эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдал” олон талт оролцогчдын хэлэлцүүлгийг ОУИТБС-ын Ажлын алба, иргэний нийгмийн (ТАН) эвсэл, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци (МУУА)-тай хамтран УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Уул уурхайн яамны дэмжлэгтэйгээр 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үр дүнд гэрээнүүдийн эх бичвэрүүдийн нэгдсэн цахим сан үүсгэж системтэйгээр олон нийтэд нээлттэй байршуулах асуудалд санал нэгдэн гэрээний ил тод байдлыг хангах чиглэлээр цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж хүргүүлсэн²⁶. Түүнчлэн гэрээний ил тод байдлын чиглэлээр Засгийн газар, иргэний нийгэм болон компаниудын төлөөлөөс бүрдсэн дэд ажлын хэсэг томилсон байна.

Энэхүү мэдээллийн цахим сан нь олон нийт, сэтгүүлчид, эрдэмтдэд эрдэс баялгийн гэрээнүүд болон бусад холбогдох баримт бичгүүдийг бүрэн эхээр нь нээлттэй болгож өгсөн.

2017 оны 06-р сарын 22-ны өдөр Нээлттэй нийгэм форум, ОУИТБС Ажлын алба болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хамтран олборлох үйлдвэрлэлийн гэрээний ил тод байдлыг сайжруулах зорилгоор цахим мэдээллийн сан ²⁷ байгуулсан. Уг мэдээллийн санд газрын тос, байгалийн хийн салбарын бүтээгдэхүүн хуваах гэрээ, хөрөнгө оруулалтын гэрээ, уул уурхайн салбарт байгуулсан концесс, орон нутгийн бүтээн байгуулалтын гэрээ, түүнчлэн 2006 оны Ашигт малтмалын тухай хуулиас өмнө байгуулсан тогтвортой байдлын гэрээг багтаасан болно.

Мэдээллийн сан нь олон нийт, иргэний нийгэм, сэтгүүлчид, эрдэмтэн судлаачдад гэрээ болон холбогдох бичиг баримтын эх бичвэрүүдийг ашиглан төрөл бүрийн дүн шинжилгээ, хяналт, судалгаа хийх боломжийг олгох зорилготой болно. Мэдээллийн сангийн хайлтын системийг ашиглан гэрээнүүдийг эрдсийн төрөл, гэрээний төрөл, гэрээ байгуулсан талууд болон огноо, гэрээний үндсэн нөхцөлүүдээр шүүн үзэх боломжтой.

Одоогийн байдлаар мэдээллийн санд 439 гэрээг байршуулсан байна ²⁸:

№	Гэрээний төрөл	Гэрээний тоо
1	Газар ашиглах гэрээ	124
2	Орон нутагтай хамтран ажиллах гэрээ	86
3	Концессийн гэрээ	4
4	Ус ашиглах гэрээ	48
5	Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн дагуу хийгдэх гэрээ	23
6	Бүтээгдэхүүн хуваах гэрээ	26
7	Хөрөнгө оруулалтын гэрээ	4
8	Тогтвортой байдлын гэрээ	11
9	Ашиглалтын өмнөх гэрээ	45
10	Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн гэрээ	67
11	Бусад	1
	Нийт	439

2017 онд 309 гэрээ бүртгэлтэй байсан бол 2018 онд 130 гэрээ нэмж бүртгэгдсэн байна.

Нэгтгэлд хамрагдсан компаниудаас нэмэлт мэдээллийн маягтын дагуу 54 компаниас бидэнд мэдээллээ ирүүлснээс 31 компани [iltodgereee.mn](http://www.iltodgereee.mn) сайтад мэдээлэл оруулсан байгаа бол үлдсэн 23 компани мэдээллээ оруулаагүй байна.

2.5.1 БХГ-ний ил тод байдал

2012 оны 7-р сарын 4-ний өдөр Засгийн газар 222 дугаар тогтоол батлагдахаас өмнө БХГ ил тод болгохтой холбоотой Засгийн газрын бодлого журам байгаагүй.

АМГТГ-ын вэбсайт дахь газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний талаарх мэдээллийг 2014 оны 10-р сарын 1-ний өдрөөс хойш шинэчлээгүй байна. Түүнчлэн АМГТГ өргөдөл гаргасан огноо, лиценз олгосон огноо, лицензийн хугацаа, талбайн координат, лицензийн төрөл, үйлдвэрлэлийн төрөл зэрэг зарим чухал мэдээллүүдийг нийтлээгүй байна.

²⁶ Эх сурвалж: http://forum.mn/index.php?sel=project&menu_id=29&obj_id=5007

²⁷ Эх сурвалж: <http://www.iltodgereee.mn>

²⁸ Эх сурвалж: <http://www.iltodgereee.mn>

2.6 Бенефициар эзэд

2.6.1 Бенефициар эздийн замын зураг

2016 онд ОТАХ-ээс ашиг хүртэгч эзэд буюу бенефициар гэдэг ойлголт, түүний эрх зүйн орчин, боломж, сорилт, асуудал, ашиглаж болох тогтолцоо зэргийг судлах ажлын дэд хэсэг томилсон ба тус дэд ажлын хэсгээс бенефициар эздийн мэдээллийг ил тод болгох Замын зургийн төслийг боловсруулж, 2016 оны 12-р сарын 20-ны өдрийн Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, 2017 оны 12-р сарын 21-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. Замын зурагт 2020 он хүртэл хэрэгжүүлэх 32 үйл ажиллагааг 7 зорилтын хүрээнд төлөвлөсөн ²⁹:

Зорилтууд	Хэрэгжсэн байдал
2017	
Зорилт 1: Бенефициар өмчлөгчийн ил тод байдлыг үндэсний бодлоготой үялдуулна. Тухайлбал, Нээлттэй засгийн түншлэлийн үндэсний зөвлөлийн үүлзалт зохион байгуулах, УИХ-ын холбогдох байнгын хороонд төлөвлөсөн ажлаа танилцуулах, сонсгол зохион байгуулна.	Иж бүрэн хэрэгжээгүй
Зорилт 2: Бенефициар өмчлөгчийн ил тод байдлын талаарх институтын хүрээг тодорхойлно. Тухайлбал, төрийн байгууллагуудад семинар зохион байгуулж, хуулийн ажлын хэсэг байгуулж, холбогдох хуулиудад болон Засгийн Газрын 222 тоот тогтоол, ОУИТБС-ын хуульд нэмэлт өөрчлөлт оруулна.	Иж бүрэн хэрэгжээгүй
Зорилт 3: Нэр томьёо, тодорхойлолт, материаллаг босго, тайлагналын хугацаа, үечлэлийг тогтооно. Тухайлбал, судалгаа хийж, ОТАХ-т цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж, Үндэсний зөвлөлийн хуралдаанд үр дүнг танилцуулна.	Хэрэгжсэн
Зорилт 4: Бенефициар өмчлөгчийн мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангах үүднээс ОУ-ийн компани нь улс төрд нөлөө бүхий этгээдийн эзэмшилд байгаа эсэх мэдээллийг бүрэн тайлагнана. Тухайлбал, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн маягтыг шинэчилнэ.	Хүлээгдэж буй
Зорилт 5: Компаниудын дунд хэлэлцүүлэг, иргэний нийгмийн байгууллага, эрэн сурвалжлах сэтгүүлчдийн сургалт, урамшууллын тогтолцоо, хэлэлцүүлэг гэх мэт нөлөөллийн ажил зохион байгуулна.	Хүлээгдэж буй
2018	
Зорилт 6: Бенефициар өмчлөгчийн мэдээллийг туршилтаар цуглуулах, мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулах зорилгоор төрийн байгууллага, агентлагуудын мэдээллийн системд холбогдох, мэдээлэл солилцох тухай холбогдох журам маягтыг шинэчлэх.	Хүлээгдэж буй
2019	
Зорилт 7: Бенефициар өмчлөгчийн мэдээллийн ил тод байдлыг ОУИТБС-ын 2018 оны нэгтгэлийн тайланд тайлагнаж олон нийтэд нээлттэй хүргэх.	Хүлээгдэж буй

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 04-р сарын 12-ны 114 тоот тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг³⁰ баталсан. Энэхүү тогтоолын хавсралт төлөвлөгөөний 4.1.6.5-д Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандартын хүрээнд ашиг хүртэгч (бенефициар) эздийг ил тод болгох ба 2020-2022 онд хэрэгжүүлж, МОУИТБС-ын Ажлын алба хариуцахаар тусгасан байна.

Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлөөс “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө (ҮАҮТ)”-г Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Хуралдаанаар ҮАҮТ-ний төслийг дэмжиж, Засгийн газрын гишүүдийн саналыг тусгасан ба нийт 13 зорилтот үйл ажиллагаа бүхий ҮАҮТ-ний төслийг Үндэсний зөвлөл 2016 оны 06 дугаар сарын 07-ны өдөр хуралдан хэлэлцэж, баталсан.

Энэхүү төлөвлөгөөний 12 дахь зорилтот үйл ажиллагаа нь Байгалийн баялгийг ашиглагч этгээдийн эздийг буюу бенефициар өмчлөгчдийг ил болгох тухай бөгөөд Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллахаар даалгажээ.

²⁹ Эх сурвалж: <http://www.eitimongolia.mn/mn/beneficial-ownership-disclosure>

³⁰ Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/7496?lawid=12293>

2.6.2 Бенефициар эздийн тодорхойлолт

ОУИТБС-ын Ажлын хэсгийн 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар ашиг хүртэгч эцсийн эздийг ил тод болгохтой холбоотойгоор нэр томьёо, тодорхойлолт, хамрах хүрээ, материаллаг босго, цуглуулах мэдээлэл зэргийг хэлэлцэж, эцэслэн баталсан. Энэхүү хуралдаанаар батлахаас өмнө төр, компани, иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн 9-н цуврал хэлэлцүүлгээр нийт 260 гаруй оролцогчид хэлэлцэж дараах тодорхойлолтуудыг тохирсон.

“Ашиг хүртэгч эцсийн эзэн” гэдэгт эрдэс баялгийн салбарт тусгай зөвшөөрөл эзэмшигч, хөрөнгө оруулагч, тендерт оролцогч, гэрээлэгч хуулийн этгээдийн 5 хувь буюу түүнээс дээш хувьцаа эсхүл түүнтэй адилтгах үнэт цаасыг, 20 хувь буюу түүнээс дээш саналын эрхийг, ... хувь буюу түүнээс дээш ногдол ашгийг шууд болон шууд бусаар эзэмшдэг, өмчилдөг, хүртдэг, удирдлага, хяналтыг шууд болон шууд бусаар хэрэгжүүлдэг, эсхүл бусад хэлбэрээр эрхээ хэрэгжүүлдэг хувь хүнийг ойлгоно.

“Эзэмшил, өмчлөлийн эрхийг шууд бүс хэлбэрээр хэрэгжүүлэх” гэдэгт өөрийн эзэмшлийн хувьцаа, түүнтэй адилтгах үнэт цаас, саналын бусад эрхийг гэрээ, итгэмжлэл, төлөөллийн бусад хэлбэрээр өөрийн хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой, холбогдох этгээдээр дамжуулан хэрэгжүүлэх эсхүл 1 буюу түүнээс дээш үргэлжлэх гинжин холбоо бүхий хуулийн этгээдийн үүсгэн байгуулахыг ойлгоно.

“Шууд удирдлага, хяналтын эрх” гэдэгт Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйл болон компанийн дүрэмд заасан эрх бүхий албан тушаалтныг томилох, их хэмжээний хэлцлийг байгуулах шийдвэрийг дангаараа болон нэгдмэлд сонирхолтой этгээдтэй хамтран гаргах эрхийг ойлгоно.

“Шууд бүс удирдлага, хяналт” гэдэгт Компанийн удирдлага, хяналтын эрхийг гэрээ, итгэмжлэл, төлөөллийн бусад хэлбэрээр эсхүл өөрийн хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой этгээдээр дамжуулан хэрэгжүүлэх нөхцөл байдлыг ойлгоно.

“Улс төрд нөлөө бүхий этгээд” гэдэгт нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан албан тушаалтнуудыг ойлгоно. Хэрэв ашиг хүртэгч эцсийн эзэн нь улс төрд нөлөө бүхий этгээд бол түүнд болон түүний хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой этгээдийн хувь эзэмшилд босго тогтоох шаардлагагүй (0%) болно.

2.6.3 Бенефициар эздийн ил тодруулга

2018 оны ОУИТБС-ын тайланд зориулан бенефициар өмчлөгчийг тодорхойлох маягтыг боловсруулж нэгтгэлд хамрагдсан компаниуд руу илгээсэн. ОУИТБС-ын шаардлагын дагуу дараах мэдээллүүдийг цуглуулсан. Үүнд:

- Овог нэр,
- Үндэс угсаа,
- Регистрийн дугаар,
- Төрсөн огноо,
- Иргэний харьяалал, давхар иргэншил
- Оршин суугаа улсын нэр
- Улс төрд нөлөө бүхий этгээд эсэх,
- Компанидаа удирдах албан тушаал хашдаг эсэх
- Одоо хашиж буй ажлын газрын хаяг,
- Өмчлөлийн хувь хэмжээ,
- Бүсдын өмнөөс эрх хэрэгжүүлдэг эсэх,

Нэгтгэлд хамрагдсан 202 компаниас 60 компани бенефициар өмчлөгчийн мэдээллээ ирүүлсэн.

Монгол Улсад олборлох салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын бенефициар эздийн талаар аль болох их мэдээлэл өгөх зорилгоор хараат бүс хянагч-нэгтгэгч нь өмнөх бүх тайлангуудын мэдээллийг (2013-2017 оны) цуглуулж, 2018 оны нэгтгэлээр цуглуулсан мэдээлэлтэй нэгтгэж оруулав. Энэхүү тайлангийн 20-р хавсралтаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компаниудын бенефициар эздийн мэдээллийг тусгасан болно.

Монгол Улсын Засгийн газар 2019 оны 05-р сараас эхлэн ашигт малтмалын салбарын тайлагнал, тайлангийн мэдээллийн баталгаажуулалт, бенефициар эздийн мэдээллийг толилуулга зэрэгтэй холбоотой зүйл заалтууд бүхий ашигт малтмалын салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулахаар ажиллаж байна. Хуулийн төслийг 2019 оны 03-р улиралд багтаан боловсруулж, 2020 оноос өмнө УИХ-д өргөн мэдүүлэхээр төлөвлөсөн байна.

Мөн Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар 2019 оны 3-р сараас эхлэн бенефициар өмчлөгчдийн талаар зарим мэдээллийг <http://opendata.burtgel.gov.mn> сайтад төвлөрүүлж эхэлсэн байна. Уг сайтад нийт 193,840 хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, бүртгэгдсэн огноо, компанийн хэлбэр (ХХК), компанийн төрөл (ашиг, ашгийн бүс), үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, гишүүний тоо, удирдлагын овог, нэр, албан ёсны хаяг болон үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн талаар мэдээллүүд байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10-р зүйлд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн баталгаажуулсан хуулбарыг улсын бүртгэлийн мэдээллийн санд цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлнэ³¹ гэж заажээ. Уг заалтыг 2020 оны 1-р сарын 1-нээс эхлэн дагаж мөрдөж эхэлснээр бенефициар эздийн мэдээллийг ил тод болгоход дөхөмтэй болно гэдэгт итгэлтэй байна.

2.7 Төрийн оролцоо

2.7.1 Олборлох үйлдвэрлэл дэх төрийн оролцоонд мөрдөгдөх журам

Компанийн тухай хуулийн 12.5 дугаар зүйлд төр, түүний байгууллага нь дараах тохиолдолд компанийн үүсгэн байгуулагч болон түүний хувьцаа эзэмшигч байж болно гэж заасан. Үүнд:

- төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчилснаар шинээр бий болсон компанийн;
- төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн байгуулах замаар үүссэн төрийн өмчит компанийн;
- хууль тогтоомжид заасан журмын дагуу дампуурч байгаа компанийн төрд төлөх өрийг хувьцаагаар нь сольж авсан компанийн (Энэ тохиолдолд төр тухайн хувьцааг гурван жилийн дотор бусад этгээдэд худалдах үүрэгтэй);
- гадаад улсын хуулийн этгээдтэй хамтран байгуулсан компанийн;
- хуульд заасан бусад

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд “Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ” болон 21.1 дугаар зүйлд “Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэнэ” гэж заасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу, төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна. Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ. Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ.

ТӨААН-ийн төрийн өмчийн төлөөллийг Төрийн өмчийг хэрэгжүүлэх журмаар зохицуулан томилдог. Энэхүү журмын 2 дугаар зүйлд олборлох салбарын төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд төрийн өмчийн төлөөлөгчийг дараах байдлаар томилно гэж заажээ:

- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг Засгийн газрын 2016 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрэм”-ийн 7.1, 8.2-т заасны дагуу Засгийн газар томилж, чөлөөлнө.
- “Оюу толгой” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын чиглэл болгосны дагуу “Эрдэнэс Оюу толгой” ХХК нэр дэвшүүлж, “Оюу толгой” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал томилж, чөлөөлнө.
- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн харьяа төрийн өмчийн оролцоотой “Эрдэнэс Таван толгой” ХК болон “Эрдэнэс Оюу толгой” ХХК, “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Мон-Атом” ХХК зэрэг төрийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг Засгийн газрын 2016 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Эрдэнэс Монгол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм”-ийн 11.8-д заасан журмын дагуу томилж, чөлөөлнө.
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас чиглэл болгосны дагуу төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага томилж, чөлөөлнө.
- Энэ журмын 2.4-2.91-т зааснаас бусад тохиолдолд төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага томилж, чөлөөлнө.

Төрийн өмчит хуулийн этгээд нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар зохиож Сангийн яаманд тушаана.

³¹ Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/13591>

Дараах хүснэгтэд уул уурхайн салбарт төрийн оролцоотой ТӨААН болон хуулийн этгээдийн дэлгэрэнгүйг харуулав:

№	Регистр	Компанийн нэр	Төрийн оролцооны хувь		Тусгай зөвшөөрлийн тоо
			2017	2018	
1	5124913	Эрдэнэс Монгол ХХК	100%	100%	4
	5435528	Эрдэнэс Таван толгой ХК	81,5%	85,2%	8
	2008572	Багануур ХК	75%	75%	3
	2004879	Шивээ-Овоо ХК	90%	90%	1
2	2074192	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	51%	51%	7
3	2657457	Оюу Толгой ХХК	34%	34%	3
4	2550466	Монголросцветмет ТӨҮГ	100%	100%	30
5	2076675	Улаанбаатар төмөр зам /Чулуун завод/ ХНН	50%	50%	1

Дараах хүснэгтэд уул уурхайн салбарт орон нутгийн засаг захиргааны оролцоотой аж ахуйн нэгжүүдийг харуулав:

№	Регистр	Компанийн нэр	Төрийн оролцооны хувь		Тусгай зөвшөөрлийн тоо
			2017	2018	
1	2016656	Тавантолгой ХК	51%	51%	1
2	2034859	Могойн гол ХК	51%	51%	2
3	2014491	Баянтээг ХК	70%	70%	1

2.7.2 Төрийн өмчит аж ахуй нэгжүүд

2.7.2.1 Уул уурхайн салбар дахь төрийн өмчит аж ахуй нэгжүүд

Эрдэнэс Монгол ХХК

“Эрдэнэс Монгол” ХХК нь 2007 оны 2 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд болон стратегийн ач холбогдол бүхий эрдэс баялгийн ордыг ашиглахтай холбоотой харилцаанд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан 100% төрийн өмчит компани юм. Энэ бол стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүнтэй холбогдох дэд бүтэц, төсөл, хөтөлбөр боловсруулах төрийн хуулийн этгээд юм.

Эрдэнэс Монгол ХХК -н үндсэн үйл ажиллагаа нь:

- уул уурхайн компаниуд дахь хувийг эзэмшин тэдгээрийн үнэ цэн, үйл ажиллагаа болон ашигт байдлыг өсгөх,
- гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө босгох, нэмүү өртөг шингэсэн аж үйлдвэрийн төслүүдийг хэрэгжүүлэх,
- үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, компаниудын үйл ажиллагаанд Засгийн газрын бодлогыг уялдуулах

Өнөөдрийн байдлаар, компани нь уул уурхай болон уул уурхайтай холбоотой үйл ажиллагаа эрхэлж буй хэд хэдэн компанид хувь эзэмшдэг. Бид дараах хүснэгтэд компанийн оролцооны талаар дэлгэрэнгүй харуулав³²:

№	Компанийн нэр	Ашигт малтмал/Үйл ажиллагаа	Хувьцаат капитал
1	“Эрдэнэс Таван Толгой” ХК	Нүүрс	85,2% Эрдэнэс Монгол ХХК 14,8% Бусад
2	“Багануур” ХК	Нүүрс	75% Эрдэнэс Монгол ХХК 25% Бусад
3	“Шивээ-Овоо” ХК	Нүүрс	90% Эрдэнэс Монгол ХХК 10% Бусад
4	“Эрдэнэс Оюу Толгой” ХХК	Зэс, алт	100% Эрдэнэс Монгол ХХК
5	“Мон-Атом” ХХК	Уран	100% Эрдэнэс Монгол ХХК
6	“Эрдэнэс Шивээ Энержи” ХХК	Нүүрс	Эрдэнэс Монгол ХХК Эйкүсора ХХК
7	“Эрдэнэс Алт Ресурс” ХХК	Алт	100% Эрдэнэс Монгол ХХК
8	“Эрдэнэс Метан” ХХК	Метаны эрэл	100% Эрдэнэс Монгол ХХК
9	“Эрдэнэс Ассет Менежмент” ХХК	Хөрөнгийн зөвлөх үйлчилгээ	100% Эрдэнэс Монгол ХХК
10	“Эрдэнэс Ашид” ХХК	Хайгуулын үйл ажиллагаа	34% Эрдэнэс Монгол ХХК 66% Монголын Алт (МАК) ХХК
11	“Эрдэнэс Стийл” ХХК	Ган төмөрлөгийн үйлдвэр	50% Эрдэнэс Монгол ХХК 50% Бэрэн Групп ХХК
12	“Гашуунсүхайд авто зам” ХХК	Авто замын эзэмшил	100% Эрдэнэс Монгол ХХК

“Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин компаниудын ТУЗ-ын гишүүдийн нэр, ажил албан тушаал:

№	Овог нэр	Албан тушаал	Одоогийн ажил, албан тушаал
1	Г.Баясгалан	ТУЗ-ийн дарга	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга
2	Ц.Цэнгэл	ТУЗ-ийн гишүүн	БОАЖА-ны Төрийн нарийн бичгийн дарга
3	Э.Бат-Идэр	ТУЗ-ийн гишүүн	ЗГХЭГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
4	Б.Тэлмүүн	ТУЗ-ийн гишүүн	Сангийн яамны төсвийн орлогын хэлтсийн дарга
5	П.Ганхүү	ТУЗ-ийн гишүүн	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал
6	Ч.Анун	ТУЗ-ийн гишүүн	УУХҮЯ-ны гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга
7	Д.Энхжаргал	ТУЗ-ийн гишүүн	Хараат бус гишүүн
8	Д.Мөнхгэрэл	ТУЗ-ийн гишүүн	Хараат бус гишүүн “Петровис Ойл” ХХК-ийн Хуулийн газрын захирал
9	Ц.Пүрэвэрэнчин	ТУЗ-ийн гишүүн	Хараат бус гишүүн, “Сод Монгол” группийн дэд захирал

Эрдэнэс Таван Толгой ХК

МУ-ын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий Таван толгойн коксжих нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор 2010 онд “Эрдэнэс Таван толгой” ХК-ийг байгуулсан.

“Эрдэнэс Таван толгой” ХК нь стратегийн ач холбогдол бүхий нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх үндсэн чиглэлээр ажилладаг.

“Эрдэнэс Таван толгой” ХК-н эрх барих дээд байгууллага нь Компанийн тухай хуульд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурал ба Хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогдсон 11 гишүүн бүхий ТУЗ компанийн удирдлагыг хэрэгжүүлнэ. Үүнээс төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 7, хараат бус 4 гишүүн байна.

“Эрдэнэс Таван толгой” төсөл нь нүүрс олборлолт, бүтээгдэхүүн боловсруулах, дэд бүтэц, үйлдвэрүүдийг барьж байгуулах, ус хангамжийн системийг байгуулах, ордод нэмэлт хайгуул, судалгаа хийх, бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд хүргэх, дотоодын болон олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаа арилжаалах гэсэн үндсэн чиглэлээр хэрэгжих юм.

Цанхийн Зүүн уурхайн ТЭЗҮ-ийг 2011 онд батлуулан, олборлолтын үйл ажиллагаа эхлүүлсэн бөгөөд Цанхийн Баруун ТЭЗҮ-ийг 2012 онд батлуулан, олборлолтын үйл ажиллагааг 2013 оны 2 дугаар сараас тус тус эхлүүлсэн³³.

Шилэн дансны хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани 4 төрлийн, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 4 дүгээр зүйлийн 6 төрлийн, компани мэдээллээ ил тод байлгах үүднээс өөрийн саналаар тус журмын 4 дүгээр зүйлийн 2 төрлийн мэдээллийг тус тус шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон компанийн цахим сайтад байршуулан ажиллаж байна. Мөн шилэн дансны цахим хуудас болон компанийн цахим хуудсанд тогтмол байршуулах төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 11 төрлийн мэдээллийн жагсаалтыг Гүйцэтгэх захирлын 2019 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн А/446 тоот тушаалаар баталсан. Холбогдох мэдээллийг www.erdenestt.mn, www.shilendans.gov.mn цахим хаягуудаас авна уу?

³² Эх сурвалж: <http://www.erdenesmongol.mn>

³³ Эх сурвалж: <http://www.erdenesmongol.mn>

“Эрдэнэс Таван Толгой” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн нэр хаяг, тэдгээрийн эзэмшлийн хувь хэмжээ, түүнд орсон өөрчлөлтийн мэдээ:

Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолд компанийн нийт гаргах хувьцааны 51-ээс доошгүй хувийг төр эзэмшиж, үлдсэн 50 хүртэлх хувийн 20 хүртэлх хувийг Монгол улсын иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэх, 10 хүртэлх хувийг тусгай шаардлага хангасан үндэсний аж ахуйн нэгжүүдэд нэрлэсэн үнээр худалдах, 20 хүртэлх хувийг гадаад, дотоодын зах зээлд хувьцаа гаргах замаар хөрөнгө оруулалт татахаар заасан байдаг. Компанийн нийт хувьцаа эзэмшлийн бүтэц дараах байдалтай байна.

- Монгол Улсын Засгийн газар 12,780,711,099 ширхэг буюу 85.20%
- 486 аж ахуйн нэгж 7,065,038 ширхэг буюу 0,05%
- 2,511,332 Монгол Улсын иргэн 2,212,223,865 ширхэг буюу 14.75%

“Эрдэнэс Таван Толгой” ХК болон түүний охин компаниудын ТУЗ-ын гишүүдийн нэр, ажил албан тушаал:

№	Овог нэр	Албан тушаал	Томилогдсон огноо	Одоогийн ажил, албан тушаал
1	Б.Баярсайхан	ТУЗ-ийн дарга	2019/08/13	Үндэсний хөгжлийн газрын дарга
2	У.Бямбасүрэн	ТУЗ-ийн гишүүн	2018/10/19	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга
3	С.Наранцогт	ТУЗ-ийн гишүүн	2018/10/19	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
4	М.Баяраа	ТУЗ-ийн гишүүн	2018/10/19	Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамны ТЗУГ-ын дарга
5	Р.Мэргэн	ТУЗ-ийн гишүүн	2018/10/19	Зам тээврийн хөгжлийн яамны газрын дарга
6	Б.Ганхуяг	ТУЗ-ийн гишүүн	2018/10/19	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал
7	Ц.Баяр-Эрдэнэ	ТУЗ-ийн гишүүн	2018/10/19	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга
8	Р.Бурмаа	ТУЗ-ийн гишүүн	2018/10/19	Нийгмийн дэвшил, эмэгтэйчүүдийн хөдөлгөөний тэргүүн
9	Ц.Ганболд	ТУЗ-ийн гишүүн	2018/10/19	Монголын хуульчдын холбооны Тамгын газрын дарга
10	П.Өлзийнаран	ТУЗ-ийн гишүүн	2018/10/19	“МоЭнко” ХХК-ийн төслийн инженер
11	Х.Болор-Эрдэнэ	ТУЗ-ийн гишүүн	2018/10/19	“Дорнод газар” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Багануур ХК

Багануур ХК анх 1978 онд Төвийн эрчим хүчний системийн харьяа Дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах зориулалтаар байгуулагдсан. 1995 онд хувьчлагдан төрийн өмч давамгайлсан “Багануур” хувьцаат компани болон өөрчлөгдсөн. Засгийн газрын 2013 оны 100 дугаар тогтоолоор нийт хувьцааны 75 хувийг төр буюу “Эрдэнэс Монгол” ХХК, 25 хувийг бусад аж ахуй нэгж, иргэд эзэмшдэг.

Ордын байршлын хувьд Багануурын нүүрсний орд газар нь Улаанбаатар хотоос зүүн тийш 130.0 км зайтай Хэнтийн уулархаг мужийн зүүн өмнөд хэсэгт Хэрлэн голын баруун эргийн дагуу оршдог ба ордын нийт нөөцийг 812 сая.тн гэж тогтсон.

Үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал 4.0 сая.тн бөгөөд дотоодын хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээнээс хамаарч 3.6-3.8 сая.тн нүүрсийг олборлож 16.0-18.0 сая шоо метр хөрс хуулдаг. Монгол Улсын нүүрсний хэрэгцээний 60%, төвийн бүсийн нүүрсний хэрэгцээний 70 гаруй хувийг дангаараа хангаж ирсэн.

Багануурын нүүрс нь өөрийн физик, хими шинж чанараараа зөвхөн эрчим хүчний зориулалтаар ашиглагдах төдийгүй дахин боловсруулалт хийгдэн шатдаг хий, түлш, шингэн ба шахмал түлш, бусад химийн үйлдвэрлэлийн түүхий эд болох бүрэн боломжтой нь судалгаагаар батлагдсан³⁴.

Шивээ-Овоо ХК

1995 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар тус уурхайг Төрийн өмч давамгайлсан “Шивээ-Овоо” ХК болгон зохион байгуулав. Нийт хувьцааны 90 хувийг төр буюу “Эрдэнэс Монгол” ХХК, 10 хувийг иргэд эзэмшдэг.

Шивээ-Овоогийн нүүрсний уурхай нь Улаанбаатар хотоос зүүн урагшаа 265 километр, Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт, далайн түвшинээс дээш 1,200 метрт оршдог. Шивээ-Овоогийн нүүрсний орд нь нийт 29500.0 га талбайг хамардаг бөгөөд нийт 2708.7 сая тн нүүрсний нөөцтэй (Шинэ усны хэсэг - 564.1 сая.тн, Өөхийн цагааны хэсэг - 1147.9 сая.тн, Ногоон тойромны хэсэг - 996.7 сая.тн).

³⁴ Эх сурвалж: <http://www.baganuurmine.mn>

Тус компани нь Монгол Улсын дотоодын нүүрсний хэрэгцээний 30%, “ДЦС-4” ТӨХК-ийн хэрэгцээний 50%-ийг хангаж байна.

“Шивээ-Овоо” ХК-ийн 2018 оны худалдан авалтын тайлан, шилэн данс тайлагналт: 2018 оны худалдан авалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолын 5 дах хэсэг “Дүгнэлт, зөвлөмж цаашид авах арга хэмжээ”-т дурдсаны дагуу зохион байгуулж байна. Мөн түүнчлэн зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг эдийн засгийн тооцоо судалгаанд суурилан хийх, анхан шатны баримт бичгийн бүрдэлтэд хяналт тавин ажиллаж байна. Цаашид төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг чанд мөрдөж 2018 оны Сангийн сайдын 281 дүгээр тушаалаар баталсан худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу маягтын хүрээнд бүрэн гүйцэд тайлагнан ажиллаж байна.

Эрдэнэс Оюу Толгой ХХК

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Оюу толгойн зэс-алтны ордыг ашиглах "Хөрөнгө оруулалтын гэрээ"-г Монгол Улсын Засгийн Газар, "Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед" ХХК, "Айвенхоу Майнз" ХХК-үүд 2009 онд байгуулсан. "Оюу Толгой" ХХК-ийн хувьцааны 34 хувийг Монгол Улсын Засгийн Газар эзэмшиж байгаа бөгөөд "Эрдэнэс Монгол" ХХК-нд энэхүү 34 хувийг эзэмшүүлсэн. Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 348 дугаар тогтоол, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 оны 28 дугаар тогтоолуудаар "Эрдэнэс Монгол" ХХК-ийн охин компани болох "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийг шинээр үүсгэн байгуулж, "Оюу Толгой" ХХК-ийн хувьцааны 34 хувийг "Эрдэнэс Монгол" ХХК-аас "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-нд албан ёсоор шилжүүлэв³⁵.

"Эрдэнэс Оюу Толгой" ХХК нь монголын талын 34 хувийн хувьцааг эзэмшин, "Оюу Толгой" ХХК-ийн үйл ажиллагаанд оролцож, ашигт малтмалын ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлэх явдал юм.

"Эрдэнэс Оюу Толгой" ХХК нь “Эрдэнэс Монгол” ХХК-н 100%-н эзэмшлийн компани юм.

Эрдэнэс Ассет Менежмент ХХК

Хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө босгох, бонд шаргах, хувьцаа эзэмших, худалдаалах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

Эрдэнэс Шивээ Энержи ХХК

Төр, хувийн хэвшлийн хамтарсан Эрдэнэс Шивээ Энержи ХХК нь 2016 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Эрдэнэс Монгол ХХК (50%) болон Эйкусора ХХК (50%)-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу байгуулагдсан. Эрдэнэс Шивээ Энержи ХХК нь 1.2 тэрбум тоннын нүүрсний нөөцтэйгээр Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт үйл ажиллагаагаа явуулдаг байсан боловч 2017 оны 10-р сараас эхлэн үйл ажиллагаагаа түр зогсоосон. Уг компани нь стратегийн ач холбогдол бүхий Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн байгуулах Эрчим хүчний экспортын Шивээ Энержи цогцолбор төслийг нүүрсээр хангах юм³⁶. 2018 оны 9-р сард “Шивээ Энержи” эрчим хүчний цогцолбор төслийн ТЭЗҮ-ийг бэлтгэж дууссан байна.

Мон-Атом ХХК

Цөмийн энергийн тухай хуульд цацраг идэвхт ашигт малтмалын ордыг хэмжээнээс нь үл хамааран стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулж, ордыг ашиглах тохиолдолд төрийн төлөөллийг заавал хангасан байхыг шаарддаг. Энэ чиг үүргийг хариуцуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 45 дугаар тогтоолоор уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд дангаар болон бусад хуулийн этгээдтэй хамтран оролцох, төрийн төлөөллийг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх үүднээс “Мон-Атом” ХХК-ийг үүсгэн байгуулсан³⁷.

“Мон-Атом” ХХК нь 2019 оны байдлаар Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т заасны дагуу Франц Монголын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн 34 хувийг, Монгол Чехийн хамтарсан “Гүрвансайхан” ХХК-ийн 15 хувийг эзэмшиж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор “Мон-Атом” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг бүхэд нь “Эрдэнэс Монгол” ХХК-нд шилжүүлж охин компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.

³⁵ Эх сурвалж: <http://eot.mn>

³⁶ Эх сурвалж: <http://www.erdnesmongol.mn>

³⁷ Эх сурвалж: <http://www.erdnesmongol.mn>

Мон-Атом” ХХК-тай хамтарсан төслүүд**Монгол-Францын хамтарсан төсөл-1**

Монгол-Францын хамтарсан төслийн хүрээнд Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Зөөвч овоо, Дулаан уулын ордуудыг ашиглахаар бэлтгэж байна.

Тус ордуудыг ашиглах техник эдийн засгийн үндэслэл нь 2015 оны 02 дугаар 04-ний өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлагдсан. Тус ТЭЗҮ-д дурдсанаар нийт 22 жилийн хугацаанд газар дор уусган ашиглах аргаар олборлох төслийн нийт хөрөнгө оруулалт 1077 сая ам.доллар, борлуулалтын орлого 5977 сая ам.доллар болох ба нийт улс болон орон нутгийн төсөвт 1190 сая ам.долларын орлого оруулж 1454 ажлын байр шинээр бий болох юм.

“Зөөвч овоо”, “Дулаан уул” ордуудын ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг Ашигт малтмалын газраас 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдөр олгож, түүнчлэн “Орд ашиглах гэрээ”-г 2016 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан.

Энэхүү төслийг эхлүүлэх чиглэлээр Мон-Атом ХХК нэгдсэн төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангаж идэвх, зүтгэл гаргаж ажилласан. Үүний үр дүнд холбогдох зөвшөөрлүүдийг авч оны төгсгөл гэхэд төсөл эхлэхэд үндсэндээ бэлэн болоод байна.

Уг ордуудыг ашиглах туршилтын үйлдвэрийн барилга болон уурхайг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/18/16 дугаар тушаалын дагуу Зөөвч-Овоо талбай дээр туршилтын үйлдвэрийг улсын комисст хүлээн авах ажлын хэсэг ажилласан.

Монгол-Чехийн хамтарсан төсөл-2

Монгол-Чехийн хамтарсан төслийн хүрээнд Дундговь аймгийн Баянжаргалан, Өлзийт сумдын нутагт орших Хайрхан, Чойрын хайгуулын талбайд Хараат, Хайрхан ордууд, Дундговь аймгийн Гурвансайхан, Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Уулбаян сумдын нутагт орших Гурвансайхан болон Өлзийтийн орд газруудыг шинээр нээж, нөөцийг улсын нөөцийн санд бүртгүүлсэн.

Тус ордуудыг ашиглах техник эдийн засгийн үндэслэл нь 2015 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлагдсан. Орд газруудыг газар дор уусган ашиглах аргаар олборлох бөгөөд төслийн нийт хөрөнгө оруулалт 204 сая ам.доллар, борлуулалтын орлого 1692 сая ам.доллар болох ба нийт улс, орон нутгийн төсөвт 286 сая ам.долларын орлого оруулж 396 ажлын байр шинээр бий болох юм.

Монгол-Хятадын хамтарсан төсөл-3

Монгол-Хятадын хамтарсан төслийн хүрээнд Дорнод аймгийн нутагт орших Гурванбулагийн орд газрыг эзэмшдэг бөгөөд уг ордын нөөцийн тайланг төв хүдрийн биет дээр шинээр боловсруулж 2011 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар оруулан Монгол улсын нөөцийн санд бүртгүүлсэн.

Тус ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг 2015 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар баталсан.

Ордыг далд уурхайн аргаар ашиглах бөгөөд төслийн нийт хөрөнгө оруулалт 259 сая ам.доллар, борлуулалтын орлого 1019 сая ам.доллар болох ба нийт улс болон орон нутгийн төсөвт 324.7 сая ам.долларын орлого оруулж 640 ажлын байр шинээр бий болох юм.

“Мон-Атом” ХХК нь “Эрдэнэс Монгол” ХХК-н 100%-н эзэмшлийн компани юм.

**Эрдэнэс метан ХХК**

Газрын тос ба байгалийн хийн салбарт “Эрдэнэс Метан” ХХК гэх төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК-н 100%-н эзэмшлийн компани байгаа боловч уг компани нь нэгтгэлд хамрагдаагүй болно. “Эрдэнэс Метан” ХХК нь гадаадын хөрөнгө оруулалт татах замаар Тавантолгой болон бусад ордын нүүрсний давхаргын метаний нөөцийг тогтоож, олборлолт хийж, Улаанбаатар хот болон зарим суурин газарт ахуйн хий нийлүүлэх замаар нүүрсний хэрэглээг багасгаж, улмаар агаарын бохирдлыг бууруулах, цаашид Монгол улсыг хий экспортлогч орон болгох зорилготой ажиллаж байна.

Эрдэнэс Ашид ХХК

Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт байрлах гурван талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулах зорилгоор “Эрдэнэс Ашид” ХХК-ийг “Эрдэнэс Монгол” ХХК “Монголын Алт” ХХК-тай хамтран байгуулсан.

Эрдэнэс Стийл ХХК

Монгол Улс дахь ган төмөрлөгийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор “Бэрэн групп” ХХК-тай хамтран кокс, ган төмөрлөгийн цогцолбор үйлдвэрийн төслийг санаачлан эхлүүлж, 2017 оны 04 дүгээр сард төсөл хэрэгжүүлэгч төрийн өмчийн оролцоотой “Эрдэнэс Стийл” ХХК-ийг байгуулан ажиллаж байна.

Эрдэнэс Алт Ресурс ХХК

“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, “Алт-2” үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор үнэт металл эрэх, хайх, олборлох, цэвэршүүлэх, борлуулах чиг үүрэг бүхий “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-г 2018 онд байгуулсан. “Эрдэнэс Алт Ресурс” ХХК нь “Эрдэнэс Монгол” ХХК-н 100%-н эзэмшлийн компани юм.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь зэс, молибдены хvdрийн олборлолт, баяжуулалтаар Ази тивдээ томоохонд тооцогддог Орхон аймагт байрладаг үйлдвэр юм. 1978 онд хоёр орны Засгийн газар хоорондын гэрээний дагуу “Эрдэнэтийн овоо”-ны орд газарт байгуулагдсан. 2016 онд Оросын Засгийн Газрын эзэмшиж байсан 49% Монгол улс дахь хувийн эзэмшилд шилжсэн ба Монгол улсын Засгийн газар 51%-г эзэмшдэг.

Орд газар нь Улаанбаатар хотоос баруун хойд зүгт 340 км, Дархан хотоос баруун зүгт 180 км, Булган аймгийн төвөөс хойд зүгт 60 км, мөн Оросын Холбооны Улсын хилээс 140 км-т тус тус байрладаг.

2010 оны 4-р сард “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн Зөвлөлийн ээлжит 43-р хуралдаанаар баталсан “Эрдэнэт” үйлдвэрийг 2010-2015 онд (2020 он хүртэл) хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн тоног төхөөрөмжийг эрчим хүч, цахилгаан энерги бага зарцуулдаг, байгаль орчинд ээлтэй орчин үеийн шинэ техник технологи нэвтрүүлэх замаар боловсронгуй болгож, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж 2015 оноос жилд 35 сая тн хүдэр боловсруулах, нэгж бүтээгдэхүүний зардлыг бууруулах, улмаар нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэн ажиллаж байна.

2018 онд орлогыг 2 их наяд төгрөгт, цэвэр ашгийг 400 орчим тэрбум төгрөгт хүргэж, улсын болон орон нутгийн төсөвт 650 орчим тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна³⁸.

Монголросцветмет ТӨҮГ

“Монголросцветмет” ТӨҮГ нь БНМАУ, ЗСБНХУ-ын (хуучин нэрээр) Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 1973 онд Монгол Улсын нутаг дэвсгэрт хайлуур жонш, үнэт металл болон бусад төрлийн ашигт малтмалыг олборлон баяжуулах, эрдэс түүхий эдийн нөөцийг өсгөх, улсын экспортын чадавхыг нэмэгдүүлэх зорилготойгоор байгуулагдсан.

Үйлдвэрийн газар нь:

- Хайлуур жоншны хүдэр олборлолт, баяжуулалт;
- Төмрийн хүдэр олборлолт, баяжуулалт;
- Алт олборлолт, баяжуулалт;
- Хайрга, дайрга, элс үйлдвэрлэл

Өнөөдрийн байдлаар үйлдвэрийн газар нь Улаанбаатар хотод Захиргаа, Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд орших “Бор-Өндөр” уулын баяжуулах үйлдвэр, Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Шижири алт” ХХК, “Зэрэгцээ” алтны үйлдвэрүүдийг багтаан үйл ажиллагаа явуулж байна.

Оросын Засгийн Газрын эзэмшиж байсан 49% Монгол улс дахь хувийн эзэмшилд 2016 онд шилжсэн ба Монгол улсын засгийн газар 100% эзэмшиж байна³⁹.

³⁸ Эх сурвалж: <https://www.erdnetmc.mn>

³⁹ Эх сурвалж: <http://www.mongolros.mn>

2.7.2.2 Орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүд

Тавантолгой ХК

ЗГ-ын өмч хувьчлалын хурлын комиссын 42 тоот тогтоолын дагуу 1994 онд төрийн өмч давамгайлсан Тавантолгой ХК үүсгэн байгуулагдсан. 1995 оноос эхлэн Тавантолгой ХК нь орон нутгийн өмчит компани хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тавантолгойн чулуу нүүрсний орд нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт, сумын төвөөс баруун урагш 18км-т оршдог.

Тавантолгойн коксждог нүүрс нь дэлхийн хэмжээнд нөөцийн хэмжээгээр эхний 10-т багтдаг. Тавантолгойн орд нь дэд бүтцээс нэлээд алслагдсан хэдий ч 6.5 тэр бум гаруй нөөцтэй. Үүнээс 4-р хэсгийн пласт нь ордын төвд, нөхцөл нь хамгийн сайн, нөөцийн хувьд 100-аас дээш жил үргэлжлэх боломжтой. Ордыг 1966-оноос эхэлж ил уурхайгаар ашиглаж Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн төв болон ойролцоох сумдын нүүрсний хэрэгцээг хангаж ирсэн.

Могойн гол ХК

Могойн голын чулуун нүүрсний орд нь Улаанбаатар хотоос 880 км, Хөвсгөл аймгийн Мөрөн хотоос 209 км, Завхан аймгийн Улиастай хотоос 226 км зайд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт оршино. Могойн голын нүүрсний уурхай 1971 онд ашиглалтад орсон. Могойн гол ХК нь Хөвсгөл аймгаас гадна Завхан аймгийн төв болон зүүн чиглэлийн сумдыг эрчим хүчний нүүрсээр хангадаг.

Баянтээг ХК

Баянтээг ХК нь 1961 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд нүүрсний уурхайн орд газар нь Өвөрхангай аймагт буюу Улаанбаатар хотоос 560 км зайтай байрладаг. 1995 онд хувьцаат компани болж дахин зохион байгуулагдсан ба хувьцааны 70% нь төрийн эзэмшилд байдаг. 1994 оноос хойш Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй байна.

2.7.3 Засгийн газар болон ТӨААН-үүдийн хоорондын санхүүгийн харилцааг зохицуулсан үндсэн дүрэм журам

Засгийн газар болон ТӨААН-үүдийн хоорондын харилцааг Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль болон хуулийн дагалдах Төрийн өмчийг хэрэгжүүлэх журмуудаар зохицуулдаг. Энэхүү хуульд тусгайлан заагаагүй бол Засгийн газар болон ТӨААН-үүдийн хоорондын харилцааг Компанийн тухай хууль болон тухайн төрийн өмчит аж ахуйн нэгжийн компанийн дүрмээр зохицуулдаг

1996 онд УИХ-аас төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилт бүхий Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг баталсан.

Хуулийн 21.15 дугаар зүйлд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, тэдгээрээс төсвийн байгууллагын санхүү болон мөнгөн хөрөнгийн гүйлгээнд нөлөөлөх байдал, ажлын үр дүнд хяналт тавина гэж заасан. /Энэ хэсгийг 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

Хуулийн 21.16 дугаар зүйлд Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана. /Энэ хэсгийг 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 13 дугаар заалтад Төрийн мэдлийн хувьцаа эзэмшигч нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс олгох ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох саналыг төлөөлөн удирдах зөвлөлд бичгээр гаргана. Харин Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт Компанийн дүрмд өөрөөр заагаагүй бол ТУЗ (эсвэл Хувьцаа эзэмшигчдийн хурал ТУЗ-ийг орлож) ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг хуваарилах өдөр зэргийг тогтооно гэж заасан байна.

2.7.4 Засгийн Газар болон ТӨААН-үүдийн санхүүгийн харилцааг зохицуулах практик

Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргах зорилт дэвшүүлсэн.

2018 онд ОУ-ийн нийт орлогод оруулсан хувь нэмэр дээр нь үндэслэн 7 ТӨААН-үүдийг материаллаг гэж үзсэн. Хараат бүс хянагч-нэгтгэгч эхлэлтийн үе шатанд ОТАХ нийт 202 компаниудыг хамгийн их материаллаг төлбөр төлсөн учир нэгтгэлд хамруулахаар зөвшилцсөн. Эдгээр 7 ТӨААН-үүд эдгээр 202 компанийн тоонд багтсан юм.

ОУИТБС-ын стандартын ТӨААНүүдтэй холбоотой шаардлагуудыг багтаасан тусгай маягтыг Засгийн Газарт материаллаг төлбөр хийсэн 7 ТӨААН-үүд рүү явуулсан. Энэ маягтад ТӨААН болон Засгийн Газрын хоорондын санхүүгийн харилцаа, зээл болон зээлийн баталгаа, шилжүүлэг болон төсвийн шинжтэй зарцуулалт гэх мэт стандарт шаардлагуудыг багтаасан. Мөн бид аудитлагдсан санхүүгийн тайлангуудыг ТӨААН-с хүссэн. Үүнээс “Эрдэнэс Таван Толгой” ХК, “Шивээ-Овоо” ХК нь Үндэсний Аудитын Газраар аудитлагдсан санхүүгийн тайлангаа явуулсан бол “Багануур” ХК нь иж бүрэн тайлан ирүүлээгүй зөвхөн аудитын санал дүгнэлтээ явуулсан байна.

Доорх хүснэгтэд зарим ТӨААН-үүдийн аудитлагдсан санхүүгийн тайлан дахь 2018 оны хуримтлагдсан ашиг болон цэвэр ашиг(алдагдал)-ийг харууллаа:

№	Регистрийн дугаар	Компанийн нэр	2018 онд хуримтлагдсан ашиг (сая.төг)	Цэвэр ашиг (алдагдал) (сая.төг)	Ногдол ашиг
1	5435528	“Эрдэнэс Таван Толгой” ХК	807,826.92	807,562.2	-
2	2004879	“Шивээ-Овоо” ХК	3,474.97	(2,631.67)	-

2.7.4.1 Зээл болон зээлийн баталгаа

Нэгтгэлд хамрагдсан ТӨААН-үүдээс Засгийн газар болон ТӨААН-үүдээс авсан зээл, зээлийн баталгаа болон бусад ТӨААН-үүдэд олгосон зээл, зээлийн баталгааны мэдээллийг хүссэн. Үүнээс “Могойн Гол” ХК болон “Багануур” ХК мэдээллээ ирүүлсэн ба эдгээр нь Засгийн газар болон ТӨААН-с ямар нэгэн зээл аваагүй болно.

Монгол улсын хөгжлийн банкнаас уул уурхай, газрын тосны төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжүүдэд олгосон зээл, зээлийн баталгааны үлдэгдэл 2018 оны 12 сарын 31-ээр 53,155,796,719.38 төгрөг байна.

Монгол улсын Хөгжлийн банкнаас уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дараах төслүүдийг санхүүжүүлсэн. Үүнд:

№	Төслийн нэр	Төслийн эхлэх дуусах хугацаа	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Зээлдэгч
1	Багануурын нүүрсний уурхайн хүчин чадлыг өргөтгөх	2013 он – 2018.04 сар	18,6 тэрбум төгрөг	18,6 тэрбум төгрөг	-
2	Эрдэнэс Оюу Толгой	2014.11 сар	10 сая ам доллар	2,5 сая ам доллар	Сангийн яам

Дээрх төсөл хөтөлбөрийн талаар товч танилцуулбал:

Багануурын нүүрсний уурхайн хүчин чадлыг өргөтгөх

“Багануур” ХК-ийн нүүрс тээврийн 4, хөрс тээврийн 4 автомашин, 1 бульдозер худалдан авах, нүүрс бутлан ачих байгууламжийг өргөтгөх зорилгоор уг төсөл хэрэгжсэн ба үүний үр дүнд нүүрс олборлолт 10%, хөрс хуулалт 11%-аар тус тус өссөн байна. Нүүрс бутлан ачих байгууламжийг өргөтгөснөөр нүүрс бутлах ачих хүчин чадал жилийн 4.5 сая тонн болон өссөн. Уг төсөл нь 2018 оны 4 сард 100% гүйцэтгээд дууссан.

Эрдэнэс Оюу Толгой

Оюутолгойн далд уурхайг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилготой ба Монгол улсын стратегийн ач холбогдол бүхий орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар Монгол Улсын ДНБ-ийн хэмжээ, экспортын хэмжээ, валютын дотогшлох үрсгалыг нэмэгдүүлж, гадаад худалдааны болон төлбөрийн тэнцэлд эерэг өөрчлөлтүүд бий болно.

2.7.4.2 ТӨААН-үүдийн хоорондын гүйлгээ

Нэгтгэлд хамрагдсан ТӨААН-үүдээс тайлант хугацаанд хийгдсэн хоорондын гүйлгээний мэдээллийг хүссэн ба хоорондын гүйлгээтэй холбоотой мэдээлэл ирээгүй байна.

2.7.4.3 ТӨААН-үүдэд хийгдсэн хөрөнгө оруулалт

Нэгтгэлд хамрагдсан ТӨААН-үүдээс тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалтын мэдээллийг хүссэн. “Эрдэнэс Таван Толгой” ХК-н мэдээлэл ирсэн нь ямар нэгэн хөрөнгө хийгдээгүй гэж мэдүүлснээс өөр хөрөнгө оруулалттай холбоотой мэдээлэл ирээгүй байна.

3 Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ерөнхий тойм

3.1 Уул уурхайн салбар

Түүхэндээ Монгол Улсын эдийн засаг нь мал аж ахуй, газар тариалангаас хамаарч байсан боловч сүүлийн жилүүдэд уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай болж байна. 2015 онд Монгол улс дэлхийн жоншны үйлдвэрлэлийн 3 хувийг дангаараа бүрдүүлж байв. Үүнээс гадна нүүрс, зэс, алт, газрын тос, ураны асар их нөөцтэй билээ.

Уул уурхайн салбар нь манай улсын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг. Улсын нутаг дэвсгэрийн нэлээдгүй хэсэгт геологи хайгуулын ажил хийснээр ашигт малтмалын асар их нөөцийг олж илрүүлжээ. Сүүлийн гурван жилийн дунджаар уул уурхайн салбар нь ДНБ-ий 23.03%-ийг эзэлж байгаа бөгөөд 2018 онд ДНБ-д эзлэх хувь өмнөх оноос 0.2%-иар өссөн байна. Улсын нийт аж үйлдвэрлэлд уул уурхайн салбарын эзлэх хувь сүүлийн 3 жилийн дунджаар 57,63% байв.

Монгол Улс 6,000 гаруй ашигт малтмалын орд, 80 гаруй төрлийн ашигт малтмал бүхий асар том нөөцтэй бөгөөд хайгуулын ажил жилээс жилд өргөжиж зэс, алт, нүүрс, уран болон бусад төрлийн ашигт малтмалын илрүүлсээр иржээ.

3.1.1 Стратегийн ач холбогдол бүхий ордууд

“Ашигт малтмалын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 1.5-д “Засгийн газар нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох тухай саналыг Улсын их хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасан байна.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд нь үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн түвшинд улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд болзошгүй нөлөөтэй байж болох эсхүл тухайн жилд нийт ДНБ-ний 5%-иас илүү үйлдвэрлэх боломжтой эсвэл үйлдвэрлэж байгаа ордууд юм.

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт болон 2015 оны 1 дүгээр сарын 23-ний өдрийн 11 тоот тогтоолоор батлагдсан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын 16 ордуудын товч мэдээллийг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

№	Ордууд	Ашигт малтмалын төрөл	Байршил	Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд	Эзэмшлийн хувь	
					Төр	ААН
1	Асгат	Мөнгө	Баян-Өлгий, Ногооннуур	Эрдэнэс Монгол ХХК	100	0
2	Багануур	Нүүрс	Улаанбаатар, Багануур	Багануур ХК	75	25
3	Бороо	Алт	Сэлэнгэ, Баянгол	Бороо гоулд ХХК	0	100
4	Бүрэнхаан	Фосфорит	Хөвсгөл, Алаг-Эрдэнэ	Сутайхэн цо ХХК Топруонхэнцо ХХК Талст маргад ХХК	0	100
5	Гацуурт	Алт	Сэлэнгэ, Мандал	Сентеррагоулд Монголия ХХК	Хэлэлцэж байна	
6	Гурванбулаг	Уран	Дорнод, Дашбалбар			
7	Дорнод	Уран	Дорнод, Дашбалбар			
8	Мардай	Уран	Дорнод, Дашбалбар	Адамасмайнинг ХХК		
9	Нарийн сухайт	Нүүрс	Өмнөговь, Гурвантэс	Монголын Алт МАК ХХК Чинхуа МАК Нарийн Сухайт ХХК Саус гоби сэндс ХХК Өсөх зоос ХХК	0	100
10	Оюу толгой	Зэс, алт	Өмнөговь, Ханбогд	Оюу толгой ХХК Онтрэ ХХК	34	66
11	Таван толгой	Нүүрс	Өмнөговь, Цогтцэций	Тавантолгой ХК Энержи Ресурс ХХК Эрдэнэс Таван Толгой ХХК	51 0 100	49 100 0
12	Төмөртэй	Төмөр	Сэлэнгэ, Хүдэр	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК	100	
13	Төмөртэйн овоо	Цайр	Сүхбаатар, Сүхбаатар	Цайрт Минералс ХХК		100
14	Шивээ овоо	Нүүрс	Говьсүмбэр, Сүмбэр	Шивээ-Овоо ХК Эрдэнэс Монгол ХК Эйкүсора ХХК	90	10
15	Цагаан суварга	Зэс, молибден	Дорноговь, Мандах	Эрдэнэс Цагаан Суварга ХХК Монголын Алт МАК ХХК	0	100
16	Эрдэнэтийн овоо	Зэс, молибден	Орхон, Баян-Өндөр	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	51	49

3.1.2 Монгол Улсын ашигт малтмалын нөөц

Монголын Ашигт малтмалын нөөцийг Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ) бүртгэж, тайлагнадаг. Эрдэнэтийн зэсийн ордын баруун, төв хэсгийн нөөц тодотголоор шинэчлэгдэн бүртгэгдсэн. Доорх хүснэгтэд ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэгдсэн нөөцийн сүүлийн 2 жилийн мэдээллийг хураангуйлан харуулав⁴⁰:

Ордын төрөл	Хэмжих нэгж	2017		2018	
		Хүдэр/шлих	Металл	Хүдэр/шлих	Металл
Алт (үндсэн)	мян.тн/кг	8,413	3,212	6,537.9	18,697.9
Алт (шороо)	кг	3,375	3,015	5,140.2	4,600.6
Төмөр	мян.тн	45,656	11,871	44,969.8	18,287.9
Холимог металл	мян.тн	-	-	167,692.3	-
Зэс	тн	-	-	-	51,909
Цайрын исэл	тн	-	77.7	-	-
Цайр	тн	-	-	-	1,174,190
Хар тугалга	тн	-	83	-	606,274
Гянтболдын исэл	тн	-	1,636	-	-
Алт	кг	-	-	-	512,904
Гянтболд	мян.тн	503	4.4	36.6	1.4
Газрын ховор элемент	мян.тн	-	-	356.8	125.16
Зэс молибден холимог	мян.тн	-	-	55,871.2	-
Зэс	тн	29,183	135	-	149.1
Молибден	тн	-	-	-	2.2
Цагаан тугалга	мян.тн	-	1	-	-
Хайлуур жонш	мян.тн	1,178	665	6,932	1,239.1
Уран	мян.тн	-	-	51,583.2	15.5
Нүүрс	сая тн	3,579.7	-	9,662.7	-
Мөнгө	тн	-	-	-	132,224.9
Шохойн чулуу	сая тн	186	-	52.7	-

3.1.3 Уул уурхайн хайгуулын ажил

Түсгай зөвшөөрлийн талбайд хувийн хөрөнгөөр гүйцэтгэх хайгуулын ажлын төлөвлөгөө болон гүйцэтгэсэн тайлан, зардал хянуулсан, баталгаажуулсан байдлын хувьд Ашигт малтмалын тухай хуулийн 48.1.1-д заасны дагуу түсгай зөвшөөрөл эзэмшигчдээс жил бүрийн хайгуулын ажлын төлөвлөгөө, 48.1.2-д заасны дагуу хайгуулын ажлын жил тайланг хүлээн авч хянах бөгөөд 33.1, 33.2-т заасны дагуу хайгуулын ажлын зардлын доод хэмжээг хянаж, санхүүгийн тайланд тулгуурлан баталгаажуулдаг.⁴¹:

	2016	2017	2018
Төлөвлөгөө			
Ирүүлэх ёстой	2,051	1,748	1,695
Ирүүлсэн	1,750	1,724	1,674
Ирц	85.3%	98.6%	98.8%
Тайлан			
Ирүүлэх ёстой	1,974	1,745	1,408
Ирүүлсэн	1,666	1,546	1,300
Ирц	83.0%	88.5%	92.3%
Хайгуулын ажлын тайлангийн зардлын доод хэмжээг хянасан хувь	99.7%	98.0%	10.0%
Зардал санхүүгийн тайлангаар баталгаажсан хувь	94.9%	90.8%	8.0%

⁴⁰ Эх сурвалж: [Эрдэс баялгийн статистик мэдээ 2018, Ашигт малтмал газрын тосны газар \(АМГТГ\)](#)

⁴¹ Эх сурвалж: [Эрдэс баялгийн статистик мэдээ 2018, Ашигт малтмал газрын тосны газар \(АМГТГ\)](#)


Монгол Улсын нутаг дэвсгэрт /2018 оны 12 дугаар сарын 30/-ны байдлаар Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй нийт 35 төсөл хэрэгжиж байна. Үүнд:

- 1:50,000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 27
- 1:50,000-ны масштабтай геологийн бүлэгчилсэн зураглал, ерөнхий эрлийн ажлын 3
- 1:200,000 –ны масштабтай Улсын геологийн зураг зохиох 3
- Монгол орны металлогений, ашигт малтмалын ордуудын тархалтын зүй тогтлын судалгаа 1 АМС-17
- Налайх чичирхийлэл, УБ геоэкологи-гидрогеологи, Гадаад хамтын ажиллагааны 1

Доорх хүснэгтэд сүүлийн 3 жилийн хугацаанд улсын төсвийн хөрөнгөөр хийсэн геологи, судалгааны ажлын мэдээллийг харууллаа⁴²:

Ажлын төрөл	2016 он		2017 он		2018 он	
	сая.төг	хувь	сая.төг	хувь	сая.төг	хувь
Улсын геологийн зураглал 1:200,000	642.7	100%	482.3	100%	408.5	100%
Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил 1:50,000	4,975.8	100%	5,355.9	100%	4,692.7	100%
Сэдэвчилсэн ажил	3,476.1	100%	6,274.6	80,8%	8,144.1	100%
Хамтын ажиллагааны төсөл	246.6	100%	142.4	100%	90.0	100%
Нийт	9,341.1	100%	12,255.1	91,8%	13,335.0	100%

Доорх диаграмд улсын төсвийн хөрөнгөөр геологи, судалгааны ажилд зарцуулах зардлын төлөвлөгөө болон гүйцэтгэлийг сая төгрөгөөр илэрхийлэн харууллаа.



⁴² Эх сурвалж: [Эрдэс баялгийн статистик мэдээ 2018, Ашигт малтмал газрын тосны газар \(АМГТГ\)](#)

3.1.4 Уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба экспорт

3.1.4.1 Нүүрс

Монгол Улс нүүрсний нөөцөөр дэлхийд эхний 10 орны тоонд багтдаг. Одоогийн байдлаар 15 сав газрын 300 гаруй орд, илрэл байгаа бөгөөд Монгол орны нүүрсний геологийн таамаг нөөц 173.3 тэрбум тонн бөгөөд цаашдаа өсөх боломжтой.

2018 онд 54.6 сая тонн нүүрс олборлосон нь өмнөх оноос 3.3 сая тонн буюу 6.8 хувиар, 2009 оноос 37.0 сая тонн буюу 3.6 дахин өссөн байна.

Нийт олборлосон нүүрсний 32.0 сая тонн буюу 62.3 хувийг экспортолсон бөгөөд өмнөх оноос 3.1 сая тонн буюу 10.7 хувиар, 2009 оноос 24.9 сая тонн буюу 4.5 дахин өсөж, нүүрс нь экспортын тэргүүлэгч бүтээгдэхүүн болсон.

Доорх хүснэгтэд сүүлийн 3 жилийн нүүрсний олборлолт, борлуулалт болон экспортын мэдээг харууллаа⁴³.

Он	Хөрс хуулалт (мян.м3)	Олборлолт (мян.тн)	Борлуулалт (мян.тн)	Экспорт (мян.тн)
2016	102,374.3	35,096.5	33,831.7	25,809.3
2017	197,240.8	49,480.3	41,904.6	33,400.1
2018	244,861.2	54,572.3	45,741.9	36,671.4

Доорх хүснэгтэд нүүрсний 2018 оны нийт борлуулалтын мэдээг нүүрсний төрлөөр нь харууллаа⁴⁴.

Нүүрсний төрөл	Экспорт	Дотоод	Бүгд
Чулуун баяжуулсан коксжих	5,479.5	-	5,479.5
Чулуун түүхий коксжих	14,404.2	-	14,404.2
Чулуун сул коксжих	11,680.5	-	11,680.5
Чулуун эрчим хүчний	5,107.2	-	5,107.2
Чулуун болон хүрэн	-	9,069.6	9,069.6
Бүгд	36,671.4	9,069.6	45,741.0

2018 онд 2,786.2 сая ам.долларын 35.8 сая тонн чулуун нүүрс экспортолсныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал үнийн дүнгээр 529.6 сая ам.доллар, тоо хэмжээний хувьд 2,767.3 мянган тонноор тус тус их байна. Чулуун нүүрсний 98.9% БНХАУ руу экспортлогдсон байна.

3.1.4.2 Алт

Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль 2009 онд батлагдан, хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор алтны үйлдвэрлэлийн хэмжээ харьцангуй буурч байсан билээ. Засгийн газраас алтны олборлолтыг дэмжиж хууль эрхзүй, татварын таатай нөхцөл бүрдүүлснээр 2013 оноос үйлдвэрлэл өссөн. Цаашид ч алт олборлолтыг нэмэгдүүлэх шаардлагатай хэмээн үзэж, 2016 онд Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монгол Банкны хамтарсан ажлын хэсэг байгуулагдан, “Алт-2” хөтөлбөрийг боловсруулж, 2017 оноос хэрэгжүүлж эхлээд байна. (Ашигт малтмал, газрын тосны газар) 2018 онд 20.7 тонн алт олборлосон нь өмнөх оноос 0.9 тонн буюу 4.1 хувиар, 2013 оноос 11.8 тонн буюу 2.3 дахин, 2009 оноос 11.4 тонн буюу 2.2 дахин өссөн байна. Нийт олборлосон алтны 3.4 тонн буюу 16.6 хувийг экспортолсон бөгөөд өмнөх оноос 11.2 тонн буюу 76.5 хувиар, 2013 оноос 4.2 тонн буюу 54.8 хувиар, 2009 оноос 7.5 тонн буюу 68.5 хувиар буурсан байна.

Дараах диаграммаар сүүлийн 3 жилийн алтны олборлолт болон экспортын мэдээг нэгтгэн харууллаа⁴⁵.



⁴³ Эх сурвалж: [Эрдэс баялагийн статистик мэдээ 2016, 2017, 2018, Ашигт малтмал газрын тосны газар \(АМГТГ\)](#)

⁴⁴ Эх сурвалж: [Геологи, хайгуулын хэлтэс, Ашигт малтмал газрын тосны газар \(АМГТГ\)](#)

⁴⁵ Эх сурвалж: [Аж үйлдвэрийн салбар 2018, Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо](#)

3.1.4.3 Бусад ашигт малтмал

Уул уурхай, олборлох үйлдвэрийн бусад нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг авч үзвэл, 2018 онд хайлуур жоншны баяжмал 25.5 мянган тонн буюу 46.2 хувиар, цайрын баяжмал 5.2 мянган тонн буюу 6.2 хувиар өсөж, харин молибдений баяжмал 0.3 мянган тонн буюу 4.7 хувиар, хайлуур жонш 7.7 мянган тонн буюу 7.1 хувиар, төмрийн хүдэр 1.5 сая тонн буюу 19.1 хувиар, төмрийн хүдрийн баяжмал 269.5 мянган тонн буюу 7.3 хувиар, гянтболдын баяжмал 0.2 мянган тонн буюу 30.2 хувиар буурсан байна.

Бусад ашигт малтмалын олборлолтын мэдээллийг доорх хүснэгтэд мянган тонноор илэрхийлэн харууллаа⁴⁶:

Ашигт малтмалын төрөл	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Зэсийн баяжмал, металын агуулгаар	1,080.4	1,334.7	1,445.1	1,317.6	1,310.8
Молибдений баяжмал, металын агуулгаар	4.1	5.2	5.2	5.8	5.5
Хайлуур жонш	303.0	183.5	167.7	108.9	101.2
Хайлуур жоншны баяжмал	71.9	47.3	34.1	55.2	80.7
Төмрийн хүдэр	6,293.1	4,273.6	4,936.2	7,694.7	6,225.4
Төмрийн хүдэр баяжмал	3,967.4	1899.8	2,209.9	3,675.0	3,405.5
Цайрын баяжмал	93.2	89.6	100.2	82.7	87.9
Гянтболдын баяжмал	1.0	1.0	0.7	0.6	0.4

3.1.5 Экспортын хэсэг

Монгол Улсын эдийн засаг, тэр дундаа орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг уул уурхайн салбарын бодит өсөлт төсөөлсөн хэмжээнээс сайжирч эдийн засаг дахь бодит өсөлт 2018 онд 6.9 хувьд хүрсэн. Тодруулбал, зэсийн баяжмалын экспорт 1,436.7 тоннд хүрсэн бөгөөд жилийн дундаж үнэ тонн тутамд 6,524.8 ам.долларт хүрсэн, нүүрсний экспорт 36.3 тоннд хүрч төсөөлсөн хэмжээнээс 30 хувиар, нүүрсний үнэ дунджаар 44 хувь өссөн байна.

Доорх хүснэгтэд олборлох салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн нийт орлогын хэмжээ, улсын төсөвт эзлэх хувийн хамт харууллаа⁴⁷.

2018 он	
Нэгдсэн төсвийн нийт орлого, тэрбум төгрөг	10,172.8
Уул уурхай, олборлолт	2,393.6
Эзлэх хувь	23.5%

Доорх хүснэгтэд олборлох салбарын хийж буй экспортын хэмжээ, нийт экспортод эзлэх хувийн хамт харууллаа⁴⁸.

2018 он	
Эрдэс бүтээгдэхүүний экспорт, сая ам доллар	6,070.3
Уул уурхай, олборлолт	7,011.8
Эзлэх хувь	86.6%

⁴⁶ Эх сурвалж: [Аж үйлдвэрийн салбар 2018, Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо](#)

⁴⁷ Эх сурвалж: [Сангийн Яам](#)

⁴⁸ Эх сурвалж: [Үндэсний Статистикийн Хороо](#)

Доорх хүснэгтэд 2017 болон 2018 оны ашигт малтмалын экспортын мэдээллийг харууллаа⁴⁹.

Барааны нэр	2017			2018			Өөрчлөлт	
	Тоо хэмжээ /мян/	Үнийн дүн /мян.доллар/	дундаж үнэ /доллар/	Тоо хэмжээ /мян/	Үнийн дүн /мян. доллар /	дундаж үнэ /доллар/	Тоо хэмжээ /мян/	Үнийн дүн /мян. доллар /
Эзсийн баяжмал, тн	1,447.2	1,613,117.3	1,114.6	1,436.8	2,012,194.4	1,400.5	(10.5)	399,077.1
Төмрийн хүдэр, тн	6,258.0	313,363.1	50.1	7,449.1	342,186.1	45.9	1,191.1	28,823.0
Цайрын хүдэр, баяжмал, тн	118.2	180,809.2	1,529.4	123.9	197,806.4	1,596.3	5.7	16,997.2
Жонш, тн	319.3	84,218.4	263.7	555.2	189,857.6	341.9	235.9	105,639.2
Молибден хүдэр, баяжмал, тн	6.5	37,358.7	5,744.6	6.0	49,939.4	8,332.6	-0.5	12,580.8

- 2018 онд 2786.2 сая ам.долларын 35.8 сая тонн чулуун нүүрс экспортолсныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал үнийн дүнгээр 529.6 сая ам.доллараар, тоо хэмжээний хувьд 2767.3 мянган тонноор тус тус их байна. 2017 онд 1 тонн нүүрсний хилийн дундаж үнэ 68.4 ам.доллар байсан бол энэ онд 77.9 ам.доллар болж өгчээ. Чулуун нүүрсний 98.9 % БНХАУ-руу гаргасан байна.
- 2018 онд 1436.7 мянган тонн эзсийн баяжмал экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 10.5 тонноор бага байгаа ба хилийн дундаж үнэ 1114.6 ам.доллараас 1400.5 ам.доллар болж 285.9 ам.доллараар өссөн байна. 2017 онд эзсийн баяжмалын экспорт үнийн дүнгээр 1613.1 сая ам.доллар байсан бол 2018 онд 2012.2 сая ам.доллар болжээ.
- Боловсруулаагүй нефтийн экспорт 6189.8 мянган баррель буюу 392.0 сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны гүйцэтгэлээс 1324.4 мянган баррелиар бага ба үнийн дүнгээр 17.9 сая ам.доллараар их байна. 1 баррель нефтийн хилийн дундаж үнэ 49.8 ам.доллар байсан бол тайланд хугацаанд 63.3 ам.доллар болж өгчээ.
- Төмрийн хүдрийн экспорт 7.4 сая тонн буюу 342.2 сая ам.долларт хүрсэн байна. 2017 оны гүйцэтгэлтэй харьцуулахад уг бүтээгдэхүүний экспорт 1191.0 мянган тонноор, үнийн дүн нь 28.8 сая ам.доллараар тус тус өгчээ. 1 тонн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 45.9 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 4.1 ам.доллараар буурсан байна.
- Цайрын баяжмал: 2018 онд 123.9 мянган тонн цайрын баяжмалын 1 тонныг дунджаар 1596.3 ам.доллараар экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хилийн дундаж үнэ 66.9 ам.доллараар өссөн байна. Цайрын баяжмалын экспорт үнийн дүнгээр 197.8 сая ам.доллар болж, өнгөрсөн оныхоос 17.0 сая ам.доллараар өгчээ.
- 2018 онд 189.9 сая ам.долларын 555.2 мянган тонн жонш экспортолсон нь 2017 оны гүйцэтгэлээс 235.9 мянган тонноор, үнийн дүнгээр 105.6 сая ам.доллараар тус тус өссөн байна. Жоншны экспортын дундаж үнэ 341.9 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 78.2 ам.доллараар өссөн байна. Жоншийг БНХАУ, ОХУ, Украин, Узбекистан, Беларусь руу экспортолсон ба 34.2 хувь ОХУ-д, 65.7 хувь БНХАУ-д тус тус ногдож байна.
- Молибдены баяжмалын экспорт үнийн дүнгээр 49.9 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 12.6 сая ам.доллараар өссөн байна. Тус бүтээгдэхүүний нэг тонны экспортын хилийн дундаж үнэ 5744.6 ам.доллараас 8332.6 ам.долларт хүрч, 2588.0 ам.доллараар өгчээ. 2018 онд 5993.2 тонныг экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс 510.0 тонноор бага байна. Молибдены баяжмалын 88.9 хувийг БНХАУ-руу гаргасан байна.
- 2018 онд 3431.9 кг алт экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 11122.6 кг-аар бага байна. Алтны экспортын дундаж үнэ 2017 онд 40905.1 ам.доллар байсан бол энэ онд 42104.9 ам.доллар болж 1199.8 ам.доллараар өссөн байна. Алтны экспорт үнийн дүнгээр 144.5 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 450.8 сая ам.доллараар буурчээ.

Экспортын бүтэц 2018 оны байдлаар авч үзвэл, нийт экспортын 86.6 хувь эрдэс бүтээгдэхүүнд; 2.1 хувь алтны экспортод, 5.8 хувь нэхмэлийн материал болон нэхмэл эдлэлийн экспортод тус тус ногдож байна.

⁴⁹ Эх сурвалж: [Гаалийн Ерөнхий Газар](#)

3.1.6 Гар аргаар ашигт малтмал олборлох буюу бичил уурхай

3.1.6.1 Гар аргаар ашигт малтмал олборлох буюу бичил уурхайн ерөнхий тойм

Гар аргаар ашигт малтмал олборлох буюу Бичил уул уурхай гэдэг нь өргөн утгаараа Монгол Улсын нутаг дэвсгэрт нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн (ихэвчлэн хууль бус) эрхэлж буй ашигт малтмал олборлох үйл ажиллагааг хэлнэ. БУУ-н үйл ажиллагааны улирлын шинж чанар, тогтворгүй байдал болон албан ёсны статистик мэдээллийн дутмаг байдлаас шалтгаалан энэхүү тайланд бичил уул уурхайн салбарыг Монгол Улсын голлох олборлох салбарын тоймоос тусад нь авч үзсэн болно.

2019 онд АМГТГ-т ирүүлсэн мэдээллээр бичил уул уурхайн зориулалтаар ашиглаж байгаа талбай нь 375.54, эвдрэлд оруулсан талбай 126.75 байна. Харин бичил уурхай эрхлэгчдийн тоо улсын хэмжээнд 1,508 байгаагаас 1,902 эрэгтэй, 417 эмэгтэй байна. Үүнээс хамгийн олон бичил уурхай эрхлэгчидтэй аймгууд Булган аймаг 234, Баянхонгор 226, Дорноговь 153, Сэлэнгэ 362, Хэнтий аймагт 364 бичил уурхай эрхлэгчид байна.

3.1.6.2 Хууль, эрх зүйн орчин

2010 онд Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Засгийн газрын 308 дугаар тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” батлагдсан. 2014 оны 1 дүгээр сард УИХ-ын 18 дугаар тогтоолоор 2014-2025 он хүртэл Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг баталсан. Энэхүү бодлогын бичиг баримтад зааснаар төрөөс “бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийг хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг төрөөс бодлогоор дэмжиж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох” бодлого баримталж байгаа юм.

“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” хэрэгжсэн өнгөрсөн жилүүдэд журмыг шинэчлэн боловсруулах эрх зүйн болон практик шаардлагууд гарч ирсэн. Иймд бичил уурхайн холбогдох талуудын санаа, бодлыг тусган “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулж Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 151 дүгээр тогтоолоор баталсан байна. Уг шинэчлэн батлагдсан журам нь бичил уурхайн албажуулалтын хүрээг тэлэхэд эерэг үр нөлөө үзүүлээд зогсохгүй журмын дагуу бичил уурхайчид хуулийн этгээдийн нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйл ажиллагаа явуулж татварын холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар төлдөг болсноор бичил уурхайгаас улс орны эдийн засагт оруулж буй хувь нэмрийг бодитойгоор тооцох боломж бүрдүүлнэ.

Энэхүү тогтоолд аймгуудын засаг захиргааны чадавхыг бэхжүүлэх, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэхээр заасан. Аймгийн засаг захиргаа нь сумын БУУ-н үйл ажиллагааны тайланг нэгтгэн АМГТГ-т хүргэхээр үүрэг болгосон. Мөн тогтоолд бичил уурхайн аюулгүй байдлын дүрэм (АМГ-ын даргын 2011 оны 153-р тушаал, Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм)- ийг дагаж мөрдөх, бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг тусгасан байна.

Өнөөдрийн байдлаар Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хоршооны тухай хууль, Нөхөрлөлийн тухай хуулиуд бичил уул уурхайн үйл ажиллагаанд мөрдөгдөж байна. Мөн Бичил уул уурхайгаар ашигт малтмал олборлох журам, “АЛТ-2” Үндэсний хөтөлбөр зэрэг засгийн газрын тогтоолууд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/115, А/123 дугаар тушаал буюу Бичил уурхайн аюулгүй байдлын дүрэм болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/269, А/182 дугаар тушаал буюу Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал зэрэг тушаалууд мөрдөгдөж байна. Мөн 2019 онд Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаарх авах арга хэмжээний тухай 355-р тогтоол батлагдсан.

3.1.6.3 Бичил уул уурхайн эдийн засагт оруулж буй хувь нэмэр

Бичил уурхай нь олон хүний хувьд ядуурлаас гарах, амьжиргаагаа залгуулах чухал хэрэгсэл болж байгаа төдийгүй үндэсний болон орон нутгийн эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байна. Бичил уурхайчид олборлосон алтаа албан ёсны сүлжээгээр дамжуулан борлуулснаар Монгол банкны гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байгаагаас гадна шууд болон шууд бусаар ажлын байрыг бий болгож, орон нутгаас төв рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг саармагжуулж, өрхийн орлогыг нэмэгдүүлж байна. Гэсэн хэдий ч Монгол Улсын алтны нийлүүлэлтийн сүлжээ бүрэн албажаагүй хэвээр байна. Монгол дахь алтны сүлжээний сүүлийн шат буюу Монгол банканд алтыг тушааснаар энэ сүлжээ нь албан ёсных болдог. 2018 онд Тогтвортой бичил уурхай төсөл, Монгол банк, Стандарт хэмжил зүйн газрын Үнэт металлын сорьцын хяналтын газар хамтран Дархан-Уул, Баянхонгор аймгуудад алтны сорьц тогтоох, худалдан авах нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг байгуулсан нь алтны гарал үүсэл, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, алт сорьцлох, худалдан авах үйл ажиллагааны төвлөрлийг сааруулах, алтны худалдааны шат дамжлагыг бууруулахад тодорхой хувь нэмрээ оруулж байна.

3.1.6.4 Бичил уурхайн талаарх мэдээллийн тархац, эх сурвалж

Орон нутгийн иргэдэд бичил уурхайн танилцуулга мэдээллийг олон нийтийг хамарсан сайн дурын ажил болон хандивын аянаар дамжуулан түгээдэг. Харин бичил уурхай эрхлэгчдийн болон олборлолтын талаарх статистик мэдээллийг АМГТГазраас авах боломжтой.

3.1.6.5 Монголд хэрэгжиж буй Тогтвортой Бичил Уурхайн Төсөл

Тогтвортой бичил уурхай (ТБУ) төсөл нь Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр 14 дэх жилдээ хэрэгжиж байна. Төслийн 4 дэх үе шат 2015-2018 оны хугацаанд үргэлжлэх бөгөөд уг үе шатны зорилго нь эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хариуцлагатай, хүний эрхэд суурилсан Монгол Улсын бичил уурхайн салбарыг төлөвшүүлэх, бичил уурхайгаар олборлосон алтны худалдааны эрх зүйн орчныг бүрдүүлэх, нийлүүлэлтийн сүлжээг албажуулах, бичил уурхайн талаарх дэлхийн бусад орны сайн туршлагаас суралцах, өөрсдийн туршлагаас хуваалцахад дэмжлэг үзүүлэх явдал юм.

Европын Холбоо 2021 оноос гарал үүсэл нь тодорхой болсон алт болон бусад гурван төрлийн ашигт малтмалыг худалдан авах тухай мэдэгдсэн. Мөн Монгол банкнаас алтны дотоодын худалдан авалтыг хийхдээ Худалдан авалтын гэрээ байгуулахыг шаардах бодлого баримтлахаар төлөвлөж байна.

Иймд БУУ-аар олборлосон ашигт малтмалыг гарал үүслийн бичигтэйгээр экспортлох шаардлагатай болж байгаа учир ТБУ төсөл нь бичил уурхайгаас бий болсон ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээ-гарал үүслийг сайжруулах, түүнийг тодорхой болгох зорилготойгоор ажиллаж байна. Энэхүү зорилгын хүрээнд Дархан, Баянхонгор аймагт сорьцын хяналтын лабораторийг 2018 онд нээсэн байна.

3.1.6.6 Нөхөн сэргээлтийн байдал

Бичил уурхай эрхлэгч этгээд нь Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд заасны дагуу олборлолт явуулсан талбайд нөхөн сэргээлт хийх ажлын төлөвлөгөө, төсөв, зардлыг эх үүсвэрийн баталгааг гаргаж сум, дүүргийн Засаг даргатай байгуулах гэрээндээ тусган ажиллана. Бичил уурхай эрхлэгч нь олборлолтын талбайгаа бүцааж хүлээлгэн өгөхийн өмнө тухайн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан А/226, А/182 дугаар тушаалаар батлагдсан “Бичил уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн, газарт нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу хийж, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан, сум дүүргийн засаг даргын томилсон комисст актаар хүлээлгэн өгнө. Бичил уул уурхай эрхлэгч этгээд болон нутгийн захиргааны байгууллага нь нөхөн сэргээлтийн дундын сангийн мөнгөн хөрөнгийг зөвхөн бичил уурхайгаар олборлолт явуулсан талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх зориулалтаар хамтран захиран зарцуулна.

Бичил уурхайн зориулалтаар ашиглаж байгаа 215.39 га нь алтных, 9 га нь гялболд, 151.15 га нь жонш олборлож байна. АМГТГ-т ирүүлсэн мэдээллээр нийт ашиглаж байгаа талбай, эвдрэлд орсон талбай болон нөхөн сэргээсэн талбайн хэмжээг аймгаар нь харуулбал:

Аймаг	Ашиглаж байгаа талбайн хэмжээ /га/	Эвдрэлд орсон талбай /га/	Нөхөн сэргээсэн талбай /га/
Архангай	0	0	0
Булган	45.15	13.1	5.9
Баян-Өлгий	4	9	1
Дархан-Уул	44.14	15.14	10.24
Дорнод	9	10	8.5
Баянхонгор	20.81	7.97	5.39
Завхан	0	0	0
Орхон	0	0	0
Ховд	5	2	1
Увс	0	0	0
Говь-Алтай	5.71	3	0
Дорноговь	81.39	3.4	0
Сэлэнгэ	90.58	30.84	31.7
Хэнтий	69.76	32.3	4

3.2 Газрын тос болон байгалийн хий

3.2.1 Газрын тос болон байгалийн хийн үйл ажиллагааны тухай тойм

1940 оны үед Зүүнбаянгийн нефтийн талбайг Зөвлөлтийн геологичид Монгол Улсын зүүн зүгийн говийн цөлд илрүүлсэн байдаг. Энэхүү талбайг 6.2 сая тонн нөөцтэй гэж тооцоолсон бөгөөд 400 мянган тонн боловсруулах хүчин чадалтай Монгол Улсын анхны “Монгол тос” боловсруулах үйлдвэр баригджээ. Улмаар тус талбайд 4 сая тонн түүхий нефт олборлосон бөгөөд ОХУ-ын түүхий нефттэй нэгтгэн боловсруулах үйлдвэр нь түлш, тослох материалын дотоодын хэрэглээний 20 хүртэлх хувийг хангаж байжээ. 1969 онд тус компани нь цооног дахь даралтын бууралт, боловсруулах үйлдвэрт гарсан галын болон бусад эдийн засгийн хүчин зүйлсийн улмаас боловсруулах үйл ажиллагаагаа зогсоосон.

1993 онд АНУ-ын SOCO компанитай Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан бөгөөд жилийн дараа 3000 метр гүн дэх анхны хайгуулын цооног өрөмджээ. 1997 онд XIX блок дээр 19-3-р анхны чөлөөт урсгалын газрын тосны цооног бүртгэгдсэн. Удалгүй газрын тосыг Монголоос ачааны тэргээр Хятад руу экспортолж байв.

Манай улсад одоогоор газрын тос боловсруулах үйлдвэр, тоног төхөөрөмж байхгүй тул түүхий нефт экспортолж байна. Монгол Улс газрын тосны бүтээгдэхүүнийг дотоодын хэрэгцээнд зориулан Орос улсаас импортолдог.

Одоогийн байдлаар, Монгол Улсын хэмжээнд газрын тосны 32 тусгай зөвшөөрөлтэй талбай байгаа бөгөөд 25 талбайд 21 гэрээлэгч БХГ байгуулан, Засгийн газраар батлуулан ажиллаж байна. Эдгээр тусгай зөвшөөрлийн 25 талбайгаас 3 талбайд олборлолт, 22 талбайд хайгуулын ажил хийгдэж байна. Үлдсэн 7 талбайд эрлийн ажил явагдаж байна. Олборлолт явуулж байгаа 3 талбайд 2 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Доншен газрын тос монгол ХХК болон Петроцайна ХХК-ийн охин компани болох “Петроцайна дачин тамсаг” ХХК нь газрын тосны олборлолт, экспортын дийлэнх үйл ажиллагааг явуулж байна.

No.	Олборлолтын талбай	Хэлэлцээрийн огноо	Гэрээлэгч
1	Тосон-уул XIX	1993/04/26	“Петроцайна дачин тамсаг” ХХК
2	Тамсаг XXI	1995/12/11	
3	PSA-97	1997/01/24	Доншен газрын тос монгол ХХК

Петроцайна Дачин Тамсаг ХХК

Хятадын Үндэсний газрын тосны корпорацийн харьяа төрийн өмчит “Дачин Ойл Фийлд Лимитед” компани нь 2008 оны 8 дугаар сард Тамсагийн сав газрын XIX, XXI, XXII гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах БХГ-ний эрх үүргийг АНУ-ын “СОКО Интернейшнл” ХХК-иас шилжүүлэн авч, БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Петроцайна дачин тамсаг” ХХК-ийг Монгол Улсад байгуулан Дорнод аймгийн Халх гол, Матад сумдын нутагт орших Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайнуудад газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Доншен газрын тос Монгол ХХК

БНХАУ-ын “Доншен Жингүн Петролеум Девелопмент Групп Сток” компани нь Монгол Улсын Засгийн газрын 1997.02.19-ний өдрийн 47 тоот тогтоолоор 2003 оны 2 дугаар сарын 15-нд батлагдсан БХГ-ний эрх, үүргийг Австралийн “Рок Ойл (Говь)” компаниас шилжүүлэн авч, БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Доншен газрын тос Монгол” ХХК-ийг Монгол Улсад байгуулан, Дорноговь аймгийн нутагт орших 1997 оны БХГ-т талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Газрын тосны үйл ажиллагаанд газрын тостой холбоотой хайгуул болон олборлолтын үйл ажиллагаа багтдаг. Харин уламжлалт бус газрын тосны үйл ажиллагаа нь байгалийн битүм, шатдаг занар, тослог элс, хийн элс, хийн занар болон нүүрсний метантай холбоотой.

Газрын тосны тухай хуулийн дагуух нэр томъёогоор “Газрын тос” гэдэгт түүхий тос, байгалийн хий орно. Мөн АМГТГ нь байгалийн хийн талаар ямар нэгэн гэрээ хэрэгжүүлээгүй ба байгалийн хийн эрэл, хайгуулын ажил явагдаагүй байна.

Эрдэнэс Метан ХХК нь 2016 оны 02 дугаар сард уламжлалт болон уламжлалт бус байгалийн хий, газрын тос хайх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийг зохицуулах болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх зорилгоор Эрдэнэс Монгол ХХК-ийн 100% өмчлөлтэй охин компани болон байгуулагдсан.

3.2.2 Газрын тосны нөөц

“Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос Монгол” ХХК нь хайгуул, үнэлгээ, туршилтын олборлолт, ашиглалтын нийт 1465 цооног (Тосон-Уул XIX талбайд 869 цооног, Тамсаг XXI талбайд 477 цооног, БХГ-97 талбайд 119) өрөмдөн, 12.78 мянган тууш км хоёр хэмжээст (Тосон-Уул XIX талбайд 4.37 мянган тууш км, Тамсаг XXI талбайд 3.27 мянган тууш км, БХГ-97 талбайд 5.14 мянган тууш км), 5.33 мянган км² гурван хэмжээст (Тосон-Уул XIX талбайд 2.32 мянган км², Тамсаг XXI талбайд 2.67 мянган км², БХГ-97 талбайд 339.6 км²) чичирхийллийн судалгаа хийсэн.

ЭБМЗ-өөр 2011 онд Тосон-Уул XIX талбайн газрын тосны нөөцийн тооцооны нэмэлт тайланг дахин хэлэлцүүлж, тус зөвлөлийн 2011 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 06 тоот дүгнэлтийг үндэслэн ЭБЭХ-ний сайдын 2011 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 148 дугаар тушаалаар газрын тосны “баталгаат” нөөцийг 60.06 сая тн, үүнээс газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөцийг 6.50 сая тонноор нэмж, Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэснээр дээрх талбайн нийт газрын тосны “баталгаат” нөөц 179.08 сая тн, үүнээс газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөц 20.17 сая тонн гэж бүртгэгджээ.

Тамсаг XXI талбайн газрын тосны нөөцийн тооцооны тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлж, тус зөвлөлийн 2012 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 01/12 тоот дүгнэлтийг үндэслэн ЭБЭХ-ний сайдын 2012 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 41 дүгээр тушаалаар газрын тосны “баталгаат” нөөцийг 127.509 сая тн, үүнээс байгалийн горимоор ашиглах газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөцийг 14.01 сая тонн, ус шахалтын горимоор ашиглах газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөцийг 21.018 сая тонноор Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн.

БХГ-97 талбайн газрын тосны нөөцийг 26.05 сая тонн буюу 186.3 сая баррель; үүнээс “ашиглалтын баталгаат” нөөцийг 2.07 сая тонн буюу 14.86 сая баррелиар тус тус тогтоосон ба уг нөөцийн тооцооны тайланг ЭБЭХЯ-ны дэргэдэх ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн, тус зөвлөлийн 2010.04.18-ны өдрийн 03 тоот дүгнэлтийг үндэслэн ЭБЭХ-ний сайдын “Нөөц бүртгэх тухай” 2011.06.08-ны өдрийн 137 дугаар тушаалаар Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн байна.

3.2.3 Газрын тосны олборлолт болон экспорт

2018 онд газрын тосны үйлдвэрлэл 6.4 сая баррель болсон нь 2017 онтой харьцуулахад 1.2 сая баррель буюу 16.2% буурсан гэсэн үг юм. Энэ нь 64.5 сая баррель буюу 2009 оны үзүүлэлтээс (10 жилийн өмнөх) 3.4 дахин их өсөлтийг харуулж байна. 6.2 сая баррель буюу 2018 оны нийт **газрын** тосны бүтээгдэхүүний 96.9% -ийг экспортолсон байна. Өмнөх жилтэй харьцуулахад 1.3 сая баррель буюу 17.6% буурчээ. Дараах диаграммд газрын тос олборлох, экспортлох сүүлийн 3 жилийн статистикийг харуулав.⁵⁰



2018 оны газрын тосны олборлолт болон экспортыг сараар доорх хүснэгтэд харуулав⁵¹:

	Олборлолт		Экспорт	
	Баррел	%	Баррел	%
2018.01	620,842	9.7	558,232	9.0
2018.02	556,544	8.7	451,701	7.3
2018.03	568,740	8.9	621,219	10.0
2018.04	535,029	8.4	579,017	9.4
2018.05	556,865	8.7	555,443	9.0
2018.06	539,680	8.4	541,818	8.8
2018.07	563,763	8.8	543,629	8.8
2018.08	553,224	8.7	537,238	8.7
2018.09	515,475	8.1	423,496	6.8
2018.10	198,319	3.1	156,157	2.5
2018.11	569,745	8.9	698,891	11.3
2018.12	610,983	9.6	521,584	8.4
Нийт 2018	6,389,209	100	6,188,425	100
Нийт 2017	7,624,055	-	7,512,810	-
Өөрчлөлт	-16.20%	-	-17.60%	-

⁵⁰ Эх сурвалж: [Аж үйлдвэрийн салбар 2018, Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо](#)

⁵¹ Эх сурвалж: [Ашигт малтмал газрын тосны газар \(АМГТГ\)](#)

3.2.4 Газрын тосны бүтээгдэхүүний орлого

Ашигт малтмал газрын тосны газраас гаргасан 2018 оны статистик мэдээллээр газрын тосны орлогыг дараах байдлаар гаргасан байна.

Төсвийн орлогын гүйцэтгэл, /орлогын төрлөөр, сая төгрөг, 2018/

Орлогын үрсгал	2018 төлөвлөгөө	Гүйцэтгэл		Биелэлт 2018
		2018.XII	2018.I-XII	
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	2,100.0	580.8	3,023.4	144.0%
Газрын тосны экспортын орлого	223,448.3	4,553.9	222,514.7	99.6%
Газрын тосны үйлчилгээний орлого	2,392.5	445.5	2,551.5	106.6%

3.3 Баяжуулах болон боловсруулах үйлдвэр

АМГТГ-аас гаргасан 2018 оны бүтээгдэхүүн гаргалтын мэдээг хүснэгтээр харуулбал:

Ашигт малтмалын төрөл	Хэмжих нэгж	Тоон утга	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	Тоон утга
Холимог металл	-	-	Хар тугалганы баяжмал дахь алт	кг	74
Холимог металл	-	-	Цайрын баяжмал дахь алт	кг	26
Алт (Үндсэн)	-	-	Мөнгөний гүлдмай дахь аль	кг	6
Зэс (ил уурхай)	-	-	Зэсийн баяжмал дахь алт	кг	9,003
Алт (Үндсэн)	мян.тн	9,540.47	Алт (Гүлдмай)	кг	6,522
Алт (Үндсэн)	мян.тн	175.23	Бэлтгэл ажил хийсэн	-	-
Алт (Шороон)	-	-	Зөвхөн хөрс хуулалтын ажил явагдсан	-	-
Бар/м (Цемент)	-	1,512.74	Цемент	мян.тн	1,078
	-	79.36	Шохой	мян.тн	93
	-	540.56	Шохойн чулуу	мян.тн	996
	-	-	Клинкер	мян.тн	-
Бар/м (Шохойн чулуу)	-	-	Шатаах зуухны горим тааруулах, хөрөнгө оруулалт байхгүй тул ажиллаагүй	-	-
Гантиг	м3	3.20	Гантиг	м3	3
Гөлтгөнө	мян.тн	56.90	Гөлтгөнө	тн	42
Гянтболд (Үндсэн)	мян.тн	46.25	Гянтболдын баяжмал	тн	320
Зэс (ил уурхай)	мян.тн	68,574.78	Зэсийн баяжмал	мян.тн	1,321
Зэс (далд уурхай)	-	11.67	Бэлтгэл малталт хийсэн	-	-
Зэс	мян.тн	11,402.82	Катодын цэвэр зэс	мян.тн	12
Холимог металл	мян.тн	29,836.56	Молибден баяжмал	мян.тн	5
Алт (Үндсэн)	-	-	Мөнгө (Гүлдмай)	кг	2,736
Холимог металл	-	-	Хартугалганы баяжмал дахь мөнгө	кг	31,703
Холимог металл	-	-	Цайрын баяжмал дахь мөнгө	кг	5,084
Алт (Үндсэн)	-	-	Алтын гүлдмай дахь мөнгө	кг	566
Зэс (ил уурхай)	-	-	Зэсийн баяжмал дахь мөнгө	кг	28,882
Хас	мян.тн	16.78	Улаан хас чулуу (экспортолсон)	тн	16
Хас	-	-	Чулуун хавтан үйлдвэрлэх хас агуулсан конгломерат	тн	5,070
	-	7,975.02	Төмрийн бүхэллэг баяжмал	мян.тн	5,981
	-	5,693.48	Төмрийн нунтаг баяжмал	мян.тн	7,849
	-	372.84	Төмрийн бүхэллэг хүдэр	мян.тн	2,370
	-	-	Төмрийн нунтаг хүдэр	мян.тн	69
Төмөр	-	-	2017 онд баяжуулсан бүтээгдэхүүнээ борлуулсан	-	-
	-	150.35	Хайлуур жоншны баяжмал ФФ-97	мян.тн	28
	-	136.46	Хайлуур жоншны баяжмал ФФ-95	мян.тн	113
	-	39.39	Бүхэллэг жонш ФК-92	мян.тн	16
	-	73.24	Бүхэллэг жонш ФК-85	мян.тн	11
	-	-	Бүхэллэг жонш ФК-80	мян.тн	0
	-	295.69	Бүхэллэг жонш ФК-75	мян.тн	86
	-	2.78	Бүхэллэг жонш ФК-65	мян.тн	19
	-	262.57	Хайлуур жоншны хүдэр ФР	мян.тн	699
Хайлуур жонш	-	-	Бэлтгэл болон үндсэн малталт хийсэн	-	-
Холимог металл	мян.тн	679.90	Хар тугалганы баяжмал	мян.тн	23
Цайр	мян.тн	1,091.54	Цайрын баяжмал	мян.тн	118

4 Орлогын төвлөрөл

БДО Тунис ба БДО Монгол ХХК-ийн консорциум ("Хараат бус хянан-нэгтгэгч") нь олборлох салбар дахь компаниудаас засгийн газрын хүлээн авсан орлогын тодорхой үрсгалын нэгтгэлийг хийж гүйцэтгэхээр сонгогдсон бөгөөд энэхүү бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан болно. Тохируулгыг хийхдээ мөнгөн суурьт нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримталсан.

Хараат бус хянан-нэгтгэгч нь тайлагнагч байгууллагуудаас бөглөж ирүүлсэн маягт, мэдээлэл ба тэднээс өгсөн тайлбарт үндэслэн өөрсдийн ажлыг гүйцэтгэсэн ба уг мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдалд баталгаажуулалт хийгээгүй болно. Тайлагнагч байгууллагуудаас хүлээн авсан тайлбар, мэдээлэл үнэн зөв, найдвартай байдлыг хангахын тулд сонгогдсон 202 компаниас удирдлагын хариуцлагын захидал, аудитын мэдэгдэл, аудитын тайлангийн дүгнэлт болон тайланг компаниудаас хүлээн авсан. Гэхдээ 113 компани уг батламж мэдэгдлийн аль нэгийг огт ирүүлээгүй.

ОУИТБС-ын нэгтгэл тайлан нь 2019 оны 11 сарын 25-ныг хүртэл компаниуд болон засгийн газрын байгууллагуудаас ирүүлсэн татвар, төлбөр, хураамжийн дэлгэрэнгүй мэдээлэл болон нэмэлт мэдээллээс бүрдсэн.

4.1 Хамрах хүрээг тодорхойлох нь

Монгол Улсын ОУИТБС-ын 2018 оны нэгтгэл тайланд хамрагдах цар хүрээг тодорхойлохдоо ОТАХ-тэй хамтран дараах асуудлуудыг харгалзаж үзсэн. Үүнд:

- Тайланд хамрагдах уул уурхайн салбарын үндсэн мэдээллүүдийн хүрээг тогтоох,
- Тайланд хамрагдсан компаниудаас авах нэмэлт мэдээллүүдийн хүрээг тогтоох,
- Тайланд хамрагдах материаллаг төлбөр төлсөн компаниудыг тодорхойлох,
- Тайланд хамрагдах материаллаг төлбөр хүлээж авсан төрийн байгууллагуудыг тодорхойлох,
- Тайлан хамрагдах материаллаг төлбөр бүхий орлогын үрсгалуудыг тодорхойлох,
- Тайлагнасан тоо мэдээлэл нь үнэн зөв гэдгээ баталгаажуулах хувилбарууд.

Эхлэлийн үе шатанд Хараат бус хянан-нэгтгэгч нь Монгол Улсын ОУИТБС-ын 2018 оны тайланд оруулах шаардлагатай агуулга, мэдээлэл, Ажлын даалгаврын Хавсралтад орох баримт бичгүүдийг хянан шүүж, энэ талаар хэд хэдэн оролцогч талуудтай урьдчилсан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Эхлэлийн үе шатны зорилго нь ОУИТБС-ын тайлагналын үйл явцын хамрах хүрээг зөв тодорхойлж, мэдээлэл цуглуулах журам, ОУИТБС-ын тайланг хэвлэх хуваарь зэргийг баталгаажуулах явдал юм.

Бид МОУИТБС-ын Ажлын албанаас 2019 оны 10 дугаар сарын 03-нд зохион байгуулсан ОТАХ (цаашид ОТАХ гэх)-ийн гишүүдийг хамруулсан эхний уулзалтад 2018 оны ОУИТБС-ын тайлангийн агуулга, холбогдох тодорхойлолтууд болон ил тод болгох мэдээллийн материаллаг хэмжээний босго үзүүлэлтүүдийг авч хэлэлцэн энэхүү тайланд эхний уулзалтын үеэр өгсөн саналыг тусгасан.

4.1.1 Материаллаг байдлын босго үзүүлэлт

Бид нэгтгэлд хамруулах компанийг сонгохдоо ашиглах материаллагийн түвшин тодорхойлохын тулд ОУИТБС-ын Ажлын албанаас 2019 оны 9-р сарын 26-нд бидэнд ирүүлсэн Засгийн газрын тайлан дээрх уул уурхай, газрын тосны салбараас Засгийн газрын хүлээн авсан орлогын үрсгалыг харгалзан үзсэн. ОУИТБС-ын тайланд хамрагдах төлбөр, орлогын материаллаг байдлыг Эхлэлийн семинар дээр ОТАХ-тэй хэлэлцэж, ОТАХ үүнийг дараах байдлаар шийдвэрлэсэн. Үүнд:

2018 оны ОУИТБС-ын тайланд 'Материаллагийн босго'—г 200 сая.төг байхаар төлөвлөсөн. Доорх шинжилгээ нь бүх тайлагнагч компаниуд дахь босго тогтооход ашигласан интервал болон хувь хэмжээг харуулж байна:

Төгрөгөөрх дүн	Компанийн тоо	Төлбөрийн дүн(төг)	Эзлэх хувь	Эзлэх хувь өссөн дүнгээр	Компанийн тоо өссөн дүнгээр
Дүн >= 500 тэрбум	1	600,438,611,856	21.00%	21.00%	1
500 тэрбум > Дүн >= 100 тэрбум	6	1,599,633,597,387	55.96%	76.96%	7
100 тэрбум > Дүн >= 1 тэрбум	59	552,715,430,470	19.33%	96.30%	66
1 тэрбум > Дүн >= 500 сая	46	31,439,227,293	1.10%	97.40%	112
500 сая > Дүн >= 200 сая	92	29,398,164,223	1.03%	98.43%	204
200 сая > Дүн >= 100 сая	120	16,817,597,331	0.59%	99.01%	324
100 сая > Дүн	1,730	28,196,070,483	0.99%	100.00%	2,054
	2,054	2,858,638,699,043	100%		

Дээрх харуулсан энэхүү аргаар нийт тайлагнасан орлогын 98.43%-г хамарсан томоохон 204 компанийг сонгохоор болсон.

Гэхдээ, бид 204 компанийн жагсаалтыг шинжилсний дараа үүнээс 12 компанийн гол үйл ажиллагаа нь олборлох салбартай холбоогүй болохыг тогтоосон. Мөн эдгээр 12 ААН нь эзэмшиж буй уул уурхайн лицензтэй холбоотой ямар нэгэн төлбөр төлөөгүй байсан.

Шинэчлэгдсэн хамрах хүрээг тооцохын тулд эдгээр компаниудыг сонгосон түүврээс хассан болно.

Хасагдсан компанийн жагсаалт:

Бүртгэлийн дугаар	Компанийн нэр	Төлбөрийн дүн (төг)	Тайлбар
2016192	Баян уул ХХК	330,236,590	Гол үйл ажиллагаа нь оёдлын үйлдвэр болон барилга угсралт
2057573	Макс Импэкс ХХК	720,546,795	2017 оны ОУИТБС тайланд хасагдсан
2571889	Молор-Трейд ХХК	989,717,518	Бетон үйлдвэрлэдэг
2593009	Бридж Констракшн ХХК	249,784,299	2017 оны ОУИТБС тайланд хасагдсан
2643987	Хэнтий үс ХХК	442,251,132	Нийтийн ашиглалтын компани
2697807	Уужим-Од ХХК	572,016,819	Тайлангаа илгээгүй, олборлолттой холбоотой татвар төлөөгүй
2808676	БУТИ ХХК	407,708,507	Барилга угсралтын компани
3306437	Дорноговь АЗЗА ТӨХК	192,266,707	Зам барилгын компани
3615243	Өгөөмөр Гавилууд ХХК	252,850,052	Агуулахын түрээс болон хүний нөөцийн зөвлөгөө гэх мэт олон үйл ажиллагаа явуулдаг
5272378	Зууннайман ойл ХХК	1,890,606,523	Олон улсын худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг
5385075	Дарданговь ХХК	294,916,947	2017 оны ОУИТБС тайланд хасагдсан
5961149	Церкон геологи ХХК	193,060,520	Геологийн үйлчилгээний компани
Нийт		6,535,962,409	

12 олборлох салбарын бус компаниудыг хассанаар шинжилгээнд дараах байдлаар өөрчлөлт оров:

Төгрөгөөрх дүн	Компаниудын тоо	Төлбөрийн дүн (төг)	Эзлэх хувь	Эзлэх хувь өссөн дүнгээр	Компаний тоо өссөн дүнгээр
Дүн >= 500 тэрбум	1	600,438,611,856	21.05%	21.05%	1
500 тэрбум > Дүн >= 100 тэрбум	6	1,599,633,597,387	56.09%	77.14%	7
100 тэрбум > Дүн >= 1 тэрбум	58	550,824,823,947	19.31%	96.45%	65
1 тэрбум > Дүн >= 500 сая	43	29,156,946,161	1.02%	97.47%	108
500 сая > Дүн >= 200 сая	86	27,420,416,696	0.96%	98.44%	194
200 сая > Дүн >= 100 сая	118	16,432,270,104	0.58%	99.01%	312
100 сая > Дүн	1,730	28,196,070,483	0.99%	100.00%	2,042
	2,042	2,852,102,736,634	100%		

Үүний үр дүнд нийт тайлагнасан орлогын 98.44%-г хамарсан томоохон 194 компанийг сонгохоор болсон. Мөн ОТАХ-ын ирүүлсэн саналыг үндэслэн дараах 8 компанийг нэмж түүвэрлэсэн.

Дугаар	Компани РД дугаар	Компаний нэр	Ашигт малтмал төрөл	ОТАХ-ээс ирүүлсэн шалгуур
1	2621169	Эс Жи групп ХХК	Алт	Бага татвар төлсөн, талбайн хэмжээ том
2	5459362	Өү И Эл ХХК	Жонш	Бага татвар төлсөн, талбайн хэмжээ том
3	5255791	Олдмен ХХК		Тайлан ирүүлээгүй, татвар огт төлөөгүй, талбайн хэмжээ том
4	5287227	Кэй Эм майнинг ХХК		Тайлан ирүүлээгүй, татвар огт төлөөгүй, талбайн хэмжээ том
5	2687968	ЕАИ ХХК	Нүүрс	Талбайн хэмжээ том, их татвар төлсөн
6	5161312	Алагтэвш ХХК	Нүүрс	Том талбайтай, их татвар төлсөн
7	2672146	Адамасмайнинг ХХК		Стратегийн орд, талбайн хэмжээ том, их татвар төлсөн, Ураны зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж
8	2023202	Мандал-Алтай групп ХХК	Бар/м	Түгээмэл тархацтай аж ахуйн нэгж талбай, их татвар төлсөн

4.1.2 Компаниудын жагсаалт

Дээрх материаллаг байдлын дүн шинжилгээний дагуу, 202 олборлогч компаниуд нэгтгэлд оролцсон. Тэдгээр компаниудыг үйл ажиллагааны төрлөөр дэлгэрэнгүй харуулбал:

Үйл ажиллагаа	Компаниудын тоо	ЗГ-ын хүлээн авсан дүн (мян.төг)	Хувь
Уул уурхай – Хайгуул	22	12,453,835	0.44%
Уул уурхай - Олборлолт	120	2,112,948,956	75.03%
Уул уурхай – Хайгуул ба олборлолт	51	226,400,097	8.04%
Газрын тос ба байгалийн хий - Хайгуул ба олборлолт	8	279,930,755	9.94%
Уул уурхай, газрын тос ба байгалийн хий - Хайгуул ба олборлолт	1	184,449,980	6.55%
Нийт	202	2,816,183,623	100.00%

4.1.3 Орлогын урсгалуудын жагсаалт

ОУИТБС цахим тайлангийн систем дэх Засгийн газар болон компаниудын мэдүүлсэн бүх орлогын урсгал нь ямар нэгэн материаллагийн босгогүйгээр нэгтгэлд хамрагдсан. Гүйцэтгэлийн шатанд сонгогдсон 202 компанийн тайлагнасан төлбөрийн урсгал эхний үүлзлэлд тохирсон урсгалд хамрагдаагүй байсан гурван орлогын урсгалыг нэмж оруулсан. Энэхүү нэмсэн орлогыг урсгалыг багтаасан Орлогын урсгалын жагсаалт нь дараах байдалтай байна.

Орлогын урсгал	Нийт 2052 компанийн дүн (сая.төг)	Эзлэх хувь	Сонгогдсон 202 компанийн дүн (сая.төг)	Эзлэх хувь	Эзлэх хувь өссөн байдлаар
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр					
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	654,295,384	22.61%	650,991	22.39%	57.19%
Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	230,166,436	7.95%	217,630	7.48%	64.68%
Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлого	222,514,737	7.69%	222,515	7.65%	72.33%
Нэмэгдсэн өртгийн албан татвар (Гааль)	147,201,239	5.09%	144,614	4.97%	77.30%
Нэмэгдсэн өртгийн албан татвар (ТЕГ-т төлсөн)	116,927,086	4.04%	112,852	3.88%	81.19%
Гаалийн үйлчилгээний хураамж	77,063,878	2.66%	76,131	2.62%	83.80%
Гаалийн албан татвар	70,112,710	2.42%	68,787	2.37%	86.17%
Агаарын бохирдлын төлбөр	40,103,188	1.39%	40,051	1.38%	87.55%
Ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	38,066,364	1.32%	19,322	0.66%	88.21%
АМНАТ	33,486,815	1.16%	33,487	1.15%	89.36%
Засгийн газарт төлсөн урьдчилгаа төлбөр	32,189,359	1.11%	32,128	1.10%	90.47%
Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар	13,211,037	0.46%	12,606	0.43%	90.90%
Бусад	11,158,545	0.39%	11,095	0.38%	91.28%
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	6,900,222	0.24%	6,763	0.23%	91.51%

Орлогын урсгал	Нийт 2052 компанийн дүн (сая.төг)	Эзлэх хувь	Сонгогдсон 202 компанийн дүн (сая.төг)	Эзлэх хувь	Эзлэх хувь өссөн байдлаар
Төрийн өмчийн ногдол ашиг	3,200,000	0.11%	3,200	0.11%	91.62%
Автобензин, дизелийн түлшний албан татвар	1,963,381	0.07%	1,946	0.07%	91.69%
Төсвийн захирагч нарын тайланд аудитын дүгнэлт гаргуулах, дээд шатны захирагчид хүргүүлэх, нэгтгэх, улмаар нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг батлах үйл явц, цаглабарыг доор харуулав.

НЭГДСЭН ТӨСВИЙН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ



5.3.1.1 Төсвийн гүйцэтгэл

Тухайн оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн төсөв зарцуулах эрх нээгдэх бөгөөд 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болдог. Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар болон бусад орлого төвлөрүүлэх үүрэгтэй байгууллагууд нь төсвийн орлогыг төрийн санд төвлөрүүлдэг ба батлагдсан төсвийн хуваарийн дагуу төрийн сангаас төсвийн байгууллагад санхүүжилт олгож, төлбөр тооцоог гүйцэтгэдэг.

5.3.1.2 Төсвийн тайлагнал

Сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээг төсвийн байгууллагууд гаргаж тогтоосон хугацаанд дээд шатны захирагчид хүргүүлдэг. ТЭЗ нар мэдээллийг нэгтгээд Сангийн яаманд хүргүүлнэ. Сангийн яам мэдээг нэгтгэн гаргаж сар бүрийн 8-ны дотор Үндэсний статистикийн хороонд хүргүүлэн олон нийтэд мэдээлдэг. Харин улирал, хагас жил, бүтэн жилээр төсвийн байгууллагууд санхүүгийн тайланг гаргаж дээд шатны захирагчид хүргүүлдэг. Аудитын байгууллагаар жилийн эцсийн санхүүгийн тайланд заавал аудит хийлгэдэг. Сангийн яам төсвийн ерөнхийлөн захирагчдын аудит хийлгэсэн тайланг нэгтгэн Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг гарган Үндэсний аудитын газарт хүргүүлнэ. Үндэсний аудитын газар нь тайланд аудит хийж, аудитын дүгнэлтийн хамт Засгийн газар, УИХ-д өргөн мэдүүлдэг. УИХ нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцсэнээр Монгол Улсын төсвийн гүйцэтгэл батлагддаг.

5.3.1.3 Төсвийн хариуцлага

Улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг Засгийн газар УИХ-ын өмнө хариуцдаг бол орон нутгийн төсвийн хувьд гүйцэтгэлийг бүх шатны засаг дарга тухайн шатны ИТХ-ын өмнө хариуцдаг.

5.3.1.4 2018 оны төсвийн орлого, төсвийн өсөлтийн урьдчилсан гүйцэтгэл

Үзүүлэлт	2017 (тэрбум төг.)	2018 (тэрбум төг.)	Өсөлт (%)
Нийт орлого	7,922	10,063	127%
Ирээдүйн өв сан	358	621	174%
Төсвийн тогтворжуулалтын сан	326	207	64%
Тэнцвэржүүлсэн орлого	7,239	9,235	128%
Татварын орлого	6,303	8,207	130%
Импорттой холбоотой татвар	1,860	2,628	141%
Импортлолсон бараа үйлчилгээний НӨАТ	1,032	1,412	137%
Гаалийн албан татвар	512	682	133%
Онцгой албан татвар	316	534	169%
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого	1,610	2,086	130%
Нийгмийн даатгалын шимтгэл	1,314	1,621	123%
Дотоодын бараа үйлчилгээний татвар	986	1,056	107%
НӨАТ-ын буцаан олголт	(147)	(114)	78%
Бусад татварын орлого	679	929	137%
Татварын бус орлого	936	1028	110%

Эх сурвалж: Сангийн яам

5.3.2 Төсвийн зарцуулалт ба цэвэр зээл

Үзүүлэлт	2017 (тэрбум төг.)	2018 (тэрбум төг.)	Өсөлт
Нийт зарцуулалт ба цэвэр зээл	8,981	9,223	(242)
Анхдагч зарцуулалт	7,825	8,176	(351)
Хүүгийн төлбөрөөс бусад урсгал зардал	5,850	6,301	(451)
Капитал зарцуулалт	1,646	1,608	38
Цэвэр зээл	329	267	62
Хүүгийн төлбөр	1,156	1,047	109
Тэнцвэржүүлсэн үлдэгдэл	(1,742)	12	(1,754)
ДНБ-ийн %	(0)	-	(0)
Анхдагч тэнцэл	(586)	1,059	(1,645)
ДНБ-ийн %	(0)	0	(0)

Эх сурвалж: Сангийн Яам


6 Нийгэм, эдийн засгийн зарцуулалт

6.1 Олборлох салбарын компаниудын нийгмийн болон байгаль орчны зардал

6.1.1 Хандивын мэдээлэл

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын нэгтгэлд хамрагдсан 202 компанийн 2018 онд мөнгөн ба мөнгөн бүс хэлбэрийн хандив дэмжлэгийг төрийн болон орон нутгийн байгууллагуудад үзүүлсэн. Төрийн байгууллагууд болон компаниудаас ирүүлсэн мэдээллүүд нь зөрүүтэй байсан тул тохируулга хийж зөрүүг тохируулсан. Дээр дурдсанчлан заавал тайлагнах хандив дэмжлэгүүдийг нэгтгэлд оруулж тохируулга хийсэн бол сайн дурын хандив дэмжлэгүүд тохируулга хийгдээгүй болно.

2018 онд нэгтгэлд хамрагдсан компаниудаас 99 компани нийт 24,065 сая төгрөгийн мөнгөн ба мөнгөн бүс хандивыг олгосон байна. Тохируулгын дараах байдлаар нийт хандив, дэмжлэгийг зориулалтаар нь харуулбал дараах байдалтай байна.



Хандив хүлээн авагч	Мөнгөн Хандивын дүн /мян.төгрөгөөр/	Мөнгөн бүс Хандивын дүн /мян.төгрөгөөр/	Нийт үнийн дүн	Эзлэх хувь
Яам, агентлагт	66,000	52,767	118,767	0.49%
Аймаг, нийслэлд	2,797,963	1,815,635	4,613,598	20.42%
Сум, дүүрэгт	1,877,942	2,564,658	4,442,600	18.45%
Төрийн бүс байгууллага, сангууд	14,428,488	437,912	14,866,400	59.95%
Бусад байгууллагад	5,000	43,011	48,011	0.68%
Нийт	19,175,393	4,913,983	24,089,376	100.00%

Нийт хандив, дэмжлэгийн 77.5 %-ийг Оюу Толгой ХХК, Цайртминерал ХХК, МоЭнКо ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Энержи Ресурс ХХК, Фриендшип ресурсис ХХК гэсэн 6 компани үзүүлжээ. Мөн нийт орон нутгийн хөгжлийн санд өгсөн хандивын 95.7%-г Өмнөговь аймгийн “Говийн оюу сан” болон Ховд аймгийн “Ховд хөшөөт хөгжил сан”-д өгсөн байна.

Тохируулгын дараах байдлаар нийт хандив, дэмжлэгийг авсан аймгуудаар нь харуулбал дараах байдалтай байна.

Хандив хүлээн авагч	Мөнгөн Хандивын дүн /мян.төгрөгөөр/	Мөнгөн бүс Хандивын дүн /мян.төгрөгөөр/	Нийт үнийн дүн	Эзлэх хувь
Архангай	98,300	71,453	169,753	0.70%
Баян-Өлгий	-	24,905	24,905	0.10%
Баянхонгор	435,043	209,742	644,785	2.68%
Булган	406,470	1,016,269	1,422,739	5.91%
Говь-Алтай	117,075	105,313	222,388	0.92%
Дархан-Уул	358,641	66,335	424,976	1.76%
Дорноговь	853,381	902,753	1,756,134	7.29%
Дорнод	30,000	187,000	217,000	0.90%
Дундговь	11,840	104,881	116,721	0.48%
Өвөрхангай	5,000	99,350	104,350	0.43%
Өмнөговь	12,589,852	1,533,814	14,123,666	58.63%
Сүхбаатар	2,089,082	120,300	2,209,382	9.17%
Сэлэнгэ	49,100	86,668	135,768	0.56%
Төв	376,020	202,757	578,777	2.40%
Увс	64,405	148,398	212,803	0.88%
Улаанбаатар	79,880	26,236	106,116	0.44%
Ховд	1,587,918	5,309	1,593,227	6.61%
Хөвсгөл	10,606	2,500	13,106	0.05%
Хэнтий	9,480	-	9,480	0.04%
Говьсүмбэр	3,300	-	3,300	0.01%
Нийт	19,175,393	4,913,983	24,089,376	100%

6.2 Төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрүүд

Нэгтгэлд хамрагдсан ТӨААН-үүдээс тайлант хугацаанд хийгдсэн төсвийн хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг хүссэн ба төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой мэдээлэл ирээгүй байна.

6.3 Олборлох салбарын зүгээс эдийн засагт оруулж буй хувь нэмэр

6.3.1 Ерөнхий тойм

Монгол Улсын эдийн засгийн таатай нөхцөл, Засгийн газрын эдийн засгийн өсөлтийг хурдасгах бодлогын эерэг нөлөөллийн үр дүнд уул уурхайн компаниудын борлуулалтын өсөлт, ашигт ажиллагааны түвшин, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамжийн өсөлтийн үр дүнд Монгол Улсын эдийн засаг 2018 онд 6.9% -иар өссөн нь сүүлийн дөрвөн жилийн хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд төлөвлөсөн хэмжээнээс 2.7% -иар их байна. Улсын нийт орлогоос уул уурхайн салбарын эзлэх хувь өнгөрсөн оноос 7% -иар өгчээ.

Доорх хүснэгтэд эдийн засгийн өсөлтийг салбар түс бүрээр харуулав.⁵³

Салбар	2017	2018*	Өсөлт / Бууралт
Нийт эдийн засгийн өсөлт	5.3	6.9	1.6
Хөдөө аж ахуй	1.8	4.5	2.7
Үйлдвэрлэл	0.4	6.2	5.8
Уул уурхай	5.5	5.1	10.6
Үйлдвэрлэлийн салбар	20.1	15.7	-4.4
Цахилгаан эрчим хүч	5.5	8.2	2.7
Барилга	7.3	-5.0	-12.3
Үйлчилгээ	7.9	5.3	-2.6
Бөөний болон жижиглэн худалдаа	7.1	3.4	-3.7
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	14.2	6.7	-7.5
Мэдээлэл, харилцаа холбоо	15.8	4.0	-11.8
Бусад үйлчилгээ	5.4	6.1	0.7
Цэвэр татвар	18.5	20.1	1.6

Төсвийн орлого дахь уул уурхайн салбарын нийт орлогыг 1,720.0 тэрбум төгрөгөөр төлөвлөж байсан ба 2,394.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн нь нийт орлого, буцалтгүй тусламжийн төсвийн 23.5 хувийг эзэлж байна.

Хэмжээ, тэнцвэржүүлсэн үнэ, ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт орлого дараах байдалтай байна.⁵⁴

№.	Бүтээгдэхүүн	Хэмжээ		Үнэ		Нийт орлого	
		(мян.тонн)		(доллар/тонн)		(сая төг.)	
		2017	2018	2017	2018	2017	2018
1	Алт	17.5	18.1	1,257.2	1,266.5	49.1	80.0
2	Нүүрс	33,400.5	36,265.1	68.4	77.3	692.9	998.0
3	Зэсийн баяжмал	1,447.2	1,436.7	6,162.3	6,524.8	903.1	999.0
4	Цайр	118.2	123.9	1,529.4	1,596.3	64.2	78.0
5	Төмрийн хүдэр	6,257.8	7,449.0		45.9	23.4	30.6
6	Бусад					178.7	208.4
	Нийт					1,911.4	2,394.0

⁵³ Эх сурвалж: Сангийн яам

⁵⁴ Эх сурвалж: Сангийн яам

Хүснэгтээс харахад 2018 онд уул уурхайн салбараас улсын төсөвт оруулсан орлогын 83.4 хувь нь зэс, нүүрсний борлуулалтаас, 16.6 хувь нь бусад ашигт малтмалын бүтээгдэхүүний орлогоос бүрджээ.

Бүтээгдэхүүн		2017 бат.	2018	
			бат.	гүйц.
1	Нүүрс	269.1	212.0	443.4
2	Зэсийн баяжмал	479.5	469.0	487.3
3	Бусад	99.1	125.4	116.3
НИЙТ		847.7	806.4	1047.0
Төсвийн тогтвортой байдлын сан		297.4	97.4	137.7
Ирээдүйн өв сан		357.7	460.9	588.6
Тэнцвэржүүлсэн сан		192.6	248.1	320.7

Уул уурхайн салбарт ашигт малтмалын ашиглалт, хайгуул болон өсөн нэмэгдэх нөөцийн ашиглалт, хайгуулын төлбөр 2018 онд 1,047 тэрбум төгрөгт хүрч төсвөөс 29.8% буюу 240.6 тэрбум төгрөгөөр давжээ. Зэсийн баяжмал 46.5 хувь, нүүрс 42.4 хувь, үлдсэн 11.1 хувь нь бусад уул уурхайн бүтээгдэхүүнээс бүрджээ.

Нүүрс, зэсийн ашигт малтмалын нөөц ашиглалт, хайгуулын төлбөрөөс олсон орлого өмнөх оноос 199.3 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Төсвийн тогтвортой байдлын санд ашигт малтмалын ашиглалт, хайгуулаас оруулсан хувь нэмэр 159.7 тэрбум төгрөгөөр буурчээ. Энэ нь зах зээлийн үнийн үналт, зэсийн үнийг өмнөх онтой харьцуулсан тэнцвэржүүлсэн үнээс үүдэлтэй юм.

Ашигт малтмалын хайгуул, ашиглалтаас Ирээдүйн өв санд хөрөнгө оруулсан хувь нэмэр төсвөөс 127.7 тэрбум төгрөгөөр давж, өмнөх онтой харьцуулахад 230.9 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Зэсийн баяжмалын экспорт 2018 онд 1,436.7 мянган тоннд хүрч, төсвөөс 70.7 мянган тонноор давж, өмнөх оныхоос 10.5 мянган тонноор буурсан ба харин нүүрсний экспорт 36,265.1 мянган тоннд хүрч, төсвөөс 8,265.1 мянган тонноор давж, өмнөх оныхоос 2864.6 мянган тонноор нэмэгджээ.

Сүүлийн гурван жилийн дунджаар Манай улсын ДНБ-ий 23.03% -ийг уул уурхайн салбар эзэлж байна. 2018 онд тус салбарын ДНБ-ний эзлэх хувь 2017 оныхоос 0.2% -иар их байна.

6.3.2 Олборлох үйлдвэрлэлээс төвлөрүүлэх Засгийн газрын нийт орлого

6.3.2.1 Газрын тосны орлого

2018 онд газрын тосны нийт экспортыг 8,100 мянган баррельд хүргэхээр төлөвлөсөн бөгөөд 1 баррель бүрийн үнийг 50 ам.доллараар тооцож, санхүүгийн жилд улсын төсөвт 223.4 тэрбум төгрөг төвлөрүүлэх зорилттой байсан. Оны эцсийн байдлаар 6,189.8 мянган баррель газрын тос экспортолж, улсын төсөвт 222.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэв (төлөвлөгөөний 99.6%).

6.3.2.2 Ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр

2017 онд Ашигт малтмал, газрын тосны салбарт 7.1 сая га талбайд хайгуулын 1,405 лиценз, 1,673 ашиглалтын тусгай зөвшөөрөл, нийт 3,078 тусгай зөвшөөрөл АМГТГ-т бүртгэгдсэн байна. Улсын төсөвт тусгагдсан тусгай зөвшөөрлийн төлбөр 38.9 тэрбум төгрөг (төсвийн тухай хуулиар 37.0 тэрбум төгрөг байхаар тооцсоноос 1.9 төгрөгөөр давсан) байна.

6.3.2.3 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын төлбөр

Төсвийн тухай хуулийн 23.8-д заасны дагуу сум, дүүргийн төсвийн татварын орлогод түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын төлбөр орно.

2018 оны батлагдсан төсөвт үндсэн орлогын нөөц ашигласны төлбөрийг 1.6 тэрбум төгрөгөөр тусгаж, Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийг 2.1 тэрбум төгрөгөөр баталсан.

6.3.3 Эдийн засагт оруулж буй хувь нэмэр

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн дэд салбар нь аж үйлдвэрийн салбарын чухал салбар юм. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн гол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дараах 5 дэд бүлэгт ангилдаг.

- i. Нүүрсний уурхай,
- ii. Газрын тосны олборлолт,
- iii. Металлын хүдрийн уурхай,
- iv. Бусад ашигт малтмалын олборлолт,
- v. Уул уурхайн олборлолтын бусад түслах ажлууд.

Сүүлийн жилүүдэд уул уурхай, ашигт малтмалын салбар эрчимтэй хөгжиж, Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг болжээ. Стратегийн ач холбогдолтой ордуудыг нээн ашиглалтад орсноор уул уурхайн салбар хөгжих болно.

6.3.3.1 Олборлох үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд (ДНБ) оруулж буй хувь нэмэр

Олборлох үйлдвэрлэлийн 2018 онд дотоодын нийт бүтээгдэхүүнд (ДНБ) оруулсан хувь нэмрийг дараах байдлаар харуулав:⁵⁵

Үзүүлэлт	2016 (тэрбум төг.)	2017 (тэрбум төг.)	2018 (тэрбум төг.)
ДНБ	23,942.8	27,876.3	32,307.3
Уул уурхай, олборлолт	4,817.3	6,543.4	7,604.3
Эзлэх хувь	20.1%	23.4%	23.5%

ДНБ-д эзлэх уул уурхайн салбарын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.06 хувиар өсчээ.

6.3.3.2 Бичил уул уурхайн эдийн засагт оруулж буй хувь нэмэр

Бичил уурхай нь олон хүний хувьд ядуурлаас гарах, амьжиргаагаа залгуулах чухал хэрэгсэл болж байгаа төдийгүй үндэсний болон орон нутгийн эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байна. Бичил уурхайчид олборлосон алтаа албан ёсны сүлжээгээр дамжуулан борлуулснаар Монгол банкны гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байгаагаас гадна шүүд болон шүүд бусаар ажлын байрыг бий болгож, орон нутгаас төв рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг саармагжуулж, өрхийн орлогыг нэмэгдүүлж байна. Гэсэн хэдий ч Монгол Улсын алтны нийлүүлэлтийн сүлжээ бүрэн албажаагүй хэвээр байна. Монгол дахь алтны сүлжээний сүүлийн шат буюу Монгол банканд алтыг тушааснаар энэ сүлжээ нь албан ёсных болдог. 2018 онд Тогтвортой бичил уурхай төсөл, Монгол банк, Стандарт хэмжил зүйн газрын Үнэт металлын сорьцын хяналтын газар хамтран Дархан-Уул, Баянхонгор аймгуудад алтны сорьц тогтоох, худалдан авах нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг байгуулсан нь алтны гарал үүсэл, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, алт сорьцлох, худалдан авах үйл ажиллагааны төвлөрлийг сааруулах, алтны худалдааны шат дамжлагыг бууруулахад тодорхой хувь нэмрээ оруулж байна.

Өнөөдрийн байдлаар алт, жонш, гянтболд зэрэг уул уурхайн салбарт хувиараа хөдөлмөр эрхэлдэг 60 мянга гаруй иргэн ажиллаж байгаа бөгөөд тэдний 15 орчим хувь нь гар аргаар алт олборлогчид юм.

6.3.3.3 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн

2018 онд нүүрсний олборлолтын дэд салбар аж үйлдвэрлэлд 5.3 их наяд төгрөгийн хувь нэмэр оруулжээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.4 их наяд төгрөг буюу 35.9%, 2013 оныхоос 3.8 их наяд төгрөг буюу 3.6 дахин, 2009 оныхоос 4.8 их наяд төгрөг буюу 10.9 дахин их байна.

2018 оны хувьд нүүрсний олборлолт нь нийт аж үйлдвэрлэлийн 20.8 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 2.3% -иар өсчээ. Нүүрсний олборлотой алт нь олборлох үйлдвэрлэлийн 36.3 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 4.2% -ийн өсөлттэй байна.

2018 онд газрын тосны үйлдвэрлэл 1.0 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь өмнөх оноос 0.1 их наяд төгрөгөөр буюу 7.6%, 2013 оныхоос 0.2 их наяд төгрөг буюу 25.3%, 2009 оноос 0.9 их наяд төгрөг буюу 6.6 дахин өсчээ.

Газрын тосны үйлдвэрлэл нь нийт аж үйлдвэрлэлийн 3,8 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 0.5% буурсан гэсэн үг юм. Гэхдээ газрын тосны үйлдвэрлэл нь олборлох үйлдвэрлэлийн 6.7% -ийг эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.8% -иар өссөн байна.

⁵⁵ Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

6.3.3.4 Экспорт

2018 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 12.9 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.4 (22.3%)тэрбум ам.доллараар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж экспорт, импортын зөрүү 1 тэрбум 136.7сая ам.доллараар эерэг гарсан байна.

Экспорт 7 тэрбум 11.8 сая ам.долларт хүрч,өнгөрсөн оны мөн үеэс 811.1 (1.1 дахин) сая ам.доллараар өссөн байна.

Доорх хүснэгтэд 2017, 2018 оны экспортын бүтээгдэхүүний төрлөөр гадаад худалдааны гүйцэтгэлийг харуулав.

Экспортлосон бүтээгдэхүүн	Экспорт (мян.доллар)		Зөрүү		хувь нэмэр
	2017	2018	дүн (мян.доллар)	%	
01 Мал аж ахуй, мал эсвэл малын гаралтай бүтээгдэхүүн	67,416.8	102,121.2	34,704.4	51.5	1.5
02 Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	67,654.8	22,010.5	-45,644.3	-67.5	0.3
03 Амьтны болон ургамлын тос, өөх	388.2	536.0	147.7	38.1	0.0
04 Хүнсний бүтээгдэхүүн	23,007.9	91,423.3	68,415.3	297.4	1.3
05 Эрдэс баялгийн бүтээгдэхүүн	4,933,672.1	6,070,339.2	1,136,667.1	23.0	86.6
06 Химийн болон холбогдох бүтээгдэхүүн	1,470.9	1,247.7	-223.2	-15.2	0.0
07 Хуванцар болон түүний эдлэл; резин ба түүний хийц	2,983.5	1,591.3	-1,392.2	-46.7	0.0
08 Арьс шир, арьс шир, арьс, тэдгээрийн эдлэл	23,920.7	16,960.3	-6,960.5	-29.1	0.2
09 Мод, модон эдлэл	633.5	356.7	-276.9	-43.7	0.0
10 Цаас, кардон, тэдгээрээр хийсэн зүйл	77.7	36.3	-41.4	-53.3	0.0
11 Нэхмэл ба нэхмэл эдлэл	335,466.0	409,800.7	74,334.6	22.2	5.8
12 Гутал, малгай гэх мэт	2,492.4	2,317.4	-175.0	-7.0	0.0
13 Чулуу, гипс, асбест, гялтгануур болон үүнтэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	100.6	59.8	-40.9	-40.6	0.0
14 Сүвд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёл чимэглэл, зоос	596,939.2	145,480.7	-451,458.5	-75.6	2.1
15 Үндсэн металл, тэдгээрийн бүтээгдэхүүн	101,000.6	91,754.7	-9,245.9	-9.2	1.3
16 Машин, механик тоног төхөөрөмж, эд анги, цахилгаан хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл	22,770.1	24,854.4	2,084.3	9.2	0.4
17 Авто, агаар, усан тээврийн хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл	17,030.8	24,749.2	7,718.4	45.3	0.4
18 Тэгш өнцөгт, гэрэл зураг, хэмжилт, хяналт, эмнэлгийн хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг гэх мэт эд ангиуд	1,238.0	3,952.7	2,714.7	219.3	0.1
20 Төрөл бүрийн бараа	2,228.7	2,037.8	-191.0	-8.6	0.0
21 Уран зураг, цуглуулга, тусгай болон эртний үнэт дурсгалууд	98.8	128.0	29.1	29.5	0.0
Нийт	6,200,593.0	7,011,757.8	811,164.8	13.1	100.0

2018 онд экспортын голлох бүтээгдэхүүний үнийн ерөнхий өсөлт гарсан байна. ДНБ-д уул уурхайн салбарын эзлэх хувь 22.1% -д хүрэв.

Статистикийг их наяд төгрөгөөр дараах байдлаар харуулав.

№	Үйлдвэрлэл	2014	2015	2016	2017	2018
1	Дотоодын нийт бүтээгдэхүүн	22.2	23.2	23.9	17.0	18.1
2	Уул уурхайн олборлолт	3.7	3.9	4.0	3.7	4.0
3	Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	9.3	8.7	9.9	12.9	15.7
4	Уул уурхай, олборлох аж үйлдвэр	6.4	5.9	7.9	9.4	11.2

6.3.3.5 Ажиллах хүч

Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай Засгийн Газрын тогтоол (2016)

ЗГ-аас жил бүр Монгол Улсад ажиллах гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тодорхойлсон тогтоол гаргадаг. Энэхүү тогтоол нь салбар бүрийн хувьд нийт ажилчдын хэдэн хувь нь гадаад ажилчид болон мэргэжилтнүүд байхаар зөвшөөрөгдсөн тухай жагсаалтыг хавсралтаар заасан байдаг. Энэхүү хавсралтад тусгагдаагүй салбарын хувьд уг тогтоолын дагуу нийт ажиллагчдын 5 хүртэл хувь нь гадаадын ажилчид, мэргэжилтнүүд байхаар зөвшөөрөгдсөн гэж ойлгоно.

Засгийн Газрын 2016 оны 137 дугаар тогтоолоор 2017 онд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажиллагчдын тоонд эзлэх гадаадын ажиллах хүч, мэргэжилтний хувийг хавсралтаар баталсан. ОУ-ийн салбарт 2017 онд ажиллах нийт ажилчдын тоонд гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувь өмнөх оны түвшинтэй ижил байхаар баталсан байна. Мэдээллийг дараах хүснэгтэд 2017-18 оны байдлаар тусгав.

Аж ахуйн нэгж	Уул уурхай		Газрын тос ба Байгалийн хий	
	2017	2018	2017	2018
100 сая төгрөг хүртэлх хувьцаат капитал				
15 - 30 ажилчид	10%	10%	10%	10%
31 - 50 ажилчид	20%	20%	20%	20%
51 - 100 ажилчид	20%	25%	60%	30%
100 сая болон түүнээс дээш төгрөгийн хувьцаат капитал				
Ажилчдын тоо харгалзахгүй	25%	35%	70%	50%

Монгол улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэд

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар 2018 оны 12-р сарын 31-ний байдлаар 95 орны 4.5 мянган гадаадын иргэн хөдөлмөрийн гэрээгээр ажилласан нь ажилчдын тоо 3 дахин нэмэгдэж, ажилчдын тоо 201 буюу 4.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Манай улсад 2018 онд хөдөлмөр эрхэлж байсан гадаадын иргэдийн 1.7 мянга (36.7%) нь уул уурхай, олборлох салбарт, 918 (20.4%) боловсрол, 782 (17.4%) бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ эрхэлж, 295 (6.6%) хүн боловсруулах үйлдвэрт, засаг захиргааны болон туслах үйл ажиллагаанд 182 (4.0%), барилгын салбарт 121 (2.7%), бусад салбарт 550 (12.2%). (<https://www.nso.mn/contents/4>) ажилласан байна.



Эх сурвалж: [Үндэсний Статистикийн хороо](#)

6.4 Олборлох үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл

6.4.1 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар төрийн бодлого

Байгаль орчны болон уул уурхайн нөхөн сэргээлтийг зохицуулах хууль тогтоомжийн үндсийг 1988 оноос бий болгосон бөгөөд сүүлийн жилүүдэд холбогдох хуулиудыг баталж, нэмэлт өөрчлөлт оруулсан.

Уул уурхайн ашиглалтын явцад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар дараах хуулиуд мөрдөгдөж байна.

- Газрын хэвлийн тухай хууль (1988);
- Ашигт малтмалын тухай хууль (1997, 2006);
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль (2009);
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2001, 2006, 2012);
- Бусад байгаль орчны хууль, тогтоомжууд.

Түүнчлэн эдгээр хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 30 гаруй журам, аргачлал батлан мөрдүүлж байна. Тухайлбал:

- "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал" (2015),
- "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам" (2014),
- "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам" (2014).


2014-2025 он хүртэл Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогод байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн хүрээнд дараах бодлогуудыг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

- олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийн үе шатуудад хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, хүрээлэн байгаа орчны экологийн тэнцвэрт байдлыг хангасан байх;
- төрийн өмчийн аж ахуйн нэгж нь ерөнхий гэрээлэгчийн зарчмаар ажиллаж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг хэрэгжүүлэх;
- уурхайн нөхөн сэргээлт, хаалтын стандарт, журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах;
- эрдэс баялгийн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлд газрын гүний цэнгэг усыг аль болох ашиглахгүй байх, гадаргын усыг түлхүү ашиглах, холбогдох хуульд заасны дагуу хэрэглэсэн усыг дахин ашиглах, уул уурхайн салбарын ахуйн хэрэглээнд саарал усыг ашиглах, орчин үеийн дэвшилтэт технологийг дэмжих.

6.4.2 Байгаль орчныг хамгаалах тусгай данс

БОАЖЯ-ны мэдээлснээр 2018 онд 1,411 сая төгрөгийн нөхөн сэргээлтийн зардал Байгаль хамгааллын тусгай дансанд төвлөрсөн ба буцаан олголт байгаагүй байна. 2018 оны 12 сарын 31-ний өдрийн эцсийн үлдэгдэл 14,037 сая төгрөг байна.

Он	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Орлого	22	612	565	385	942	1,216	2,014	1,545	2,273	1,027	1,317	1,102	1,411
Зарлага	-	-	21	126	1	5	16	225	1	-	-	-	-
Эцсийн үлдэгдэл	22	634	1,179	1,438	2,379	3,590	5,588	6,908	9,180	10,207	11,524	12,626	14,037



Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Нөхөн сэргээлтийн Байгаль хамгаалалтын тусгай дансанд барьцаа төлбөрөөр тэргүүлсэн 10 байгууллага /2007-2018 онд/



Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

2018 онд барьцаа дансанд төвлөрүүлсэн аж ахуйн нэгжүүд, барьцаанд төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн задаргааг хавсралт 24а-аас харна уу?

6.4.3 2018 оны уулын ажлын болон нөхөн сэргээлтийн ажлууд

АМГТГ-ын ирүүлсэн мэдээгээр 2018 онд нийт 584 га талбай газар уулын ажилд хамрагдсанаас 604 га талбай газарт нөхөн сэргээлт хийгдсэн байна. 2018 онд нөхөн сэргээлтийн нийт зардал нь 2,772.5 сая төгрөг болсон байна. Доорх хүснэгтэд олборлох салбарт хийгдсэн нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг харуулав.

Жил	Уулын ажилд хамрагдсан талбай (га)	Нөхөн сэргээлт хийгдсэн талбай (га)	Нөхөн сэргээлтийн харьцаа (%)	Нөхөн сэргээлтийн зардал (сая төг.)
Өмнөх жил	23,598.0	17,548	74%	72,266.0
2013	1,038.0	807.0	78%	7,382.0
2014	1,561.0	960.0	61%	9,212.0
2015	871.0	750.0	86%	4,019.0
2016	671.0	623.9	93%	6,369.0
2017	917.6	556.0	61%	2,560.0
2018	584.0	608.0	104%	2,772.5
Total	29,240.6	21,852.9	75%	104,580.5

Нөхөн сэргээлтийн ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн буюу огт хийгдээгүй тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн судалгаа.

Аймаг	Аж Ахуй Нэгжийн нэр	НС хийх шаардлагатай талбай /га-аар/
Архангай	Батдөлгөөн мөрөн ХХК, Монгол газар ХХК, Сэншивээмонгол ХХК, Эм Жи Эйч ХХК	483.000
Баян-Өлгий	Бүрхит корпарци ХХК, Сагсай минерал ресурс ХХК	31.500
Булган	Азаргын гол чонот ХХК, Алтандорнод монгол ХХК, Баянгол эко заамар ХХК, Батбродерс майнинг ХХК, Бэрхийн нурамт ХХК, Мон хуа энерги ХХК, Монголросцветмет ТӨҮГ, Монполимет ХХК, Ориент майнинг инвестмент ХХК, Өрмөн-Уул ХХК, Собт трейд ХХК, Төсөлч ХХК, Хос хас ХХК	1,110.430
Говь-Алтай	Анир дэлхий ХХК, Мандал алтай групп ХХК, Марко поло ХХК, Тэнгритерра ХХК	111.494
Дархан Уул	Алтан хөндий ХХК, Бичигт хад майнинг ХХК, Дархан алтан туул ХХК, ЖМЭ ХХК, Монзол ХХК, Очир үндраа ХХК, Хааны харгуй ХХК, Хөөсгөл ХХК, ЧЧТБ ХХК, Шингчан ХХК	43.000
Дорноговь	Дунфанлунма ХХК, Дуулгант эко ХХК, ЖЕМИ интернэйшнл ХХК, Их говь энерги ХХК, Казмон контакт ХХК, Коммод ХХК, Монголросцветмет ТӨҮГ, Монлаа ХХК, Мөнхболорхүрээ ХХК, Найгман орд ХХК, РЕМАР ХХК, Спот констракшн ХХК, Талст дөл ХХК, Ти Энд Пи ХХК, Тээлийн шонхор ХХК, Хөх төр, Хүрд авто ХХК, Хүдрэнт ХХК, Хүрээ дэл ХХК, Шидэт-Од ХХК, Эжүмэн ХХК, Экилешия ХХК, Ялгуун Интернэйшнл ХХК	434.400
Дорнод	Петрочайна Дачин Тамсаг ХХК, Хөөсгөл ХХК	30.000
Дундговь	Алантахь ХХК, Бигмогул коул энд энерги ХХК, Болоржонш ХХК, Бууралстоун ХХК, Геохөгжил майнинг ХХК, Дүнхли ХХК, Жун-Юань ХХК, Минг Хонг Да ХХК, Монголросцветмет ТӨҮГ, Мөнхболор хүрээ ХХК, Нун ХХК, Ньюфлюорит ХХК, Тайхар-Орд ХХК, Тарагт гөлтгөнө ХХК, Ханхастрейд ХХК, Чинхаш ХХК, Эм Си Си Эм ХХК, Эрд гео ХХК, Эрдэнгипс ХХК, Эрдэнийн сан майнинг ХХК	68.000
Завхан	Форс голд майнинг ХХК	5.600
Орхон	Отгонтэнгэр-оргил ХХК	15.000
Өмнөговь	АГМ майнинг ХХК, Болд Фа Ар да ХХК, Дун Юань ХХК, Олон овоот гоулд ХХК, Трейжа Маунтайн Интернэйшнл майнинг ХХК, Цагаан өвөлжөө ХХК, Эрдэнэс таван толгой ХХК	-
Сүхбаатар	Цайртминерал ХХК, ЭБЭ ХХК, Тэрмэнжонш ХХК, Билүүтмайнинг ХХК, Баян-Эрч ХХК, Эрдэнийн олз ХХК, Андын илч ХХК, Бадмаарагхаш ХХК, Цэгээн-Үүдэн ХХК, Энгүйтал ХХК, Талын гал ХХК, Олондавна ХХК, Соронзонтолгой ХХК, Гаррисон-Ази ХХК, Монголжүюаньли ХХК, Эф Жи Пи Эм ХХК, Сүхунголд ХХК, Молиметал ХХК, Бага өлгий ХХК, Нанжид ХХК, БХЛ ХХК, Олгойбулаг ХХК	624.437
Сэлэнгэ	Аллансголд ХХК, Баян талын өв ХХК, Бэйсикметал майнинг ХХК, Монтэнгэр ХХК, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Дунар-Од ХХК, Золотая корона ХХК, Зүбгол ХХК, Капитал авто сервис ХХК, Монгол-Анар трейд ХХК, Монлид трейд ХХК, Пентатерра ХХК, Ньюголдден кроун ХХК, Ричмөнх ХХК, Тайхаржин майнинг ХХК, Уртхошуу ХХК, Флинкмонголиа ХХК, Хишиг-Оргилуун ХХК, Хризопраза групп ХХК	-
Төв	Антрацит ХХК, Баттрипел ХХК, Баян хурай ХХК, ЖБЦБ ХХК, Зэрэгцээ алтны үйлдвэр, Нарийн гол гоулд ХХК, Нью хаппи ХХК, Өндөрбуянт холдинг ХХК, Редвулкан ХХК, Си эф си ХХК, Собт трейд ХХК, Сүлдтогтох ХХК, Такаражин ХХК, Ти жи вай ХХК, Түмэн тал ХХК, Үүргоулд ХХК, Хар занар ХХК, Цантын жим ХХК, Шижиер-алт ХХК, Эрдэнийн цахирмаа тал ХХК	252.030
Увс	Монсиб ХХК, Улаанначин ХХК, Хорикаваметалл ХХК, Цэрэнбадам	43.000
Улаанбаатар	Дабльмөнх ХХК, Ордтрейд ХХК, ОЭНДЧ ХХК, Топтоосго ХХК	22.700
Ховд	Идеал систем ХХК, ЛУВР ХХК	25.500
Нийт		3,300.091

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Нөхөн сэргээлтийн ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн буюу огт хийгдээгүй тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн судалгааны дэлгэрэнгүйг хавсралт 246-ээс харна.

Газрын хэвлийн нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллагын эрх бүхий аж ахуйн нэгжүүдийн нэрсийг хавсралт 25-аас харна уу?

6.4.4 Ашигласан усны мэдээлэл

Монголын ОУИТБС-ын 2018 оны нэгтгэл тайлантай холбоотойгоор компаниудаас ашигласан усны дэлгэрэнгүй мэдээллийг авахаар хавсралт маягтыг илгээсэн. Маягтыг бөглөсөн компанийн мэдээллийг нэгтгэж үзэхэд нийт 45,286,588 метр.куб ус ашиглахаар гэрээ хийсэн боловч 33,989,987 метр.куб буюу гэрээлсэн усны 75,1 хувийг ашигласан байна.

Үзүүлэлт	Гэрээнд заасан ашиглах усны мэдээлэл (метр.куб)	Ашигласан гадаргын усны хэмжээ (метр.куб)	Ашигласан газрын доорх усны хэмжээ (метр.куб)	Ашигласан нийт усны хэмжээ (метр.куб)	Саарал ус буюу ахуйн хэрэглээнээс үүссэн бохир ус дахин ашигласан (метр.куб)
Тоо хэмжээ	45,286,588	3,193,861	30,796,125	33,989,987	810,461

2018 онд хамгийн их усны төлбөр төлсөн топ 10 компанийг доорх хүснэгтээр харуулав.


Компанийн нэр	Ус ашигласны төлбөр мян.төг	Ашигласан усны хэмжээ м3			Саарал ус буюу ахуйн хэрэглээнээс үүссэн бохир усыг дахин ашигласан хэмжээ м3
		Гадаргын	Газрын доорх	Нийт	
Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	16,016,244		Ашигласан усны дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлээгүй		
Оюу толгой ХХК	13,439,635	-	14,695,061	14,695,061	711,351
Петрочайна дачин тамсаг ХХК	2,827,343		Ашигласан усны дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлээгүй		
Энержи ресурс ХХК	1,755,473	-	1,725,784	1,725,784	-
Багануур ХК	810,200	-	5,435,000	5,435,000	
Монголросцветмет ТӨҮГ	651,627		Ашигласан усны дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлээгүй		
Шинь шинь ХХК	558,054		635,735	635,735	-
Цайртминерал ХХК	443,057		358,722	358,722	8,471
Монголын алт мак ХХК	400,393		Ашигласан усны дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлээгүй		
Шарын гол ХК	263,766		657,000	657,000	

2018 онд засгийн газар ус ашигласны төлбөр гэж 41,214,036 мян.төгрөг хүлээн авсан ба дээрх 10 компаниуд 90.2%-г бүрдүүлж байна.

Усны гэрээгээр заасан ашиглах усны хэмжээ болон 2018 онд ашигласан усны хэмжээгээр өндөр зөрүүтэй байгаа дараах 2 харилцагчдаас тайлбарыг авсан.

1. "Оюу толгой" ХХК 20,363,973 метр.куб ашиглах усны гэрээ хийсэн боловч 5,668,912 метр.куб ус ашигласан гэж тайлагнасан ба гэрээнд заасан дүн нь урьдчилсан байдлаар гаргасан дүн бөгөөд 2018 онд бодит ашигласан нь 5,668,912 метр.куб хэрэглэсэн.
2. "Шивээ Овоо" ХК 5,734,827 метр.куб ашиглах усны гэрээ хийсэн боловч 4,082,441 метр.куб ус ашигласан гэж тайлагнасан. Үүний шалтгаан нь 2018 онд төлөвлөгөөгөөр 45 худаг ажиллуулахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 35 худаг ажилласантай холбоотой.

ОУИТБС-н 2018 оны нэгтгэл тайланд хамрагдсан компаниудын ирүүлсэн усны мэдээлэлд үндэслэн ашигт малтмалын төрлөөр нь усны хэрэглээг харууллаа.



6.4.5 Хог хаягдлын мэдээлэл

Монголын ОУИТБС-ын ОТАХ-ийн гишүүдийн саналаар хог хаягдлын мэдээллийг цахим тайлангийн маягтаар нэгтгэсэн ба дэлгэрэнгүй байдлаар 48 компани мэдээллээ ирүүлсэн. 2018 онд нийт 344,852 мян.төгрөгийг хог хаягдлын төлбөрт төвлөрүүлсэн байна.

Нийт хог хаягдлын 79.05 хувь буюу 657,006.23м³-г энгийн хог хаягдал, 10,18 хувь буюу 84,570.65м³-г аюултай хог хаягдал, 10.77 хувь буюу 89,528.85м³-г дахин боловсруулсан аюултай хог хаягдал, устгасан аюултай хог хаягдал эзэлж байна. Энэхүү төлбөр нь Улаанбаатар хот болон бусад 15 аймагт төвлөрсөн. Үүнээс Өмнөговь аймагт 289,105 мян.төгрөгийн төлбөрийг байна.

Бидэнд ирүүлсэн мэдээллээс хамгийн өндөр төлбөр төлсөн 10 компанийн мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа.

Компанийн нэр	Аймаг / Нийслэл	Аюултай хог хаягдлын хэмжээ (метр куб)	Энгийн хог хаягдлын хэмжээ (метр куб)	Нийт хог хаягдлын хэмжээ	Төлсөн төлбөр (мян.төгрөг)	Дахин боловсруулсан аюултай хог хаягдлын хэмжээ (метр куб)	Устгасан аюултай хог хаягдлын хэмжээ (метр куб)
Энержи Ресурс ХХК	Өмнөговь	1,902.00	9,606.00	11,508.00	274,095	829.19	1,092.00
Капкорп Монголиа ХХК	Өвөрхангай	0.20	8.30	8.50	16,200	200.00	-
Жавхлант-орд ХХК	Өмнөговь	-	358.00	358.00	7,160	-	-
Кожеговь ХХК	Сүхбаатар	-	-	-	6,769	-	-
Бадрах Энержи ХХК	Дорноговь	-	415.00	415.00	6,225	-	-
Буд-Ундром ХХК	Өвөрхангай	-	-	-	5,842	-	-
АУМ АЛТ ХХК	Өвөрхангай	0.30	0.10	0.40	5,000	-	-
Баян Айраг Эксплорэйшн ХХК	Завхан	160.00	1,306.00	1,466.00	2,400	72.00	-
Саусгоби Сэндс ХХК	Өмнөговь	80,554.95	8,457.29	89,012.24	2,400	70,000.00	-
Цагаан-Өвөлжөө ХХК	Өмнөговь	62.76	3,633.68	3,696.44	2,400	71.48	12.00

6.4.6 Агаарын бохирдлын төлбөр

Агаарын бохирдлын тухай хуулийн 7-р зүйлд зааснаар:

- Засгийн газар түүхий нүүрсний төлбөрийн хувь хэмжээ, үнийг кг тутамд ногдох нүүрсний үнээр тодорхойлно.
- Органик уусмал үйлдвэрлэх, импортлоход гарах төлбөрийн хэмжээг Засгийн газраас килограмм тутамд 10-30 төгрөгийн хооронд тогтооно.
- Нүүрстөрөгчийн давхар исэл ба өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрстөрөгчийн давхар ислийг ялгах түвшинг харгалзан тогтооно.
- Хотын агаарын бохирдлын гол эх үүсвэрээс агаар бохирдуулагч бодисын ялгаруулалтын төлбөрийн хэмжээг Засгийн газар килограмм тутамд 1-10 төгрөгийн хооронд тогтооно.

Засгийн газрын 2010 оны 273 дугаар тогтоолоор түүхий нүүрсэнд агаарын бохирдлын төлбөр 1кг нь 1 төгрөг байхаар тогтоосон.

2018 оны Төсвийн тухай хуульд агаарын бохирдлын төлбөрт 30 тэрбум төгрөг төсөвлөсөн. Нийт цуглуулсан орлого 42.1 тэрбум төгрөг болсон (гүйцэтгэлийн түвшин 140.4%).

7 Өмнөх жилийн зөвлөмжийн хэрэгжсэн байдал

д/д	Зөвлөмж	Хэрэгжилтийн байдал
1	Дээрх хуулиудад эрдэс баялгийн салбарын мэдээллийг ил тод болгохыг хязгаарласан заалтуудыг хүчингүй болгож, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийг даруй батлан гаргах шаардлагатай нь харагдаж байна.	Холбогдох хуулиудад өөрчлөлт оруулаагүй байгаа. Гэхдээ Засгийн газрын 2017 оны 263 дугаар тогтоолын дагуу мэдээлэл гаргах боломжтой.
2	БХГ-г ил тод болгох зөвлөмжийг өмнөх ОУИТБС-ын тайлангуудад оруулсаар ирсэн. ЗГ-аас 2015 оны 7 сарын 4-ний өдрийн 222 тоот тогтоол баталсан байдаг, ийнхүү ил тод болгохыг хязгаарласан хуулийн болоод практик хязгаарлалт байх үндэсгүй.	БХГ-үүд www.iltodgereee.mn дээр бүгдийг 2019 оны 4-р сард байршуулсан болно.
3	АМГТГ олон нийтэд ил тод болгох тусгай зөвшөөрлийн мэдээллээ цаг тухайд нь нийтэлдэг байх, түүнчлэн газрын тос болон бусад бүх ашигт малтмалын нэр төрлүүдийн хувьд ОУИТБС-ын Стандартаар наад захын байвал зохих шаардлагыг хангасан байх ба оруулсан мэдээллээ байнга шинэчилдэг байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. (энэ зөвлөмжийг өмнө жил бас өгсөн байсан)	АМГТГ нь тусгай зөвшөөрлийг ил тод болгож байна. Цаг тухайд нь шинэчлэх ажил удаашралтай байдаг.
4	Үндэсний зөвлөл, МОУИТБС-ын Ажлын албаны зүгээс АМГТГ-тай хамтран ажиллаж 2018 оны олборлох үйлдвэрлэлийн гүйцэтгэлийг тайлагнахад энэ мэдээллийг ирүүлэх шаардлагатай.	АМГТГ үйлдвэрлэлийн гүйцэтгэлийг мэдээллийг сар бүр ил олгож байгаа ч, төдийлэн тодорхой гаргахгүй байгаа тал бий.
5	Тавьсан шаардлагын дагуу зохих гарын үсэг бүхий хариуцлагын захидал болон аудитын тайланг ирүүлээгүй төрийн байгууллагууд, ТӨААН-үүдтэй Үндэсний зөвлөл хариуцлага тооцдог байх, ирүүлээгүй баталгаажуулалтыг МОУИТБС-ын ажлын албанд даруй ирүүлэхийг шаардах ба энэ талаар дараагийн ОУИТБС тайланд тусгахыг зөвлөж байна. МОУИТБС-ын Ажлын алба цахим тайлагналын системийг ашиглаагүй компаниуд, шаардсан баталгаажуулалтын бичиг баримтыг гаргаж өгөөгүй компаниудад хариуцлага тооцож, энэ асуудлын ач холбогдлыг таниулах ойлгуулах замаар дараагийн ОУИТБС тайланд нийцлийн тал дээр ахиц гаргаж ажиллахыг зөвлөж байна.	Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэг УУХҮЯ дээр ажиллаж байна. Хуульд энэ асуудлыг оруулна гэж үзэж байна.
6	Үндэсний зөвлөл болон ОТАХ-ийн зүгээс асуудлыг нааштай шийдвэрлэхэд зохих дэмжлэг үзүүлэн, ОУИТБС-ын эрх зүйн үндэслэлийг ГЕГ-ын удирдлагад ойлгуулж, анхны тайлангаа алдаа багатай тайлагнахад тус нэмэр болохыг зөвлөж байна.	ГЕГ-ын хандлага бага нааштай байдлаар өөрчлөгдөж байгаа гэж үзэх үндэстэй байна.
7	Жил бүр ОУИТБС-ын стандартад шаардсан ямар 'орлогын бүс мэдээллийг' ямар байгууллага, ямар хэмжээнд ил тод болгохыг МОУИТБС-ын Ажлын албаны зөвлөснөөр ОТАХ-ээс зааж өгч шийдвэрлэхийг зөвлөж байна. Холбогдох төрийн байгууллагууд өөрсдөө нийтэд байнга мэдээлдэг тайландаа оруулаагүй бол эдгээр мэдээллийг зайлшгүй дараагийн ОУИТБС тайланд бэлтгэж ирүүлэхийг шаардах нь зүйтэй.	Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэг УУХҮЯ дээр ажиллаж байна. Хуулинд энэ асуудлыг оруулж, шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.
8	Бенефициар эздийг ил тод болгох талаар Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуульд тодорхой оруулж, бусад хуулиудад заасан хязгаарлалтуудыг хүчингүй болгож, хуулиудын уялдаа холбоог сайжруулах замаар ил тод байдлыг хангах асуудлыг шийдвэрлэхийг зөвлөж байна.	Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэг УУХҮЯ дээр ажиллаж байна. Хуульд энэ асуудлыг оруулна гэж үзэж байна.
9	ҮАГ гэх зэргийн эрх бүхий байгууллагаас ТӨААН-үүдийн зөрчилтэй дүгнэлтийн асуудлыг цааш тодруулж, тэдэнд зөрчилтэй асуудлуудаа засаж сайжруулах ажлыг даалгах, цаашлаад ялангуяа "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн хувьцааны үнэлгээтэй холбоотой материаллаг буруу илэрхийллийг шалгаж, санхүүгийн тайлангийн үнэн зөв эсэхэд өөрсдийн дүгнэлтийг өгөх нь зүйтэй юм.	ТӨААН-үүдийн аудитын тайланг www.audit.mn цахим хуудасны Аудитын тайлангийн хэсгээс авч болно.

д/д	Зөвлөмж	Хэрэгжилтийн байдал
10	Олборлох салбарын бүх ТӨААН-ийн аудитлагдсан иж бүрэн санхүүгийн тайланг цахимаар нийтэд мэдээлэх буюу тодруулбал тухайн ТӨААН-ийн өөрийн вэб хуудсанд болон УАГ, ОУИТБС буюу АМГТГ-ын вэб хуудсанд тус тус нийтлэхийг зөвлөж байна.	ТӨААН-уудын аудитын тайланг www.audit.mn цахим хуудасны Аудитын тайлангийн хэсгээс авч болно.
11	Мэдээллийг төслийн түвшинд задаргаатай гаргуулж авахын тулд МОУИТБС-ын Ажлын албанаас холбогдох маягтуудыг цахим тайлагналын системд оруулсан байх ёстой.	Холбогдох маягтыг боловсруулан, Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлөөр батлуулсны дараа Үндэсний статистикийн хороонд танилцуулан батлуулахаар 2020 оны ажлын төлөвлөгөөнд суулган ажиллаж байна.
12	ОТАХ-ын зүгээс АМГТГ-т энэ асуудлыг цааш тодруулах хүсэлтийг тавьж ажиллах нь зүйтэй. Нөгөө талаас Сангийн яам нь тухайн компанийн санхүүгийн тайлангаа Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн эсэхийг шалгаж, тавьсан шаардлагыг биелүүлээгүй шалтгаан үндэслэлийг Ажлын хэсэгт танилцуулах нь зүйтэй. Петровичайна дачин тамсаг компанийн ОУИТБС-д ирүүлсэн дүн материаллаг хэмжээтэй байгаа учир эдгээр авсан арга хэмжээний үр дүнг ОТАХ-д ирүүлж байж ОУИТБС-ын тайлагнал зарчмын дагуу зөв зүйтэй явагдах юм. Түүнчлэн ОТАХ-ын зүгээс ашигт малтмал, газрын тосны салбарын компаниудын санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг хангахад төр хэрхэн оролцох тухай бодлого боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. ЗГ-ын 2012 оны 222 дугаар тогтоолоор ОУИТБС-ын зорилгоор мэдээллийн хэрэгцээ шаардлага байгаа тул холбогдох зарим хуулиар хийсэн байсан нууц хадгалах тухай хязгаарлалтуудыг хүчингүй болгосон байдаг. Гэвч төрийн байгууллагууд энэ талаар бүрэн мэдээлэлгүйгээс болж уул уурхайн компаниудын санхүүгийн тайлан бүрэн ил тод болж чадахгүй байна.	ОУИТБС-ын хэрэгжилт санхүүжилтгүй болсноос хэрэгжүүлэх олон ажлыг хийж чадаагүй байна. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн хүрээнд эдгээр асуудлуудыг шийдвэрлэх боломж боломжтой. 2020 оны Ажлын төлөвлөгөөнд санхүүжилтийн асуудлыг цэгцэлснээр зарим асуудлыг шийдвэрлэх замаар тодорхой болгох боломжтой болно гэж үзэж байна.

8 МОУИТБС-ын тайлагнал, түүний хэрэгжилтэд өгөх зөвлөмж

Д/д	Зөвлөмж	Дэлгэрэнгүй
1	Жендерийн тэгш байдал	2019 оны ОУИТБС-ын стандартын шаардлага 1.4 а) ii-ийн дагуу олон талын оролцогчдын бүлэг хүйсийн тэнцвэрт байдлыг хангахын тулд төлөөлөлдөө хүйсийн тэнцвэрийг харгалзан үзэх шаардлагатай гэж заасан. Одоогоор ОУИТБС-ын олон талт оролцогчдын бүлэг нь 34 гишүүнээс бүрдэх ба үүнээс 11 нь эмэгтэй, 23 нь эрэгтэй юм. Олон талт оролцогчдын бүлгийн бүрэлдэхүүнд жендерийн тэнцвэрийг хангахын тулд оролцогч тал бүрийн төлөөлөлтэй хэлэлцүүлэг хийж, арга хэмжээ авах талаар зөвлөж байна.
2	Дэд зөвлөлийн идэвхгүй байдал	ОУИТБС-ын үндэсний зөвлөл 2013 оны 12-р сард 'ОУИТБС-ыг орон нутагт хэрэгжүүлэх дэд зөвлөлийн дүрэм' -ийг баталсан. Энэхүү дүрмээр ОУИТБС-ын дэд зөвлөлийг хэрхэн байгуулах талаар удирдамжийг оруулсан. Үүнд дэд зөвлөлийн зохион байгуулалт, бүтэц, үйл ажиллагааны хэлбэр, удирдлага, тайлагнал, санхүүжилт болон бусад асуудлын талаарх заалтууд орсон. Нийт 22 салбар зөвлөл байгуулагдсан (21 аймагт, Улаанбаатар хотод). Гэвч, ОУИТБС-ын тайланг нийтлэх хүртэл дэд зөвлөлүүд нь аливаа уулзалт, үйл ажиллагаа зохион байгуулаагүй. Орон нутгийн түвшинд ОУИТБС-ын үйл явцыг хэлэлцэх хурал, зөвлөгөөн зохион байгуулаагүй гэсэн мэдээлэл байна. Энэ нь хоёр хүчин зүйлээс шалтгаалж байгаа юм. хүний нөөц, санхүүгийн дэмжлэг муу байгаагаас боловч Засгийн газраас дэд зөвлөлийн үйл ажиллагаанд санхүүжилт хуваарилахаар холбогдох яамнаас тушаал гаргасан. ОУИТБС-ын талаарх ойлголттой хүн дэд зөвлөлөөс гарсантай холбоотой юм. ОУИТБС-ын үйл ажиллагаа, зөвлөгөөнүүдэд өмнө нь оролцож байсан, ОУИТБС-ын ажилд оролцсон салбар зөвлөлийн ажилтнууд албан тушаалаасаа гарсан. <i>Тус зөвлөлийн дүрмийг хэрэгжүүлэх боломжийг олгохын тулд илүү практикт тулгуурлан сайжруулах. Олон талт оролцогчдын бүлэг нь дэд зөвлөлийн санхүүжилттэй холбоотой Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авах ёстой.</i>
3	Мэдээллийн ил тод байдал	Газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээний мэдээллийг ил тод байгаа боловч зарим компаниудын гэрээний мэдээлэл байхгүй байна. Иймд БХГэрээ болон зарим зүйл заалт хараахан олон нийтэд ил тод болоогүй байна. Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ТУЗ-ийн гишүүдийн нэр, ажил албан тушаал, ажлын хаяг зэрэг мэдээллийг Эрдэнэс МГЛ ХК болон бусад компани гэсэн ангиллаар гаргаж, тайланд тусгах. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал, үзүүлсэн хөнгөлөлт, томилолтын зардлын охин компани тус бүрээр гаргаж, тайланд тусгах.
4	Бенефициар эздийн мэдээлэл	Бенефициар эздийн мэдээллийг жил бүр зөвхөн тохируулгын хүрээнд хамрагдсан компаниудын хувьд ил тод болгодог. Энэхүү үйл явцыг тус салбарт үйл ажиллагаа явуулж буй бүх компаниудыг оролцуулан илүү өргөн хүрээнд авч үзэх ёстой. ОУИТБС-ын стандартын 2.5-д заасны дагуу ОУИТБС-ын хэрэгжүүлэгч орнууд хайгуул, олборлолт, газрын тос, байгалийн хийн олборлолт эрхлэх тусгай зөвшөөрөл, гэрээнд оролцох эрх бүхий өргөдөл гаргасан аж ахуйн нэгж, байгууллагуудын бенефициар эздийн бүртгэлийг олон нийтэд нээлттэй байлгах ёстой.
5	Засгийн газрын байгууллагуудын хоорондын мэдээллийн зөрүүтэй байдал	ОУИТБС-ын тайланд тусгах үндсэн мэдээллийг цуглуулах явцад хэд хэдэн засгийн газрын агентлагуудын цахим хуудсанд нийтэлсэн статистик тоо баримтууд хоорондоо нийцэхгүй байсан. Уул уурхайн салбарын тусгай зөвшөөрөл, үйлдвэрлэл, экспортын орлого, орлоготой холбоотой статистик жишээ нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Үндэсний статистикийн хороо болон Сангийн яам нарын хоорондын мэдээлэл ялгаатай байна. <i>Олборлох салбартай холбоотой статистик мэдээллийг эхлээд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд төвлөрүүлэх хэрэгтэй. Эдгээр статистик мэдээллийг хянаж, шалгасны дараа бусад засгийн газрын байгууллагуудад өгөх ёстой.</i> Мөн Бичил уул уурхайн нэгдсэн дээвэр холбоо болон Ашигт малтмал газрын тосны газраас гаргасан бичил уурхайчдын тоо хэмжээ, тушаасан алтны хэмжээ зэргийг мэдээлэл нь хоорондоо зөрүүтэй байна.
6	Засгийн газрын байгууллагууд болон компаниудын мэдээллийн иж	Гаалийн ерөнхий газрын цахим тайлагналд ихэнх компанийн мэдээг буруу шивж оруулсан байсан. Мөн зарим аймгууд цахим тайлагналын систем тайлангаа шивээгүй, зарим аймгууд нь ихэнх татварын урсгалуудыг дутуу шивсэн тохиолдлууд байсан. Орон нутгийн холбогдох төрийн захиргааны байгууллагуудын хүлээн авсан хандивын мэдээллийг иж бүрэн, үнэн зөв цахим системд тайлагнах.

Д/д	Зөвлөмж	Дэлгэрэнгүй
	бүрэн, гүйцэд тайлагнах	Аймаг болон дүүргүүдээс анхны зөрүүтэй холбоотой мэдээлэл хугацаа хэтэрч ирсэн. Нэгтгэл тайланд толилуулагдах нэмэлт мэдээллийг холбогдох төрийн байгууллагаас ирүүлэхгүй байх.
7	Тайлангийн маягт сайжруулах	Тайланд хамрагдаж байгаа орлогын үрсгалуудыг төсөл (тусгай зөвшөөрөл) тус бүрээр ялган тайлагнах. Ажилчдын мэдээллийг дэлгэрэнгүй болгох (ажилчдын насны талаарх мэдээлэл нэмэлтээр оруулах). Баяжуулах, боловсруулах үйлдвэрлэлийн дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн маягтад тусгаж оруулах. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллах гэрээ байгуулсан оператор, туслан гүйцэтгэгч болон ханган нийлүүлэгч компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг оруулах
8	Цахим тайлангийн систем	Засгийн газрын болон компаниудаас үндсэн болон нэмэлт мэдээллийн маягтыг цахим системд оруулах. Ингэснээр нэгтгэл тайлангийн ажлын мэдээлэл цуглуулах болон нэгтгэх ажилд цаг хугацаа бага зарцуулна. Ил тод нээлттэй байх мэдээллийг цахим тайлагналын систем болон, албан ёсны веб сайтдаа байршуулаагүйгээс хамаарч тухайн албан газрууд руу албан бичиг бичиж мэдээлэл хүсэх, хариу ирэхгүй байх зэрэг хүндрэлүүд гарч байна. ОУИТБС-ын цахим системд оруулах мэдээллийг Засгийн газрын холбогдох байгууллагуудын гаргаж буй мэдээлэлтэй ижил байдлаар оруулж байх.
9	Ил тод гэрээ сайтад гэрээний мэдээллийг бүрэн оруулах	Iltodgereee.mn сайтад байршуулсан гэрээнүүдийн хувьд зарим үнийн дүнгээр илэрхийлсэн зүйл заалтуудыг харагдахгүй байдлаар оруулсан байгаа нь гэрээ 100 хувь ил тод болсон гэж үзэх нөхцөл бүрдэхгүй байна. Иймээс iltodgereee.mn сайтад гэрээний бүх нөхцөлийг иж бүрэн, ямар нэгэн зүйл заалт хасахгүй оруулж байх.